

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫН ДЭЛХИЙН ХӨТӨЛБӨР

ДӨРӨВ, ТАВ ДАХЬ ҮЕ ШАТНЫ

ТӨЛӨВЛӨГӨӨ



Зохиогчийн эрх © НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)

HR/PUB/21/1

eISBN: 978-92-1-005708-0

Энэхүү бүтээлийг НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар (ХЭДКГ), НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Залуучуудын асуудал хариуцсан төлөөлөгчийн газар (ЕНБДЗАХТГ) болон НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО) хамтран хэвлүүлэв.

Энэхүү бүтээлийг Атрибут-Адил хуваалцах 3.0 ОУБХ СС BY-SA 3.0 IGO, лицензийн хүрээнд нээлттэйгээр ашиглах боломжтой.

SA лиценз: <https://creativecommons.org/licenses/by-sa/3.0/igo/>.

Хэвлэн нийтлэгчид нь өөрсдийн хэвлэлийн хувилбарт байгууллагуудын тэмдгийг ашиглахгүй бөгөөд хавтасны загварыг шинээр боловсруулна.

Орчуулгад дараах зүйлсийг заавал тусгасан байх шаардлагатай:

Энэхүү бүтээл нь хэвлэн нийтлэгч бүрэн хариуцлага хүлээж буй албан бус орчуулга болно.

Энэхүү хэвлэлд ашигласан нэр томъёо, мэдээллийн агуулга нь аль нэг улсын, газар нутаг, хот, бүс нутгийн хууль эрх зүйн байдал, удирдлагын талаар, эсвэл тэдгээрийн хил хязгаар, зааг тогтоох асуудлаар НҮБ-ын Ерөнхий Нарийн Бичгийн Дарга, ХЭДКГ, ЕНБДЗАХТГ, ЮНЕСКО-ын зүгээс ямар нэгэн байр суурь илэрхийлэх утгыг агуулаагүй болно.

Энэхүү хэвлэлд тусгагдсан санаа, үзэл бодол нь зохиогчдынх бөгөөд ЮНЕСКО-гийн албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй, мөн байгууллагад ямар нэгэн үүрэг хүлээлгэхгүй.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын баримт бичиг дэх бэлгэ тэмдгүүд нь том үсгүүд болон тоон тэмдэглэлийн хослолоос бүрддэг. Ийм тэмдгүүд нь тухайн баримт бичиг НҮБ-ын баримт бичигт хамаарахыг илтгэнэ.

Хавтасны зургийн эх сурвалж (энэхүү хэвлэлд бүхэлд нь ашигласан): Adobe Stock, лавлах дугаар 189737569, зохиогч - Жэйкоб Лунд.

Хүний эрхийн боловсролын үндэсний чадавхыг дээшлүүлэх, сайн туршлага солилцож, бодлогын зөвлөмж боловсруулах зорилгоор Монголын Эмнести Интернэшнлээс санаачлан ХЭҮК, Боловсролын яам, МУИС - Хууль зүйн сургууль, Отгонтэнгэр их сургууль, Монголын хуульчдын холбоо, Хууль зүйн клиник сургалтын Ахиц нийгэмлэг зэрэг байгууллагуудтай хамтран 5 дахь удаагаа зохион байгуулж буй "Хүний эрхийн боловсролын симпозиум 2025"-д зориулж хэвлэв.

Өмнөх үг

КОВИД-19 цар тахал дэлхий нийтэд гүнзгий сорилт болсон. Энэ нь эв санааны нэгдэл, хүн төрөлхтний нийтлэг ойлголтыг бэхжүүлэх явдлыг өдөөхийн зэрэгцээ ялгаварлан гадуурхалт, арьс үндсээр ялгаварлах, үзэн ядсан үг хэллэг зэрэг хүний эрхийн зөрчлүүдийг ноцтой түвшинд нэмэгдэхэд хүргэсэн.

Дэлхий даяар 1.8 тэрбум залуучууд цар тахлын нөлөөлөлд өртөөд байгаа энэ цаг үед илүү эрх тэгш, тогтвортой, хүртээмжтэй, хямралыг даван туулах чадвартай нийгэм, эдийн засгийг бүрдүүлэх баталгааг хангах хүний эрхийн боловсролын ач холбогдол улам бүр нэмэгдэж байна. Энэ нь улс орнуудад Ковидын дараа “илүү сайн сэргэх” суурийг тавихад тусална.

Мөн залуучуудыг зөвхөн үр шим хүртэгч хэмээн үздэг хэвшмэл ойлголтоос татгалзаж, тэднийг бодит “өөрчлөлтийн эзэд” хэмээн хүлээн зөвшөөрөх цаг болсон. Шударга, тэгш, энх тайван ирээдүйн төлөө залуучуудыг дэмжин, идэвхтэй оролцоог хангаж хамтран ажиллах нь туйлын чухал юм.

Залуучуудад зориулсан албан болон албан бус хүний эрхийн боловсрол нь хүн төрөлхтний нийтлэг ойлголтыг бэхжүүлж, хүн бүр нэр төр, хүндлэл, шударга ёсыг эрх тэгш хүртэх эрхтэй гэсэн хамтын ойлголтыг төлөвшүүлдэг.

Энэ нь залуучуудыг идэвхтэй иргэний үүргээ биелүүлэх, өөрсдийн болон бусдын эрхийг хамгаалах арга хэмжээ авах, нийтийн үйл хэрэг болон ардчилсан шийдвэр гаргах үйл явцад утга учиртай оролцоог нэмэгдүүлдэг.

Үүнийг хүлээн зөвшөөрч Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн улс орнууд үндэсний түвшинд залуучуудад чиглэсэн хүний эрхийн боловсролыг сайжруулах зорилгоор Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн дөрөв дэх үе шатыг (2020–2024) эхлүүлсэн.

Энэхүү чиглэл нь Тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030-ийн хэрэгжилтэд, ялангуяа боловсролын зорилгыг тусгасан Зорилго 4 болон 4.7 дахь зорилтот түвшинд үнэтэй хувь нэмэр оруулдаг.

Хөтөлбөрийн дөрөв дэх үе шатны төлөвлөгөөг батлах үед, гишүүн улсууд залуучууд болон залуучуудаар удирдуулсан, залуучуудад чиглэсэн байгууллагуудыг бүх шатанд гол түншээр оролцуулах үүрэг хүлээсэн.

Залуучууд нь үе тэнгийнхэндээ зориулсан хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны үндсэн бүтээгч, төлөвлөгчид байх ёстой бөгөөд тэдний оролцоо, манлайллыг дэмжих орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай.

Мөн хэнийг ч хөгжлийн гадна орхигдуулахгүй байх зарчмын хүрээнд хүний эрхийн боловсролын бодлого, хөтөлбөрүүд нь гадуурхалтад өртөх эсвэл эмзэг нөхцөл байдалд байгаа залуучуудыг эн тэргүүнд анхаарах ёстой.

“Залуучууд 2030: Залуучуудын төлөө, залуучуудтай хамт” гэх НҮБ-ын Залуучуудын стратегид НҮБ-ыг залуучуудын хүний эрхийн боловсрол, дэлхийн иргэншил, тогтвортой хөгжлийн боловсролыг дэмжин ажиллах үүрэгтэй болохыг тодорхойлсон. Энэ хүрээнд залуучуудын дунд иргэний ухамсар ба оролцоо, сайн дурын үйл ажиллагаа, энх тайвны болон хүчирхийллийн бус соёлыг төлөвшүүлэхийг зорьдог.

Манай байгууллага энэ зорилгыг хэрэгжүүлэхэд гишүүн улсуудын бүх хүчин чармайлтыг дэмжин, хамтран ажиллах болно.

Одри Азулэ

*Ерөнхий захирал
Нэгдсэн Үндэстний
Байгууллагын Боловсрол,
Шинжлэх Ухаан, Соёлын
Байгууллага (ЮНЕСКО)*

Жаяатма Викраманаяке

*Нэгдсэн Үндэстний
Байгууллагын Ерөнхий нарийн
бичгийн даргын Залуучуудын
асуудал хариуцсан төлөөлөгч*

Мишель Бачелет

*Нэгдсэн Үндэстний
Байгууллагын Хүний эрхийн
дээд комиссар*

Агуулга

Өмнөх үг	1
2020–2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний товч	5
Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн дөрөв дэх үе шатны (2020–2024) төлөвлөгөө	17
I. Танилцуулга	18
A. Хүний эрхийн боловсролын тодорхойлолт	18
B. Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр болон холбогдох санаачилгууд	19
C. Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн зорилго	20
D. Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны зарчим	21
II. Хүний эрхийн боловсролоор дамжуулан залуучуудыг чадавхжуулах нь: Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн дөрөв дэх үе шатны (2020–2024) төлөвлөгөө	22
A. Хамрах хүрээ	22
B. Үндэслэл	23
C. Тодорхой зорилтууд	26
D. Бүрэлдэхүүн хэсгүүд	27
E. Үндэсний хэрэгжилтийн үйл явц	38
F. Олон улсын хамтын ажиллагаа	42
Хавсралт	
Хүний Эрхийн Зөвлөлийн 2019 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 42/7 дугаар тогтоолоор Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн дөрөв дэх үе шатны төлөвлөгөөг батлав.	45
Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр	
Үйл ажиллагааны тав дахь үе шатны (2025–2029) төлөвлөгөө	49
I. Танилцуулга	50
II. Хамрах хүрээ	50
III. Үндэслэл	51
IV. Тодорхой зорилтууд	55
V. Бүрэлдэхүүн хэсгүүд	56

2020–2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОВЧ

Энэ хэсэг нь Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн дөрөв дэх үе шатны (2020-2024) төлөвлөгөөг нэгтгэн дүгнэсэн болно.

Тус төлөвлөгөө нь өмнөх үе шатуудын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тулгуурлан, улс орнууд болон бусад оролцогч тал залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролыг хэрэгжүүлэх үйл явцыг бэхжүүлэхэд авч хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүдийг онцлов.

Хүний Эрхийн Зөвлөл 2019 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр 42/7 дугаар тогтоолоор энэхүү төлөвлөгөөг баталсан.

I. Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр (2005–үргэлжилж буй)

Хүний эрхийн боловсрол гэж юу вэ?

Хүний эрхийн боловсрол гэдэг нь хүний эрхийн түгээмэл соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн боловсрол, сургалт, мэдээллийг хэлнэ.

Хүний эрхийн боловсролыг үр дүнтэй олгосноор хүний эрх, түүнийг хамгаалах механизмуудын талаарх мэдлэгийг нь нэмэгдүүлэхээс гадна, суралцагчдыг өдөр тутмын амьдралдаа хүний эрхийг дэмжих, хамгаалах, хэрэгжүүлэхүйц үйл ажиллагаа явуулах ур чадвар, хандлагыг хөгжүүлдэг.

Хүний эрхийн боловсрол нь хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх үүрэг бүхий этгээдэд энэхүү үүргээ биелүүлэх чадавхыг сайжруулж өгдөг.

Хүний эрхийн боловсрол нь хүндлэл, тэгш байдал, шударга ёс зэрэг хүний эрхийн үндсэн үнэт зүйлс болон хүний эрхийн салшгүй байдал, харилцан хамаарал, хоорондын уялдаа холбоо, хуваагдашгүй шинж, түгээмэл чанар дээр үндэслэдэг.

Боловсролын үйл ажиллагаа нь хүний эрхийг суралцагчийн бодит амьдралын туршлага, нөхцөлтэй холбосон практик, суралцагч төвтэй байх ёстой.

Боловсролын эдгээр үйл ажиллагаа нь суралцагчдыг өөрсдийн эрхээ таньж мэдэх, шаардах, мөн асуудалд хүний эрхийн мэдрэмжтэй шийдэл эрэлхийлэх чадвартай болгох ёстой.

Сургалтын агуулга төдийгүй сургалтын арга барил нь хүний эрхийн үнэт зүйлсийг тусгах, суралцагчийн оролцоог дэмжих, хүний эрхийг өдөр тутамд хэрэгжүүлдэг суралцах орчныг хөгжүүлэхэд чиглэх ёстой.

Яагаад хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр гэж?

2004 оны 12 сарын 10-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблей 59/113 тогтоол баталж, бүх салбарт хүний эрхийн боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтийг урагшлуулах зорилгоор Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийг тунхагласан.

НҮБ-ын Хүний эрхийн боловсролын арван (1995–2004) үеэр тавигдсан суурийг үндэслэн, Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр нь хүний эрхийн боловсрол урт хугацаанд үр нөлөө үзүүлдэг болохыг олон улсын хамтын нийгэмлэг улам бүр хүлээн зөвшөөрч байгааг илэрхийлсэн.

Хүний эрхийн боловсрол нь хүний нэр төр, эрх тэгш байдлыг хүндэтгэх, тогтвортой хөгжил, ардчилсан шийдвэр гаргах үйл явцад оролцохыг дэмжих замаар энх тайвныг дэмжиж, хүчирхийлэл, зөрчлөөс урт хугацаанд урьдчилан сэргийлэхэд хувь нэмэр оруулдаг.

Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн зорилго нь хүний эрхийн боловсролын үндсэн зарчим, арга зүйн талаарх бүх нийтийн ойлголтыг хөхиүлэн дэмжих, үйл ажиллагааны тодорхой хүрээ тогтоох, олон улсын түвшнээс орон нутгийн түвшин хүртэлх түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд оршино.

Түүнчлэн энэхүү хөтөлбөр нь НҮБ-ын “Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай тунхаглал” (2011)-ын зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн практик зөвлөмжийг улс орнууд болон бусад оролцогч талуудад өгдөг.

Хүний эрхийн боловсролын арван (1995–2004) нь хугацааны хувьд хязгаарлагдмал байсан бол Дэлхийн хөтөлбөр нь хугацааны хязгааргүй, үе шаттайгаар хэрэгждэг онцлогтой.

Нэгдүгээр үе шат (2005–2009): Хүний эрхийн боловсролыг ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгах;

Хоёрдугаар үе шат (2010–2014): Дээд боловсрол дахь хүний эрхийн боловсрол болон төрийн албан хаагчид, хууль сахиулах байгууллагын ажилтнууд, цэргийн албан хаагчдад зориулсан хүний эрхийг сургалтад анхаарах;

Гуравдугаар үе шат (2015–2019): Эхний хоёр үе шатны хэрэгжилтийг бэхжүүлэхийн зэрэгцээ хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүд, сэтгүүлчдэд зориулсан хүний эрхийн сургалтыг дэмжих зорилготой байв.¹

¹ Нэг, хоёр, гуравдугаар үе шатны талаар илүү мэдээллийг дараах холбоосоор үзэх боломжтой www.ohchr.org/EN/Issues/Education/Training/Pages/Programme.aspx.

II. Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн дөрөв дэх үе шат (2020–2024): Хүний эрхийн боловсролоор дамжуулан залуучуудыг чадавхжуулах

Эхний жилүүдээс эхлэн НҮБ-ын гишүүн улс орнууд залуучуудын хүний эрхийн боловсролын чухал ач холбогдлыг онцлон тэмдэглэж, дэлхийн өнөөгийн сорилтуудаас урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх амин чухал стратеги хэмээн үзэх нь улам бүр нэмэгдэж байна.

Мөн залуучуудыг хүний эрх эдлэгч, түүний хэрэгжилтийг хангах, тогтвортой хөгжилд хүрэх, энх тайвныг бэхжүүлэх, хүчирхийлэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл явцад гол оролцогч болохыг онцлон тэмдэглэсэн.

Эдгээр ойлголтод тулгуурлан хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн дөрөв дэх үе шатны (2020–2024) төлөвлөгөө нь тухайн улсын нөхцөл байдалд нийцсэн, залуучуудад чиглэсэн хүний эрхийн боловсролын цогц стратегийг боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Энэхүү стратеги нь 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр, тэр дундаа хүртээмжтэй, чанартай боловсролыг дэмжих 4 дүгээр зорилгыг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулахыг зорьдог.

Хүний эрхийн боловсрол нь залуучууд өөрсдийн үүрэг хариуцлагыг ухамсарлаж, идэвхтэй иргэний хувиар хариуцлагатай байж, өөрийн болон бусдын эрхийг хамгаалж, нийгмийн үйл хэрэгт идэвхийлэн оролцох, ардчилсан шийдвэр гаргах үйл явцад үр нөлөөтэй оролцох боломжийг олгоход үндэслэнэ.

Өөрөөр хэлбэл, хүний эрхийн боловсрол нь залуучуудыг чадавхжуулах, хөгжүүлэх, нийгмийн оролцоог хангах үндсэн түлхүүр бөгөөд энх тайван, шударга, тогтвортой ирээдүйг цогцлоох чухал нөхцөл болдог.

Төрийн болон төрийн бус байгууллагуудын мэргэжилтнүүд, практикийн ажилтнууд тэр дундаа залуучуудын байгууллага, сүлжээний оролцоотойгоор боловсруулагдсан энэхүү төлөвлөгөөнд залуучуудад үр нөлөөтэй хүний эрхийн боловсрол олгоход шаардлагатай дөрвөн үндсэн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлсон.

1. Бодлого ба холбогдох хэрэгжилтийн арга хэмжээ

Залуучуудын оролцоотойгоор албан боловсролын тогтолцоонд хүний эрх болон хүний эрхийн боловсролыг тусган хэрэгжүүлэх баталгааг хангах, мөн албан бус боловсролын хүрээнд хүний эрхийн боловсрол олгох чиглэлээр иргэний нийгмийн байгууллагууд - түүний дотор залуучуудын бүлгүүд болон залуучуудаар удирдуулсан байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих бодлого, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай.

Бодлого нь хэрэгжилтийн болон хяналт-шинжилгээний механизмуудтай уялдсан байх шаардлагатай бөгөөд холбогдох олон улсын үүрэг, амлалтыг биелүүлэхэд чиглэнэ.

Залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролтой холбоотой, эсхүл уг чиглэлийг хамарсан үндэсний хэмжээний бүх бодлого, стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө - тухайлбал залуучууд, боловсрол, хүний эрх, жендэрийн тэгш байдал, дэлхийн иргэншил, тогтвортой хөгжил, энх тайван, аюулгүй байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн эрх зүйн шударга ёс, хэт туйлширсан түрэмгий үзлээс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх, арьс үндсээр ялгаварлан гадуурхах, гаднынхныг үзэн ядах үзэл болон түүнийг дагалдсан үл тэвчих хандлагатай тэмцэх зэрэг үндэсний санаачилгууд - нь уялдаа холбоо, харилцан дэмжлэгтэй байх ёстой.

2. Сургах ба сурах үйл явц, арга хэрэгслүүд

Хүний эрхийн боловсрол нь залуучуудад өөрсдийн эрхийг эдлэх, бусдын эрхийг хүндэтгэн, хамгаалах мэдлэг, ур чадвар, хандлагыг төлөвшүүлж, чадавхжуулахад чиглэдэг.

- **МЭДЛЭГ**-ийн хүрээнд залуучууд дараах асуудлаар хэлэлцэх чадвартай:
 - Хүний эрхийн түүх
 - Хүний эрх, энх тайван, тогтвортой хөгжлийн харилцан уялдаа холбоо
 - Хүний эрхийн зарчмууд
 - Залуучуудын өдөр тутмын амьдрал дахь хүний эрхийн гүйцэтгэх үүрэг болон тэдэнд онцгой хамаарал бүхий хүний эрхийн асуудлууд
 - Улс орнуудын хүний эрхийн үүрэг хариуцлага, мөн орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон олон улсын түвшинд ашиглах боломжтой хамгааллын механизм, гомдол гаргах журам
 - Олон улсын хүний эрх болон холбогдох олон улсын эрх зүй
 - Дэлхийн тулгамдсан асуудлууд болон тэдгээрийн хүний эрхтэй уялдаа холбоо
 - Одоогийн болон түүхэн хүний эрхийн асуудал, хөдөлгөөнүүд
- **УР ЧАДВАР**-ын хүрээнд залуучууд дараах чадварыг эзэмших:
 - Түүхэн болон өнөөгийн асуудлыг хүний эрхийн үүднээс дүн шинжилгээ хийх
 - Өдөр тутмын амьдралд гарч буй хүний эрхийн асуудлуудыг таних
 - Хүний эрхийн зөрчлүүд, тэдгээрийн уг шалтгаан, үр дагаврыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх
 - Хүний эрхийн талаарх мэдээлэл болон эх сурвалжуудыг олж авах
 - Зөрчлийг шийдвэрлэхэд хүний эрхийн зарчмуудыг хэрэглэх

- Засгийн газрын олон түвшний шийдвэр гаргах үйл явцад оролцох, манлайлах, нөлөөлөх
 - Хүний эрхийг хамгаалах чиглэлээр бусадтай хамтран ажиллах, сүлжээ үүсгэх
 - Хүний эрхтэй холбоотой бодлого, хууль тогтоомжийг өөрчлөх санал боловсруулах, хамгаалах
 - Хүний эрхийг хамгаалах, дэмжих үйл ажиллагаа төлөвлөх, хэрэгжүүлэх
 - Нийгмийн цахим сүлжээн дэх дээрэлхэл, үзэн ядсан үг хэллэг, туйлширсан түрэмгий үзэл, хууран мэхлэх зорилготой этгээдүүдтэй харилцах зэрэг эрсдэлийг харгалзан цахим болон цахим бус үзэн ядалт, ялгаварлан гадуурхалттай тэмцэх
 - Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил хүний эрхэд хэрхэн нөлөөлж байгаад дүн шинжилгээ хийх
- **ХАНДЛАГА**-ын хүрээнд залуучууд нь :
 - Бүх хүний эрх, нэр төрийг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр бүх хүнийг хүндэтгэх
 - Олон янз байдлыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэх
 - Өөрөө эргэцүүлэн бодох, суралцахад нээлттэй байх
 - Хүний эрх, шударга ёсны тухай холбогдох асуудалд идэвх сонирхолтой байх
 - Эрх, үүрэг, эрх тэгш байдал, үл ялгаварлал, нийгмийн эв нэгдэл, соёл болон шашин хоорондын яриа, ойлголцлын уялдаа холбоог ойлгож, үнэлэх
 - Эрхээ шаардах болон үүрэг хүлээгчдээс хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэхийг шаардахдаа итгэлтэй байх
 - Эрх нь зөрчигдсөн хүмүүст энэрэнгүй, эв санааны нэгдлээр хандах
 - Хүний эрхийг тууштай хамгаалах
 - Хүний эрхийн хамтын хүчин чармайлтад итгэх итгэлтэй болох

Залуучуудад чиглэсэн хүний эрхийн боловсролын арга зүйг өөрсдийнх нь оролцоотойгоор боловсруулж, суралцагч төвтэй, жендэрийн мэдрэмжтэй байхаар төлөвлөж, суралцагчдын идэвхтэй оролцоог дэмжих хэрэгтэй.

Эдгээр арга зүй нь хүний эрхийн ойлголтыг залуучууд өөрсдийн амьдрал, орчин, туршлагатай уялдуулан ойлгож хэрэглэх боломжийг олгох туршлагад суурилсан сургалтыг онцолж, залуучууд өөр хоорондоо сэтгэл хөдлөлийн холбоо тогтоох, харилцан ярилцах, ойлголцох боломжийг бүрдүүлэх үе тэнгийн суралцах аргачлалд суурилсан байх шаардлагатай.

Мөн үе хоорондын болон соёл хоорондын яриа хэлэлцээ, соёлын олон янз байдлыг хүндэтгэх, үе үеийн хүмүүсийн эв нэгдлийг бэхжүүлэх хүний эрхийн кампанит ажлууд нь эдгээр боловсролын үйл ажиллагааны чухал хэсэг байх ёстой.

Спорт, кино, урлаг, соёл, тоглоом, түүх сургамжит түүх зэрэг төрөл бүрийн боловсролын арга хэлбэр, орчныг ашиглан бүх төрлийн ялгаатай суралцагчдыг сонирхолтой, идэвхтэй байдлаа хамруулах боломжтой.

Залуучуудад зориулсан сургалтын материал бусад нөөц нь тухайн насны онцлогт тохирсон, хамааралтай, соёлын орчин болон орон нутгийн түүх, нийгмийн хөгжлийн суурь дээр тулгуурласан хүний эрхийн зарчмуудыг тусгасан байх ёстой.

Эдгээрийг хэл, хөгжлийн бэрхшээлтэй байдал зэрэг хүчин зүйлсийг харгалзан, аливаа ялгаварлалгүйгээр бүх залуучуудад хүртээмжтэй, идэвхтэй оролцоотой байхаар зохион байгуулах шаардлагатай.

Хүний эрхийн сургалтын тогтвортой хөтөлбөрүүдийг дэмжих зорилгоор шинэ сургалт, нөөцийн төвүүдийг байгуулах, эсвэл одоо байгаа байгууллагуудыг шаардлагатай хэрэгслээр хангах боломжтой. Үүний зэрэгцээ хүний эрхийн боловсролын судалгаа, шинжилгээ болон холбогдох бусад үйл ажиллагааг хөгжүүлэх нь чухал.

Хүний эрхийн боловсролыг түгээх болон түүнийг хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд залуучуудын зөвлөлүүд, орон нутгийн залуучуудын байгууллагуудыг байгуулах, эсвэл бэхжүүлэх хэрэгтэй. Мөн залуучуудыг бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд оролцох боломжийг хангах платформуудыг дэмжих шаардлагатай.

Технологи ашиглах боломжоор хангах нь хүний эрхийн боловсролд хандах хүртээмжийг нэмэгдүүлэх, сүлжээ үүсгэх, холбогдох мэдээлэл солилцох, хэлэлцүүлэг өрнүүлэх чадавхыг сайжруулна.

3. Багш чадавхжуулах сургалт

Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн өмнөх үе шатуудад багш нь хүний эрхийн үнэт зүйлс, ур чадвар, хандлага, сэдэл болон дадал хэвшлийг түгээхэд чухал үүрэг хариуцлага хүлээдэг болохыг онцолсон.

Иймд багш, их дээд сургуулийн багш, боловсролын бусад ажилтан зэрэг холбогдох мэргэжлийн бүлгүүдэд зориулсан хүний эрх болон хүний эрхийн боловсролын арга зүйн сургалт нь албан боловсролын тогтолцоо дахь хүний эрхийн боловсролын төлөвлөлтийн зайлшгүй чухал бүрэлдэхүүн хэсэг юм.

Энэ нь албан бус боловсролын орчинд ажилладаг багш нарт нэгэн адил хамаарах бөгөөд ялангуяа үе тэнгийнхэндээ сургалт явуулах чадвартай залуучууд баазыг бүрдүүлэх зорилгоор залуу багш, манлайлагчид, залуучуудын төв болон байгууллагын төлөөлөгчид, идэвхтнүүд, сайн дурын ажилтнуудад тэргүүлэх ач холбогдолтой.

Багш үр дүнтэйгээр бэлтгэхийн тулд одоо байгаа үйл ажиллагааны үнэлгээнд үндэслэн хүний эрхийн цогц сургалтын бодлого батлах, багшийн сургалтын хөтөлбөрт хүний эрх болон хүний эрхийн боловсролын зарчим, стандартуудыг тусгах, хүний эрхийн мэдрэмж болон үйлдэлд чиглэсэн сурах эрмэлзэл, өөрийгөө үнэлэх үнэлэмж, сэтгэл хөдлөлийн хөгжлийг тусгасан оролцоонд суурилсан, суралцагч төвтэй, дадлагажих, үйлдэлд чиглэсэн арга зүйг ашиглах, түүнчлэн албан ба албан бус болон өдөр тутмын орчинд сургалтын нөөц бололцоо, хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж болно.

Залуу багш болон гадуурхагдсан, эмзэг нөхцөл байдалд байгаа бүлгээс гаралтай багш нарын мэдлэг, туршлагыг илүүтэйгээр онцолж, хүндэтгэн, оролцуулах нь зүйтэй.

Багш нарт зориулсан хүний эрхийн сургалтын хөтөлбөр нь хүний эрх болон хүний эрхийн боловсролыг хүндэтгэх зан үйл, мэдлэг, ур чадвар, хандлага багтаасан сургалтын зорилтыг ашиглах ёстой.

Энэ нь хүний эрхийн үндсэн зарчим, стандарт, хамгааллын механизмг хамрахын зэрэгцээ нийгмийн бүлгүүдийн түвшинд гарч буй хүний эрхийн асуудлууд, ялангуяа залуучуудад хамаарах асуудлуудыг авч үзэх ёстой.

Нийгмийн ур чадвар, соёл хоорондын болон шашин хоорондын яриа хэлцлийн ур чадвар, хүний эрхийн зарчимд нийцсэн ардчилсан манлайллын хэв маяг нь сургалтын хөтөлбөрийн нэг хэсэг байх ёстой.

Багшид мөн сэтгэлзүйн гэмтлийг ойлгож, түүнийг зохицуулах, нийгэм-сэтгэл хөдлөлийн боловсролыг сургалтад тусгах, мөн нөлөөлөлд өртсөн иргэдийн дуу хоолойг анхаарлын төвд авч үзэх чадвартай байх ёстой.

4. Дэмжих орчин

Боловсролын үйл явцад суралцах орчин болон гэр бүл, орон нутгийн хамт олон зэрэг өргөн хүрээний орчин нөлөөлдөг.

Тиймээс улс орнууд хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа явуулахдаа зохион байгуулалт, оролцоог дэмжих арга хэмжээ авч, ийм үйл ажиллагаанд оролцсон хүмүүсийг өшөө авалт, шахалтаас ангид байх эрхийг нь баталгаажуулах ёстой.

Залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролын хүчин чармайлтад залуучуудын хүний эрхийн ойлголт, хамгааллыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг дагалдуулах шаардлагатай.

Эдгээр бүрэлдэхүүн хэсэг бүрийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаа нь төлөвлөлт, загвар боловсруулах, хэрэгжилт, үр дүнгийн үнэлгээ болон хяналт-шинжилгээ, үнэлгээний бүх шатанд залуучуудыг үндсэн буюу гол оролцогчийн хувиар оролцуулах ёстой.

III. Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролын стратегийг нэгдмэл, уялдаа холбоотой хэрэгжүүлэхэд улс орнууд хэрэгцээ шаардлагаа тодорхойлох, стратеги боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт- шинжилгээ, үнэлгээнд дэмжлэг үзүүлэх хүний болон санхүүгийн нөөцийг хангалттай хэмжээнд хуваарилах тууштай хүчин чармайлт гаргах хэрэгтэй.

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндэсний зохицуулах чиг үүрэг бүхий байгууллагаар ахлуулан хэрэгжүүлэх гурван үе шаттай үйл явцыг санал болгож байна.

Шинээр байгуулагдах зохицуулах байгууллага (эсвэл өмнө байсан байгууллагад үндэслэн байгуулагдах) нь уялдаа холбоо, мэдээлэл солилцоо, нөөцийг үр ашигтай ашиглах нөхцөлийг хангаж, давхардсан үйл ажиллагаанаас зайлсхийх хэрэгтэй.

Үүнд бусад холбогдох яамд, үндэсний хүний эрхийн байгууллагууд, залуучуудын төлөөлөл (тусгаарлагдсан буюу эмзэг нөхцөлд байгаа залуучуудын төлөөллийг оролцуулан), иргэний нийгмийн байгууллагууд болон боловсролын байгууллагын төлөөллийг хамруулах ёстой.

Боломжит бусад оролцогч талуудад нийгмийн үйлчилгээ үзүүлэгчид, хэвлэл мэдээллийн байгууллагууд, орон нутгийн болон шашны удирдагчид, сургуулийн эцэг эхийн зөвлөл, эцэг эх—багшийн холбоод, хувийн хэвшил, хандивлагчид, эрүүл мэндийн болон сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд, нийгмийн цахим сүлжээний нөлөөлөгчид болон бусад холбогдох оролцогчдыг хамруулж болно.

Уг байгууллага нь НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар (ХЭДКГ) болон бусад холбогдох НҮБ-ын агентлагуудтай хамтран ажиллаж, үндэсний түвшинд гарсан ахиц дэвшлийн талаарх мэдээллийг хуваалцах ёстой.

Хэрэгжүүлэхээр санал болгож буй гурван үе шатанд дараахыг хамруулна:

АЛХАМ 1:

Залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролын үндэсний суурь судалгаа хийх

Энэхүү судалгаа нь залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролтой холбоотой дээр дурдсан дөрвөн бүрэлдэхүүн хэсэг (хэрэгжиж буй бодлого ба холбогдох арга хэмжээнүүд, сургах,сурах үйл явц ба хэрэглэгдэхүүн, багш бэлтгэх, суралцах орчин)-ийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, залуучуудын хүний эрхийн боловсролын тусгай хэрэгцээг үнэлэхэд чиглэнэ.

Энэхүү судалгаа нь бүх оролцогч талуудын хооронд үндэсний стратеги боловсруулахад чиглэсэн үндэсний хэмжээний хэлэлцүүлгийн суурь болж чадна.

АЛХАМ 2:

Залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролыг дэмжих үндэсний стратеги боловсруулах

Энэхүү стратеги нь үндэсний суурь судалгаанд тулгуурлан энэхүү стратеги нь 2020–2024 оны хугацаа болон түүнээс цаашид хэрэгжих зорилго, тэргүүлэх чиглэл, гарцыг тодорхойлох бөгөөд үүнд оруулах хувь нэмэр, үйл ажиллагаа, зохицуулалтын механизмууд, тодорхой гарц, хүрэх үр дүн болон хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцооны нэг хэсэг болох холбогдох үзүүлэлтүүдийг багтаах юм.

Стратегийг бүх оролцогч талуудад, ялангуяа залуучуудад өргөнөөр түгээх ёстой.

АЛХАМ 3:

Үндэсний стратегийг хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.

Дараагийн алхам нь стратегийг хэрэгжүүлэх бөгөөд цаашдын хэрэгжилтийг сайжруулахын тулд тогтмол хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зэргийг хамаарна.

Үндэсний зохицуулах чиг үүрэг бүхий байгууллага үнэлгээний тайлангуудыг олон нийтэд нээлттэй болгох ёстой.

IV. Олон улсын хамтын ажиллагаа


Үйл ажиллагааны төлөвлөгөө нь үндэсний стратегийг хэрэгжүүлэхэд олон улсын хамтын нийгэмлэгээс үндэсний стратегийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээс гадна бүс нутгийн болон олон улсын түвшинд холбогдох хүчин чармайлтыг хөхиүлэн дэмжинэ.

Холбогдох оролцогчдод НҮБ-ын тогтолцоо, НҮБ-тай холбоотой мэргэжлийн сургалтын байгууллагууд, олон улсын болон бүс нутгийн засгийн газар хоорондын байгууллагууд, бүх түвшний холбогдох мэргэжлийн сүлжээ, холбоод, үйлдвэрчний эвлэлүүд, дээд боловсролын байгууллагуудын сүлжээ, үндэсний хүний эрхийн байгууллагууд болон бүх түвшний төрийн бус байгууллагууд, олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн нөөц ба баримт бичгийн төвүүд, олон улсын болон бүс нутгийн санхүүгийн байгууллагууд, хоёр талт санхүүжилтийн агентлагууд, олон талт болон хоёр талт хөгжлийн агентлагууд, мөн үндэстэн дамнасан корпорациуд болон тэдгээрийн сүлжээ багтана.

Үзүүлэх тусламжид дараах хамаарна:

- Үндэсний стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт-дүн шинжилгээ, үнэлгээ хийх үйл явцыг дэмжих.
- Оролцогч бүх талуудыг, ялангуяа төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоод, дээд боловсролын байгууллагууд, үндэсний хүний эрхийн байгууллагууд болон бусад иргэний нийгмийн байгууллагыг дэмжих.
- Мэдээлэл, ашиглах боломжтой материалууд холбогдох байгууллагууд болон хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг бүхий л түвшинд хуваалцахад дэмжлэг үзүүлэх.
- Залуучуудын чадавх бэхжүүлэх хөтөлбөрүүдийг дэмжих болон/эсвэл боловсруулах, ялангуяа залуучуудын багш нарт зориулсан хүний эрхийн сургалт болон холбогдох арга хэмжээнд залуучуудын оролцоог хангах.
- Залуучуудад зориулсан хүний эрхийн боловсрол, сургалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй одоогийн сүлжээнүүдийг дэмжих, мөн бүх түвшинд шинэ сүлжээ байгуулахыг дэмжих.
- Залуучууд болон залуучуудын байгууллагуудыг санхүүгийн дэмжлэг, нөөцөөр хангах.

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд мөн улс орнууд 2022 оны дунд үе болон дөрөв дэх шатны төгсгөл болох 2025 оны эхэнд үндэсний хэмжээнд гарсан ахиц дэвшлийн талаарх тайланг Хүний эрхийн дээд комиссар (ОНЧР)-аар дамжуулан Хүний эрхийн зөвлөлд хүргүүлэхийг хүссэн байна.



ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫН ДЭЛХИЙН ХӨТӨЛБӨРИЙН ДӨРӨВ ДЭХ ҮЕ ШАТНЫ (2020–2024) ТӨЛӨВЛӨГӨӨ

I. Танилцуулга

A. Хүний эрхийн боловсролын тодорхойлолт

1. Олон улсын хамтын нийгэмлэгээс хүнд эрхийг нь эдлүүлэхэд хүний эрхийн боловсролын оруулах хувь нэмэр, үүнд хүн бүр хариуцлагатай оролцох нийтлэг ойлголтыг зөвшилцөн хөгжүүлэхээ улам бүр илэрхийлсээр байна.

Хүний эрхийн боловсрол нь хүчирхийлэл, зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх, эрх тэгш байдал, тогтвортой хөгжлийг дэмжих, ардчилсан тогтолцоо дахь шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулдаг болохыг хүлээн зөвшөөрсөн.

2. Олон тооны олон улсын гэрээ конвенц болон баримт бичигт хүний эрхийн боловсролын талаар тусгасан байдаг. Үүнд: Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал (26 дугаар зүйл); Боловсролын талаар алагчлахтай тэмцэх тухай ЮНЕСКО-ийн конвенц (5 дугаар зүйл); Арьс үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц (7 дугаар зүйл); Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт (13 дугаар зүйл); Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц (10 дугаар зүйл); Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (10 дугаар зүйл); ОУХБ-ын уугуул иргэд болон овгийн хүмүүсийн тухай конвенц-1989 (№ 169) (30, 31 дүгээр зүйл); Хүүхдийн эрхийн конвенц (29 дүгээр зүйл); Цагаач ажилтнууд болон тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай конвенц (33 дугаар зүйл); Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц (4, 8 дугаар зүйл); Венийн тунхаглал ба үйл ажиллагааны хөтөлбөр (догол мөр. I хэсэг, 33–34; II хэсэг, 78–82); Хүн ам, хөгжлийн асуудлаарх олон улсын бага хурлын Үйл ажиллагааны хөтөлбөр, (догол мөр 7.3, ба 7.37); Дурбангийн тунхаглал ба үйл ажиллагааны хөтөлбөр (тунхаглал: 95–97; үйл ажиллагааны хөтөлбөр: 129–139) болон Дурбаны дүгнэлтийн бага хурал, Үр дүнгийн баримт бичиг (догол мөр. 22, ба 107); мөн 2005 оны Дэлхийн дээд хэмжээний уулзалтын үр дүнгийн баримт бичиг (догол мөр. 131).

3. 2011 оны 12 дугаар сард Ерөнхий Ассамблейгаас Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай НҮБ-ын тунхаглалыг баталсан.²

Уг тунхаглалд (2 дугаар зүйлд) хүний эрхийн боловсрол, сургалт нь иргэдэд мэдлэг, ур чадвар, ойлголтыг олгож, хүний эрхийн түгээмэл соёлыг бий болгох, түгээн дэлгэрүүлэхэд тэдний оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх хандлага, зан үйлийг хөгжүүлэх талаарх тусгасан

Тунхаглалд “Улс орнууд, шаардлагатай тохиолдолд холбогдох төрийн эрх бүхий байгууллагууд хүний эрхийн боловсрол, сургалтыг дэмжиж, хангах үндсэн үүрэг хариуцлагыг хүлээх” бөгөөд “Улс орнууд нь иргэний нийгэм, хувийн хэвшил болон бусад холбогдох талуудын аюулгүй, оролцооны орчныг бүрдүүлэх ёстой” хэмээн заасан (7 дугаар зүйл).

² 66/137 тогтоол, түүний хавсралт

Хүний эрх, үндсэн эрх чөлөөний талаарх олон улсын ойлголцол, хамтын ажиллагаа, энх тайвны боловсролын талаарх ЮНЕСКО-гийн Зөвлөмж (1974) нь хүний эрхийн боловсролд зориулсан дэлхийн түвшний акт болох НҮБ-ын Тунхаглалаас өмнө батлагдсан.

4. Олон улсын хамтын нийгэмлэгээр хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийн боловсролын тодорхойлолтын элементүүдийг агуулсан дээрх баримт бичгүүдэд зааснаар хүний эрхийн боловсролд хүний эрхийн түгээмэл соёлыг бүтээх зорилготой аливаа суралцах, боловсрол олгох, сургалт явуулах эсвэл мэдээлэл түгээх бүх талын хүчин зүтгэл багтана.

5. Хүний эрхийн боловсрол нь дараах зүйлсийг дэмждэг насан турш үйл явц юм. Үүнд:

- а) Мэдлэг ба ур чадвар: хүний эрхийн талаар суралцаж, тэдгээрийг өдөр тутмын амьдралд хэрэгжүүлэх ур чадварыг эзэмших;
- б) Хандлага: хүний эрхийг хамгаалах хандлага, үнэт зүйлс, итгэл үнэмшлийг хөгжүүлэх эсвэл бэхжүүлэх;
- в) Чадвар: хүний эрхийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах.

В. Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр ба холбогдох санаачилгууд

6. Хүний эрхийн боловсролын санаачилгыг дэмжих үүднээс гишүүн улс орнууд дараах олон улсын үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлсэн. Үүнд: Хүний эрхийн талаарх мэдээлэл бүхий материалыг боловсруулах, түгээхэд чиглэсэн Хүний эрхийн талаарх дэлхийн олон нийтийн мэдээллийн кампанит ажил (1988); үндэсний түвшинд хүний эрхийн боловсролын иж бүрэн, үр дүнтэй, тогтвортой стратегийг боловсруулах, хэрэгжүүлэхийг уриалсан НҮБ-ын Хүний эрхийн боловсролын арван (1995–2004) болон түүний үйл ажиллагааны төлөвлөгөө; Дэлхийн хүүхдүүдийн энх тайван ба хүчирхийллийн бус соёлыг дэмжих олон улсын арван (2001–2010); Тогтвортой хөгжлийн боловсролын НҮБ-ын Арван (2005–2014); Мөн Хүний эрхийн сургалтын олон улсын жил (2008–2009) зэрэг багтана.

7. Хүний эрхийн боловсролыг дэмждэг бусад олон улсын тогтолцоонд Олон улсын соёлын харилцан ойлголцлын арван(2013–2022), Бүх нийтэд боловсрол олгох хөдөлгөөн (2000–2015) ба Боловсрол 2030 үйл ажиллагааны хөтөлбөр, Ерөнхий нарийн бичгийн даргын “Дэлхийн Боловсрол Нэгдүгээрт” санаачилга (2012–2016), мөн Тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030 зэрэг хамаарна.

8. 2004 оны 12 дугаар сарын 10-нд Ерөнхий Ассамблейгаас Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийг тунхаглав.³

2005 оны 1 дүгээр сарын 1-нээс эхэлсэн дэлхийн хөтөлбөр нь бүх салбарт хүний эрхийн боловсролын хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг ахиулахад чиглэсэн бөгөөд шат дараалсан бүтэцтэй.

³ 59/113 А тогтоол

Эхний үе шат (2005–2009) нь хүний эрхийн боловсролыг бага болон дунд сургуулийн системд нэгтгэхэд зориулагдсан бөгөөд түүний хэрэгжилтийн шинэчилсэн төлөвлөгөөний төсөл (A/59/525/Rev.1)-г Ассамблей 2005 оны 7 дугаар сард баталсан.⁴

Хоёрдугаар үе шат (2010–2014) нь хүний эрхийн боловсролыг дээд боловсролын байгууллагуудад, багш, сурган хүмүүжүүлэх ажилтнууд, төрийн албан хаагчид, хууль сахиулах байгууллагуудын албан тушаалтнууд болон цэрэг албан хаагчид зэрэг бүх түвшинд хүний эрхийн сургалт явуулахад төвлөрсөн бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл (A/HRC/15/28)-г Хүний эрхийн зөвлөл 2010 оны 9 дүгээр сард баталсан.⁵

Гуравдугаар үе шат (2015–2019) нь эхний хоёр шатны хэрэгжилтийг бэхжүүлэх, хэвлэл мэдээллийн мэргэжилтэн, сэтгүүлчдэд зориулсан хүний эрхийн сургалтыг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөө (A/HRC/27/28 ба Corr.1)-г Хүний эрхийн зөвлөл 2014 оны 9 дүгээр сард баталсан.⁶

С. Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн зорилтууд

9. Хөтөлбөрийн зорилтууд нь:

- (a) Хүний эрхийн соёлыг хөгжүүлэхийг хөхиүлэн дэмжих;
- (b) Олон улсын баримт бичгүүдэд үндэслэн хүний эрхийн боловсролын үндсэн зарчим, арга зүйн талаарх нийтлэг ойлголтыг төлөвшүүлэх, түүнийг үндэсний бодлогод уялдуулахыг дэмжих.
- (c) Хүний эрхийн боловсролд үндэсний, бүс нутгийн болон олон улсын түвшинд анхаарлаа хандуулахыг баталгаажуулах;
- (d) Холбогдох бүхий оролцогч талуудын нийтлэг хамтын үйл ажиллагааны хүрээг бий болгох;
- (e) Бүх л түвшинд түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх;
- (f) Хүний эрхийн боловсролын хөтөлбөр болон хүний эрхийг дэмжих бусад боловсролын хөтөлбөрийг судлах, үнэлэх, дэмжих, амжилттай туршлагыг онцлох, тэдгээрийг үргэлжлүүлэх болон/эсвэл өргөжүүлэх хөшүүрэг өгч, шинэлэг хөтөлбөрүүдийг хөгжүүлэх,
- (g) НҮБ-ын Хүний эрхийн боловсрол, сургалтын Тунхаглалыг хэрэгжүүлэхийг хөхиүлэн дэмжих.

⁴ 59/113 В тогтоол

⁵ 15/11 тогтоол

⁶ 27/12 тогтоол

D. Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны зарчим

10. Дэлхийн хөтөлбөрийн хүрээнд боловсрол, сургалтын үйл ажиллагаа дараах байдлаар явагдана:

- (a) Иргэний, улс төрийн, эдийн засаг, нийгэм, соёлын эрх болон хөгжих эрхийг оролцуулаад хүний эрхийн салшгүй, харилцан хамааралтай, харилцан уялдаа холбоотой, хуваагдашгүй, түгээмэл байх зарчмуудыг дэмжих
- (b) Олон янз байдлыг хүндэтгэх, үнэлэхийг дэмжих, мөн арьсны үндэс, арьсны өнгө, хүйс, нас, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний, угсаатны болон нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрсөн болон оршин суугаа газар, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, жендэрийн илэрхийлэл болон бусад үндэслэлээр ялгаварлан гадуурхах явдлыг эсэргүүцэх.
- (c) Ядуурал, хүчирхийлэл бүхий мөргөлдөөн, ялгаварлан гадуурхалт зэрэг архагшсан болон шинэ тутам үүсэж буй хүний эрхийн асуудлуудыг улс төр, нийгэм, эдийн засаг, технологи, байгаль орчны салбарын хурдацтай хөгжлийн хүрээнд дүн шинжилгээ хийх явдлыг дэмжих, улмаар хүний эрхийн стандарттай нийцсэн, нийгмийн нэгдлийг бэхжүүлэх хариу арга хэмжээ, шийдлийг боловсруулах;
- (d) Нийгмийн бүлэг болон хувь хүмүүсийг өөрсдийн эрхийн баталгааг тодорхойлох, үр дүнтэйгээр эрхээ шаардах чадавхтай болгох;
- (e) Үүрэг хүлээгчид, ялангуяа төрийн албан тушаалтнууд өөрийн улсын эрх зүйд харьяалагдах хүмүүсийнхээ эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүргээ биелүүлэх чадавхыг бэхжүүлэх;
- (f) Ялгаатай соёлын агуулгыг бэхжүүлсэн хүний эрхийн соёлыг бий болгох, ингэхдээ улс бүрийн түүхэн болон нийгмийн хөгжлийг харгалзан үзэх;
- (g) Хүний эрхийг хамгаалахын тулд орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон олон улсын хүний эрхийн баримт бичгүүд, механизмуудын талаар мэдлэгийг нэмэгдүүлэх, тэдгээрийг ашиглах ур чадвар эзэмшихийг дэмжих
- (h) Хүний эрхийг ахиулах хувь хүний болон хамтын үйл ажиллагаанд шаардлагатай мэдлэг, шүүмжлэлт дүн шинжилгээ, ур чадварыг багтаасан оролцоонд суурилсан арга зүйг ашиглах, ингэхдээ суралцагчдын нас, соёлын онцлог болон орчныг харгалзан үзэх;
- (i) Эрхээ бүрэн эдлэх, хүний зан чанарын хөгжлийг бүрэн дүүрэн төлөвшүүлэх, оролцоог хөхиүлэн дэмжих аюулгүй сургах, суралцах орчныг бүрдүүлэхийг дэмжих;
- (j) Суралцагчдын өдөр тутмын амьдралд холбоотой байх, хүний эрхийн онолыг өөрсдийн нийгэм, эдийн засаг, соёл, улс төрийн бодит нөхцөл байдалд хөрвүүлэх арга замуудын талаарх яриа хэлэлцээрт татан оролцуулах.

II. Хүний эрхийн боловсролоор дамжуулан залуучуудыг чадавхжуулах нь: Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн дөрөв дэх үе шатны (2020–2024) төлөвлөгөө

A. Хамрах хүрээ

11. Хүний эрхийн зөвлөл 39/3 тоот тогтоолоор залуучуудад зориулсан Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн дөрөв дэх үе шатны (2020–2024) төлөвлөгөөг боловсруулах хүсэлтийг НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газарт (ХЭДКГ) хандан гаргасан.

Тус зөвлөл нь эрх тэгш байдал, хүний эрхийг хангасан, алагчлалгүй, оролцоотой, энх тайван нийгмийн бий болгохын тулд олон талт байдлыг хүндэтгэх агуулга бүхий боловсрол, сургалтад онцгой ач холбогдол өгсөн.

Мөн Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн дөрөв дэх үе шатыг Тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030, ялангуяа Тогтвортой хөгжлийн зорилтын 4.7-д тусгагдсан зорилтот түвшинтэй уялдуулахаар шийдвэрлэсэн бөгөөд тус баримт бичигт дурдсан олон янзын агуулга болон боловсролын арга зүй хоорондын уялдааг харгалзан үзсэн.

12. Түүнчлэн Зөвлөл нь дөрөв дэх үе шатны хүрээнд гишүүн улсууд болон холбогдох оролцогч талуудыг өмнөх гурван үе шатны хэрэгжилтийг урагшлуулахад илүү их хүчин чармайлт гаргахыг уриалсан.

13. Одоогийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл нь олон улсын хэмжээнд хэлэлцэн тохиролцсон зарчмуудад тулгуурлан үндэсний хэмжээнд залуучуудад зориулсан цогц хүний эрхийн боловсролын стратеги боловсруулах удирдамж болж өгдөг.

Уг төлөвлөгөөнд хэрэгжүүлэх зорилго, бүрэлдэхүүн хэсэг, үйл ажиллагаа, практик алхмууд болон холбогдох оролцогч талуудыг тодорхойлсон.

14. Уг төлөвлөгөө нь өмнөх шатны төлөвлөгөөнүүдэд тулгуурласан бөгөөд ялангуяа эхний үе шат (анхан болон дунд боловсрол дахь хүний эрхийн боловсролд төвлөрсөн) болон хоёр дахь үе шат (дээд боловсрол дахь хүний эрхийн боловсролд төвлөрсөн)-ын төлөвлөгөөнд суурилсан.

Мөн гурав дахь үе шатны төлөвлөгөөнд тулгуурлан, албан болон албан бус боловсролын багш бэлтгэх сургалтын асуудлыг тусгасан.⁷

15. Залуучууд гэх ойлголтын тухайд олон улсын санал нэгдсэн ямар нэгэн тодорхойлолт байхгүй.⁸

Олон төрлийн хандлагууд нь залуучууд гэдэг нь тогтсон насны бүлэг бус, харин өсөх, хөгжих чадавх бүхий хувь хүмүүсээс бүрдсэн өөрчлөгдөх шинжтэй, нэгдмэл бус бүлэг хэмээн тодорхойлдог.

Бусад насны бүгээс ялгаатай нь, энэ нас нь амьдралын түр зуурын үе шатуудын нэг бөгөөд нийгэм соёлын янз бүрийн нөхцөл байдлаас шалтгаалан харилцан адилгүй байдаг.

Мөн залуучууд нь зөвхөн наснаас гадна тэдгээрийг илтгэн олон төрлийн бөгөөд огтлолцсон онцлог шинж (жендэр, үндэс угсаа, тодорхой цөөнх олон уугуул иргэд харьяалагдах гэх мэт)-тэй байдаг.

16. Иймээс энэхүү төлөвлөгөө нь НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газар “залуучууд” гэдэг нэр томъёог статистикийн зорилгоор 15-24 насныхан гэж тодорхойлдог ч НҮБ-ын байгууллагууд ба тэдгээрийн нэгжүүд цаашлаад гишүүн улс орнуудын хэрэглэдэг бусад тодорхойлолтыг ямар нэг нөхцөлгүйгээр зөвшөөрдөг байна.

В. Үндэслэл

17. Гишүүн улсууд НҮБ-ын үүсгэн байгуулагдсан цагаас хойш залуучуудад хүний эрхийн боловсрол олгох нь чухал ач холбогдолтой болохыг онцлон тэмдэглэсээр ирсэн.

Жишээлбэл, 1965 оны “Залуучуудын дунд энх тайван, улс орнуудын⁹ харилцан хүндлэл ба ойлголцлын үзэл баримтлалыг түгээн дэлгэрүүлэх тухай Тунхаглал” болон 1968 онд Тегеранд болсон Хүний эрхийн олон улсын бага хурлаар баталсан “Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэхэд суурилсан залуучуудын боловсрол” -ын талаарх ХХ тогтоолд залуучуудын эрч хүч, урам зоригоор дүүрэн байдал, бүтээлч чанар болон ирээдүйг бий болгоход гүйцэтгэх үүргийг онцолсон бөгөөд, хүний эрх болон энх тайвныг дэмжихэд тэднийг чадавхжуулах, хүний эрхийн боловсрол олгохын ач холбогдлыг тодотгосон байдаг.

⁷ Төлөвлөгөөний гуравдугаар үе шат ((A/HRC/27/28 болон Corr.1) 18-22 догол мөрүүд Албан боловсрол гэдэг нь “төрийн байгууллага болон хүлээн зөвшөөрөгдсөн хувийн байгууллагуудын зохион байгуулалттай, тодорхой зорилготой, урьдчилан төлөвлөсөн боловсрол” бол албан бус боловсрол гэдэг нь мөн “зохион байгуулалттай, тодорхой зорилготой, урьдчилан төлөвлөсөн боловсрол” хэдий энэ нь хувь хүний насан туршийн боловсролын хүрээнд албан боловсролыг нөхөх, орлох болон/эсвэл түүнийг нэмэгдүүлэх зорилготой боловсролын хэлбэр бөгөөд иргэний нийгмийн байгууллагуудаас хэрэгжүүлдэг боловсролын үйл ажиллагаа үүнд багтдаг (Эдгээр тодорхойлолтыг UNESCO-ийн <http://uis.unesco.org/en/glossary> сайтаас үзэх боломжтой).

⁸ Энэ асуудлаар олон улсын байр суурь ямар байгаа тухай мэдээллийг A/HRC/39/33 баримт бичгийн 13–15 дугаар догол мөрөөс үзнэ үү.

⁹ Ерөнхий Ассамблейн 2037 (XX) дугаар тогтоол

18. Хүний эрхийн боловсрол нь сурч боловсрох эрхийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд энэ талаар хэд хэдэн олон улсын хүний эрхийн болон боловсролын гэрээ конвенц, баримт бичгүүдэд тодорхой тусгасан байдаг.¹⁰

Энэ талаар Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрт дахин баталгаажуулсан: бөгөөд хүртээмжтэй, тэгш чанартай боловсролын тухай 4 дүгээр зорилгын 7 дугаар зорилтот “Бүх суралцагчдад тогтвортой хөгжил, тогтвортой амьдралын хэв маягт чиглэсэн боловсрол, хүний эрх, жендэрийн эрх тэгш байдал, энх тайван ба хүчирхийлэлгүй соёл, дэлхийн иргэн байх, соёлын олон янз байдал, соёлын тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрийг үнэлэх зэрэг агуулгаар дамжуулан тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах мэдлэг, ур чадварыг олгох” зорилтыг дэвшүүлсэн.

19. Сүүлийн жилүүдэд залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролыг дэлхийд тулгарч буй өнөөгийн сорилтуудаас урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх стратеги хэмээн үзэх нь улам бүр нэмэгдэж байна.¹¹

1995 оны Гэмт хэрэгтэй тэмцэх болон эрүүгийн эрх зүйн тогтолцоог НҮБ-ын өргөн хүрээтэй хөтөлбөрт нэгтгэх, нийгэм, эдийн засгийн сорилтуудыг шийдвэрлэх, үндэсний болон олон улсын түвшинд хууль дээдлэх ёсыг дэмжих, олон нийтийн оролцоог хангах тухай Дохагийн тунхаглалд гишүүн улсууд залуучуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд эерэг өөрчлөлтийн төлөөлөгч болгох хүний эрх болон хууль дээдлэх ёсыг хамгаалахад чиглэсэн боловсролын хөтөлбөрүүдийг хөгжүүлэх үүрэг амлалтаа илэрхийлсэн байдаг.¹²

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл 2250 дугаар тогтоолдоо (2015 он) залуучууд нь зөрчил мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэхэд чухал үүрэг хүлээдэг болохыг бататган тэмдэглэж, залуучуудыг иргэний нийгмийн бүтэц, хүртээмжтэй улс төрийн үйл явцад бүтээлчээр оролцох чадвар олгох зохистой, чанартай энх тайвны боловсролыг дэмжихийг гишүүн улс орнуудад уриалсан байдаг.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын “Хэт туйлширсан түрэмгий үзлээс урьдчилан сэргийлэх тухай үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд хүний эрх болон олон янз байдлыг хүндэтгэх үзлийг төлөвшүүлэх, шүүмжлэлт сэтгэлгээг дэмжих ... мөн энх тайвнаар зэрэгцэн орших болон хүлээцтэй байдлыг бий болгоход хувь нэмэр оруулах зан үйлийн болон нийгэм, сэтгэл хөдлөлийн ур чадварыг хөгжүүлэх нь үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах чухал бүрэлдэхүүн хэсэг хэмээн үзсэн.¹³

¹⁰ Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн эхний үе шатны төлөвлөгөө (A/59/525/Rev.1)-ний 10–20-р догол мөрүүд болон хоёрдугаар үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөө (A/HRC/15/28)-ний 18–20-р догол мөрүүдийг үзнэ үү.

¹¹ A/HRC/35/6-г үзнэ үү.

¹² Ерөнхий Ассамблейн 70/174 дугаар тогтоолын хавсралтын 10-р догол мөр.

¹³ A/70/674-ийн 54-р догол мөр.

2018 онд Ерөнхий нарийн бичгийн даргын санаачилсан НҮБ-ын Залуучуудын стратеги — Залуучууд 2030: “Залуучуудын төлөө, залуучуудтай хамтран ажиллах нь” баримт бичгийн дагуу НҮБ нь залуучуудад зориулсан хүний эрхийн боловсрол, сургалтыг түгээн дэлгэрүүлэх, мөн дэлхийн иргэн байх болон тогтвортой хөгжлийн боловсролыг ялгаварлан гадуурхалтгүйгээр дэмжих хүчин чармайлтаа нэмэгдүүлэх, залуучуудад иргэний ухамсар, оролцоо, сайн дурын үйл ажиллагаа, энх тайван болон хүчирхийлэлгүй соёлыг төлөвшүүлэх үүрэг хүлээсэн байна.¹⁴

20. Бүс нутгийн түвшинд залуучуудыг чадавхжуулах нь улс орнуудын тэргүүлэх үүрэг амлалтын нэг юм.

Африкийн холбооны Африкийн залуучуудын Харти (2006) болон Африкийн залуучуудын арван (2009—2018) үйл ажиллагааны төлөвлөгөө нь залуучуудыг чадавхжуулах, оролцоог нэмэгдүүлэх үндэсний болон бүс нутгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахыг дэмждэг бөгөөд Африк тивд уялдаа холбоотой арга хэмжээ авахад чиглэсэн суурь баримт бичиг болдог.

2005 оны “Испани, Португал хэлээр ярьдаг Америк тивийн орнуудын залуучуудын эрхийн тухай конвенц” нь залуучуудыг эрх эдлэгч, стратегийн хөгжлийн оролцогч болохыг хүлээн зөвшөөрч, тэдний нийгэм, улс төрийн оролцоог баталгаажуулан, холбогдох хөтөлбөр, бодлого боловсруулах, хэрэгжүүлэхийг дэмждэг.

Латин Америк болон Карибын тэнгисийн бүсийн улс орнууд 2013 онд “Хүн ам ба хөгжлийн тухай Монтевидеогийн зөвшилцөл”-баримт бичгийг баталсан бөгөөд энэ нь “өсвөр үеийнхэн болон залуучуудыг аливаа ялгаварлан гадуурхалгүйгээр олон нийтийн хэлэлцүүлэг, шийдвэр гаргах үйл явц, бодлого, хөтөлбөрийн бүх үе шат, ялангуяа тэдэнд шууд хамааралтай асуудлуудад оролцох эрхийг баталгаажуулах”, түүнчлэн “тэсвэр хатуужил, олон янз байдлыг хүлээн зөвшөөрөх, харилцан хүндлэл, хүний эрхийг хүндэтгэх, зөрчил маргааныг шийдвэрлэх болон энх тайвныг дэмжих боловсролыг бага наснаас нь олгох стратеги”-ийг багтаадаг.

Зүүн Өмнөд Азийн Улсуудын Холбоо (АСЕАН) “Залуучуудын хөгжлийн индекс” (2017)-ийг баталснаар бүс нутгийн залуучууддаа илүү их анхаарал хандуулж, зохих хөрөнгө оруулалт хийх үүрэг амлалтаа баталгаажуулсан юм.

Залуучуудын төлөөлөгчдийн баталсан “Европын Зөвлөлийн хөтөлбөр 2020” болон түүний “Залуучуудын стратеги 2030”-ийн төсөл нь хүний эрхийн боловсролыг залуучуудын бодлогын үндсэн зарчим, тэргүүлэх чиглэлүүд, ялангуяа залуучуудын эрх эдлэхтэй холбоотой асуудалтай уялдуулан авч үздэг.

“Ардчилалын, иргэний болон хүний эрхийн боловсролын тухай Европын Зөвлөлийн Тунхаг (2010)” нь залуучуудыг, ялангуяа албан бус боловсролын хүрээнд, хүний эрхийн боловсролын чухал оролцогч хэмээн онцлон тэмдэглэдэг.

Европын Холбооны Залуучуудын стратеги (2019—2027) нь залуусыг чадавхжуулах, оролцоог нь нэмэгдүүлэх, мөн ардчилсан нийгэмд идэвхтэй байхад нь дэмжлэг үзүүлдэг.

¹⁴ Энэхүү стратегийн дөрөв дэх тэргүүлэх чиглэл нь “Залуучууд ба хүний эрх” юм.

21. Дээр дурдсан баримт бичгүүд болон бодлогын хүрээнүүд нь залуучуудыг эрх эдлэгч бөгөөд хүний эрхийг хэрэгжүүлэх, тогтвортой хөгжилд хүрэх, энх тайвныг бэхжүүлэх, хүчирхийлэл болон зөрчил мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны гол оролцогч болохыг хүлээн зөвшөөрсөн.

Залуучуудыг өөрсдөд нь хамааралтай, эсвэл ирээдүйд нөлөөлөх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад хүртээмжтэйгээр оролцуулах нь зайлшгүй чухал юм.

Хүний эрхийн боловсрол нь залуучуудыг идэвхтэй иргэн байх үүргээ ойлгох, таньж мэдэх, хэрэгжүүлэхэд чадавхжуулж¹⁵, өөрсдийн болон бусдын эрхийг хамгаалах, олон нийтийн асуудал болон ардчилсан шийдвэр гаргах үйл явцад идэвхтэй оролцоход нь дэмжлэг болдог.

Хүний эрхийн боловсрол нь залуучуудыг чадавхжуулах, хөгжүүлэх, энх тайван, шударга, тогтвортой дэлхий рүү хөтлөх гол түлхүүр юм.

С. Тодорхой зорилтууд

22. Дэлхийн хөтөлбөрийн ерөнхий зорилтуудыг харгалзан үзэж, энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөө дараах тодорхой зорилтуудыг хэрэгжүүлэхийг зорьж байна:

- (a) Дэлхийн хөтөлбөрийн өмнөх үе шатуудад гарсан ахиц дэвшлийг үргэлжлүүлэн, бүх залуучуудыг ялгаварлалгүйгээр хамруулсан, залуучуудын оролцоо, манлайллыг дэмжсэн хүний эрхийн боловсролын тогтвортой үндэсний стратегийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэхийг дэмжих;
- (b) Гадуурхагдсан болон эмзэг нөхцөл байдалд байгаа залуучуудыг нэн тэргүүнд тавьж, хүний эрхийн боловсролыг залуучуудтай хамтран, тэдний оролцоотойгоор албан болон албан бус боловсрол¹⁶, мөн шууд бус, албан ёсны бус сургалтын орчинд өргөжүүлэх;¹⁷

¹⁵ Хүүхдийн эрхийн хороо, ерөнхий тайлбар №20 (2016): Өсвөр насны хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх тухай, 24 дэх догол мөр.

¹⁶ Албаны ёсны бусад сургалт гэдэг нь зорилго чиглэлтэй явагддаг боловч албан ёсны байгууллага зохион байгуулдаггүй суралцах үйл явц юм.

Энэ нь албан болон албан бус боловсролоос илүү цомхон бүтэц, зохион байгуулалттай байдаг бөгөөд гэр бүл, ажлын байр, орон нутгийн хамт олон болон өдөр тутмын амьдралд, суралцагч өөрөө, гэр бүл эсвэл нийгмийн зүгээс чиглүүлэн явагддаг (ЮНЕСКО-н тайлбар толь).

¹⁷ Үүнд хөгжлийн бэрхшээлтэй залуус; угсаатан, шашин болон бусад цөөнхийн бүлэгт хамаарах, түүний дотор уугуул иргэд болон лесби, гей, бисекс, трансжэндэр, интерсекс залуучууд; нийгэм, эдийн засгийн таатай бус нөхцөлд амьдарч буй эсвэл газарзүйн хувьд алслагдсан бүс нутагт оршин суудаг залуучууд; цагаачид, түүний дотор орогнол хүсэгчид, дүрвэгсэд, дотоодын шилжин суурьшигчид болон буцан ирэгсэд; мөн эцэг эхийн асрамж халамжид байдаггүй, хуулийн зөрчил, хүний эрхийн зөрчил, хүчирхийлэлд өртөж хохирсон залуучууд хамаарна.

- (e) Залуучуудын хүний эрхийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх бусад арга хэмжээг нэмэлт хэлбэрээр залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролыг хөхиүлэн дэмжих;
- (f) Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөрийн хүрээнд, дэлхийн өнөөгийн тулгамдсан сорилтуудаас урьдчилан сэргийлэх, шийдвэрлэхэд залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролын оруулах хувь нэмэр, (с) Залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролын үндсэн бүрэлдэхүүн хэсэг болон хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх удирдамжийг албан болон албан бус боловсролын хүрээнд боловсруулж, үүний үндсэн дээр үндэсний түвшинд ахиц дэвшлийг үнэлэх боломжоор хангах;
- (d) Залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролын хөтөлбөрт тэдний оролцоо, манлайллыг дэмжиж, идэвхжүүлэх;
- (e) Хүний эрх, залуучууд, боловсрол болон тогтвортой хөгжлийн чиглэлээр ажилладаг орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон олон улсын төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын дунд залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролын сүлжээг үүсгэх, хамтын ажиллагаанд уриалах.

D. Бүрэлдэхүүн хэсгүүд

23. Дэлхийн хөтөлбөрийн өмнөх гурван үе шат нь залуучуудыг хамарсан албан боловсрол (нэгдүгээр ба хоёрдугаар үе шат), мөн албан болон албан бус боловсролын багш нарт зориулсан хүний эрхийн боловсролын (гуравдугаар үе шат) үр дүнтэй бүрэлдэхүүн элементүүдийг тодорхойлсон.

24. Эдгээр элементэд тулгуурлан энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөнд залуучуудад хүний эрхийн үр дүнтэй боловсрол олгоход чиглэсэн дараах дөрвөн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлсон. Бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн бүхий л үе шат, тухайлбал төлөвлөлт, зураглал, хэрэгжилт, хяналт-шинжилгээ болон үнэлгээний үйл явцад залуучуудыг гол түнш болгон оролцуулах шаардлагатай.¹⁸

¹⁸ Эдгээр бүрэлдэхүүн хэсгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өмнөх үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс үзнэ үү.

1. Бодлого болон холбогдох хэрэгжүүлэх арга хэмжээ

25. Залуучуудад хүний эрхийн боловсрол олгохыг дэмжих бодлогыг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх болон хяналт-шинжилгээ хийх үйл ажиллагаа нь дараах зүйлсийг багтаана:

- (a) Албан боловсролын хүрээнд (дунд, дээд болон мэргэжлийн боловсрол) залуучуудыг голтүншээр оролцуулан, хүний эрх болон хүний эрхийн боловсролыг албан боловсролд тусгах бодлого, хууль тогтоомжийг боловсруулах, үүнд дараах арга хэмжээг багтаах:
 - (i) Хүний эрхийн боловсролыг тусгах үүднээс хүчин төгөлдөр боловсролын хууль тогтоомж, сургалтын хөтөлбөрийг хянаж үзэх, мөн хүний эрхийн боловсролын талаарх хууль тогтоомжийг батлах;
 - (ii) Одоогийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон бусад холбогдох олон улсын баримт бичигт тусгагдсан сайн туршлагад үндэслэн, хүний эрхийн боловсролын зарчимд бүх холбогдох хууль тогтоомж, бодлогыг нийцүүлэх, эдгээр зарчимд нийцэхгүй хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулах;
 - (iii) Залуучуудад үйлчилдэг боловсролын байгууллагын засаглал, менежментийн талаарх бодлого, зохицуулалтыг хүний эрхийн зарчимд нийцүүлэн боловсруулах;
 - (iv) Боловсрол болон хүний эрхийн боловсролыг ялгаварлан гадуурхалтгүйгээр, ялангуяа гадуурхагдсан болон эмзэг нөхцөлд байгаа залуучуудад хүртээмжтэй байх баталгааг хангах бодлого боловсруулах;
 - (v) Эрх тэгш байдал, үл ялгаварлан гадуурхах, хүндлэл, шударга байдал болон ил тод байдлыг хүндэтгэх хүний эрхийн зарчимд нийцүүлэн багш болон боловсролын бусад ажилтныг сонгон шалгаруулах, үнэлэх, цалин урамшуулал олгох, сахилга хариуцлага тооцох, албан тушаал дэвшүүлэхтэй холбоотой бодлого, практикийг бий болгох;
 - (vi) Багш болон боловсролын бусад ажилтан, түүнчлэн залуучуудад чиглэсэн холбогдох бусад мэргэжлээр ажиллах ажилтнуудад төрийн тусгай зөвшөөрөл, гэрчилгээ олгоход хүний эрхийн сургалтад хамрагдсан байхыг шалгуур болгохыг харгалзан үзэх;
- (b) Иргэний нийгмийн байгууллагууд, тэр дундаа залуучуудын бүлэг, залуучуудаар удирдуулсан байгууллагуудаас хэрэгжүүлж буй залуучуудад зориулсан албан бус хүний эрхийн боловсролын хүрээнд, тэдний үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих бодлого болон холбогдох арга хэмжээг боловсруулах, жишээлбэл: бүртгэлийг баталгаажуулах; иргэний орон зайг бэхжүүлэх, санхүүгийн дэмжлэг, үүнд татварын хөнгөлөлт үзүүлэх; менторшип болон бусад мэргэжлийн туслалцаа, чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах; хүний эрхийн боловсролын хөтөлбөрүүд, тэр дундаа цахим хөтөлбөрүүдийг дэмжих, залуучуудаар удирдуулсан байгууллага болон хэвлэл мэдээллийг оролцуулах санаачилгыг онцгойлон анхаарах; залуучуудын хувь нэмрийг хүлээн зөвшөөрөх; гэх мэт;

- (с) Хүний эрхийн боловсрол; залуучууд; боловсрол; хүний эрх, тэр дундаа жендэрийн эрх тэгш байдал; уугуул иргэдийн эрх; дэлхийн иргэн; энх тайван, аюулгүй байдал болон хэт туйлширсан түрэмгий үзэл, хүчирхийлэл, мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх; гэмт хэрэгтэй тэмцэх, эрүүгийн эрх зүйн шударга ёс, авлигатай тэмцэх; Тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030 болон бусад хөгжлийн баримт бичгийн хүрээнд тогтвортой хөгжил; арьс үндэс, арьсны өнгө буюу гарал үүслээр алагчлах, гадаадынхныг үзэн ядах үзэл болон түүнтэй адил төстэй үл тэвчих хандлагатай тэмцэх зэрэг салбаруудад холбогдох бодлого, стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө хамтын хүчин чармайлт, хоорондын уялдаа холбоог хангах;
- (d) Уялдаа холбоо, хяналт-шинжилгээ болон хариуцлагыг хангах үүднээс бүх оролцогч талуудыг оролцуулан, механизм, үүрэг хариуцлага болон нөөц бүхий холбогдох, тодорхой иж бүрэн бодлогын хэрэгжилт болон үнэлгээний арга хэмжээ, бодлого боловсруулах, батлах;
- (e) Залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролтой холбоотой олон улсын үүргээ биелүүлэх, үүнд:
 - (i) Залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролыг багтаасан олон улсын баримт бичгүүдийг соёрхон батлахыг хөхиүлэн дэмжих;
 - (ii) Хүний эрхийн боловсрол болон залуучуудтай холбоотой бүс нутгийн болон олон улсын баримт бичгүүдтэй үндэсний бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээг нийцүүлэх;
 - (iii) Залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролын талаарх мэдээллийг, тэр дундаа гэрээний хороод (ялангуяа Хүүхдийн эрхийн хороо болон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо), тусгай журам (ялангуяа Сурч боловсрох эрхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч), Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг зэрэг холбогдох олон улсын хяналтын механизмыг үндэсний тайланд тусгах;
 - (iv) Дээр дурдсан үндэсний тайланг бэлтгэхдээ төрийн бус байгууллагууд, тэр дундаа залуучуудын байгууллагууд, хүний эрхийн үндэсний байгууллагууд, иргэний нийгэм, хүний эрхийн боловсролын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах;
 - (v) Олон улсын хүний эрхийн хяналтын механизмуудаас өгсөн холбогдох зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх;

2. Заах болон суралцах явц

26. Залуучуудад зориулсан хүний эрхийн боловсрол нь агуулгын онцлог шинж чанартай бөгөөд тэдний суралцах онцлог хэрэгцээ, насны онцлогийг харгалзан үзэх шаардлагатай болохыг хүлээн зөвшөөрч энэ хэсэгт агуулга, арга зүй, материал болон нөөцийн талаарх ерөнхий удирдамжийг санал болгож байна.¹⁹

27. Агуулгын хувьд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай Тунхаглалтай уялдуулан, хүний эрхийн боловсрол нь залуучуудыг эрхээ хэрэгжүүлэх, бусдын эрхийг хүндэтгэх, хамгаалах мэдлэг, ур чадвар, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэдэг. Эдгээр чиглэлд шаардагдах чадамжид дараахыг хамруулна:²⁰

(a) Мэдлэг: Залуучууд дараах зүйлийг мэдэж, ойлгоно:

- (i) Хүний эрхийн түүх болон тэдгээр нь эрх чөлөө, эрх тэгш байдал, шударга ёс, нэр төр төлөөх тэмцэлтэй холбоотойгоор хөгжиж ирсэн байдал; хүний эрхийн салшгүй, түгээмэл, хуваагдашгүй, харилцан уялдаа, хамаарал бүхий хувьсаж буй шинж чанарууд;
- (ii) НҮБ-ын гурван тулгуур болох хүний эрх, энх тайван, тогтвортой хөгжлийн хоорондын нягт харилцан холбоо;
- (iii) Оролцоо ба хүртээмжтэй байдлын зарчим; эрх тэгш байдал ба үл ялгаварлан гадуурхах, үүнд жендэрийн тэгш байдал; хариуцлага хүлээх; болон хүчирхийллээс ангид байх эрх зэрэг хүний эрхийн үндсэн зарчмууд;
- (iv) Хүний эрх нь хувь хүн, олон нийт болон нийгмийн түвшинд залуучуудын өдөр тутмын амьдралтай хэрхэн холбоотой болох талаар;
- (v) Залуучуудад онцгой хамааралтай хүний эрхийн асуудлуудыг орон нутгийн болон үндэсний түвшинд, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Залуучууд 2030 стратеги зэрэг холбогдох олон улсын хүний эрхийн баримт бичгийн хүрээнд авч үзэх;
- (vi) Хүний эрхтэй холбоотой төрийн үүрэг хариуцлага; эрх эдлэгч болон үүрэг хүлээгчийн тодорхойлолт; хүний эрхийн хууль тогтоомж; хүний эрх зөрчигдсөн тохиолдолд орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон олон улсын түвшинд ашиглах боломжтой хамгааллын механизм, гомдол гаргах журам;
- (vii) Хүний эрх, олон улсын хүмүүнлэгийн эрх зүй, зэвсэгт мөргөлдөөний үед хүний эрхийг хамгаалах; дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох;

¹⁹ Дэлгэрэнгүй мэдээллийг өмнөх үе шатуудын үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс үзнэ үү.

²⁰ Энэхүү жагсаалт нь зөвхөн дээрхээс хязгаарлагдахгүй бөгөөд 2012 онд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас боловсруулсан дунд боловсролын тогтолцоонд зориулсан хүний эрхийн боловсролын удирдамжийн “суурь чадамжууд” хэсгээс иш татсан болно.

- (viii) Дэлхийн хэмжээний тулгамдсан асуудлууд (ядуурал, уур амьсгалын өөрчлөлт гэх мэт), тэдгээрийн хүний эрхтэй холбогдох байдал; хүний эрхийн зөрчил болон түүний дэлхийн болон орон нутгийн түвшний үндсэн суурь шалтгаанууд; хүний эрхийг дэмжих эсвэл хүний эрхийн зөрчилд нөлөөлдөг хүчин зүйлс (жишээлбэл, улс төрийн, эрх зүйн, соёл/нийгмийн, шашны болон эдийн засгийн хүчин зүйлс);
 - (ix) Өнөөгийн болон түүхэн хүний эрхийн асуудал, хөдөлгөөнүүд - тухайн улс, бүс нутаг болон дэлхийн түвшинд - мөн хүний эрхийн үйл хэрэгт хувь нэмрээ оруулсан хувь хүн, бүлэг, тэр дундаа эмэгтэйчүүд, залуучууд болон гадуурхагдсан эсвэл эмзэг нөхцөл байдалд байгаа бүлгүүд;
- (b) Ур чадвар: залуучууд дараах чадварыг эзэмших боломжтой:
- (i) Түүхэн болон өнөө цагийн улс төр, эрх зүй, эдийн засаг, соёл, нийгмийн үйл явцыг хүний эрхийн үүднээс дүн шинжилгээ хийх;
 - (ii) Өөрсдийн болон бусдын амьдралд тулгамддаг асуудлууд, тухайлбал боловсрол, хөдөлмөр эрхлэлт, гэр бүл, олон нийтийн орчинд хамаарах хүний эрхийн чухал асуудлуудыг тодорхойлох;
 - (iii) Хүний эрхийн зөрчлүүдийг тэдгээрийн суурь шалтгаан болон үр дагавартай нь хамт тодорхойлох, дүн шинжилгээ хийх; хүний эрх бодитоор хэрэгжсэнээр хувь хүн болон хамт олонд үзүүлэх үр өгөөжийг тодорхойлох;
 - (iv) Боловсрол, мэргэжлийн болон хувийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн хүний эрхийн талаарх мэдээлэл, эх сурвалжуудыг харилцаа холбооны технологи ашиглан хайх, олох; мэдээллийн эх сурвалжууд, үүнд хэвлэл мэдээлэл болон сургалтын нөөцийн баталгаатай байдлыг үнэлэх, үзэл бодлын өнцөг, өрөөсгөл буюу ташаа мэдээллийг таньж, мэдээллийн найдвартай байдлыг ялган таних;
 - (v) Зөрчилдөөнийг шийдвэрлэхэд хүний эрхийн зарчим болон гомдол шийдвэрлэх механизмыг ашиглах; ялгаварлан гадуурхалт, дээрэлхэл, бэлгийн дарамт, жендэрт суурилсан хүчирхийллийн бүх хэлбэр, үүнд цахим орчин дахь хэлбэрийг ч мөн адил, эсэргүүцэх арга стратегийг тодорхойлон хэрэглэх;
 - (vi) Засгийн газрын бүх түвшинд өөрсдөд нь нөлөөлж буй бодлого хөтөлбөрүүдийн боловсруулалт, шийдвэр гаргах үйл явцад манлайлах, оролцох, нөлөөлөх; хүний эрхтэй холбоотой, ялангуяа залуучуудад тулгардаг саад бэрхшээлийн талаарх хэлэлцүүлэг, мэтгэлцээнд манлайлан идэвхтэй оролцох, үүнд хүний эрхээ эдлэхэд залуучуудад тулгардаг саад бэрхшээлүүдийг хөндсөн хэлэлцүүлгүүдэд оролцох, мөн маргаантай хүний эрхийн сэдвүүдэд мэдрэмжтэй бөгөөд бүтээлч байр сууринаас хандаж, хувь нэмэр оруулах;
 - (vii) Хүний эрхийг нөлөөлөн хамгаалах үйлсэд бусадтай хамтран ажиллаж, гадуурхагдсан бүлгийн дуу хоолойг хүчтэй илэрхийлэх;

- (viii) Бодлого, хууль эрх зүйн өөрчлөлт хийх санал боловсруулж, хамгаалан дэмжих (жишээ нь, боловсролын орчин, орон нутаг, нийгэм); үүрэг хүлээгч этгээдүүдэд хандан хүний эрхийн олон улсын хэм хэмжээнд суурилан хууль ёсны болон хүчирхийлэлгүй аргаар эрхээ хамгаалуулах, ийнхүү хамгаалуулахаар шаардах.
- (ix) Хувийн болон олон нийтийн орчинд хүний эрхийг дэмжих, хамгаалах үйл ажиллагаа, тэр дундаа олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг бэлтгэх, хэрэгжүүлэх; хүний эрхийн зөрчлийн хохирогчдыг оролцуулсан хүний эрхийн чиглэлээрх аливаа зохион байгуулалт, кампанит ажлыг манлайлах; хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг зохих арга зүй ашиглан зохион байгуулах;
- (x) Цахим болон цахим бус орчин дахь үзэн ядалт, ялгаварлан гадуурхалтай тэмцэх; цахим бичиг үсгийн боловсрол эзэмших; цахим орчин, ялангуяа нийгмийн цахим сүлжээнд тулгардаг эрсдэлүүд, тухайлбал хүчирхийлэгч байж болзошгүй этгээдтэй холбоо тогтоох, хүчирхийллийн агуулга, дээрэлхэл, үзэн ядсан үг хэллэг, хэт туйлширсан түрэмгий үзэл санаа гэх мэтийг таньж мэдэн хариу арга хэмжээ авах.
- (xi) Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил нь хүний эрхийг хамгаалах, хүндэтгэх, хэрэгжүүлэхэд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх; үүнд цахим сүлжээтэй холбоотой боломж, эрсдэлийг багтаан тодорхойлох;
- (c) Хандлага: залуучууд дараах зүйлсийг илэрхийлдэг:
 - (i) Бүх хүний эрхэм чанар, хүний эрхийг хүлээн зөвшөөрөх үндсэн дээр өөрийгөө болон бусдыг хүндэтгэх, мөн хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах өөрсдийн хариуцлагыг ухамсарлах;
 - (ii) Олон янз байдлыг хүндэтгэж, үнэлэх; үүнд ялгаварлан гадуурхах агуулгагүй хэл яриа, хандлагыг илэрхийлэх, мөн арьс үндэс, арьсны өнгө, хүйс, нас, хэл, шашин, улс төр болон бусад үзэл бодол, үндэс, угсаа, нийгмийн гарал, эд хөрөнгө, төрсөн болон оршин суугаа газар, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, хүйсийн илэрхийлэл болон бусад шинжээр ялгаварлан гадуурхахын эсрэг байр суурь багтана.
 - (iii) Өөрийгөө эргэцүүлэн бодох, суралцахад нээлттэй байх; үүнд өөрийн өрөөсгөл ойлголт, хандлагаа ухамсарлаж, тэдгээрийг даван туулахыг зорино. Ингэснээр хүний эрхийн зарчимд нийцсэн хувийн зан үйлээ сайжруулахыг эрмэлзэнэ.
 - (iv) Хүний эрх болон шударга ёсны тухай холбогдох асуудалд идэвх сонирхолтой байх.
 - (v) Эрх, үүрэг, эрх тэгш байдал, олон янз байдал, ялгаварлан гадуурхахгүй байх, нийгмийн эв нэгдэл, соёл болон шашин хоорондын яриа хэлэлцүүлэг хоорондын уялдаа холбоог ойлгож, үнэлэх;
 - (vi) Эрхээ шаардах шаардах болон үүрэг хүлээгч талууд хүний эрхийг хамгаалах, хүндэтгэх, хэрэгжүүлэх ёстой гэсэн хүлээлтэд итгэлтэй байх;

- (vii) Хүний эрхийн зөрчил, шударга бус байдал, ялгаварлан гадуурхалтад өртөж буй, ялангуяа гадуурхалт болон эмзэг нөхцөл байдалд өртөмтгий бүлгүүдэд энэрэнгүй сэтгэлээр хандах, эв санааны нэгдэлтэй байх;
- (viii) Хүний эрхийг хамгаалах, хүний эрхийн зөрчлийг нүдээ анин өнгөрөхгүй байхад хүчин чармайлт гаргах;
- (ix) Хүн бүр бусадтай хамтран ажилласнаар хүний эрхийг тухайн орон нутаг болон олон улсын түвшинд ахиулахад бодитой хувь нэмэр оруулж чадна гэсэн итгэл үнэмшил; хүний эрхийн төлөө хамтран зүтгэхэд (жишээлбэл, манлайлагч, эвлэрүүлэн зуучлагч эсвэл хүний эрхийн идэвхтэн байдлаар) урам зоригтой оролцох;

28. Залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролын зохистой арга зүйг залуучууд өөрсдөө боловсруулж, дараах зүйлийг хамрах:

- (a) Залуучуудыг чадавхжуулах, тэдний идэвхтэй оролцоог дэмжих суралцагч төвтэй, жендэрийн мэдрэмжтэй, нөхцөл байдалд тохирсон арга зүй; тэдний үзэл бодол, хандлага, өрөөсгөл үзэл, давуу эрх, шүүмжлэлт сэтгэлгээ, өөр өнцгөөс харах чадварыг сорих үйл ажиллагааг зохион байгуулах, ялгаатай хэрэгцээ, чадамжийг харгалзан, албан болон албан бус боловсролын орчинд тохируулан хэрэгжүүлэх; залуусын олон төрлийн үзэл бодол, соёл, туршлагыг сонсож, төлөөллийг нь хангах оролцоот хандлага;
- (b) Залуучууд хүний эрхийн ойлголтыг өөрсдийн туршлагатай уялдуулан амьдралдаа хэрэглэх боломж бүхий туршилтад суурилсан сургалтын арга зүй, тухайлбал, олон нийтийн чиглэсэн үйлчилгээ болон гарааны бизнес эрхлэх, хүний эрхийн талаар орон нутгийн болон олон улсын түвшинд дуу хоолойгоо хүргэх, олон нийтийг зохион байгуулах, төрийн төлөөлөгчидтэй уулзалт хийх, залуучууд болон орон нутгийн иргэдийн дунд хүний эрхийн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх зэрэг үйл ажиллагаа багтана.
- (c) Үе тэнгийн сургалт — ихэвчлэн залуучуудын цуглардаг, аюулгүй, зарим тохиолдолд насанд хүрэгчдийн хяналтгүй орчинд сэтгэл хөдлөлийн холбоо, яриа хэлэлцээ, харилцан ойлголцлыг хөгжүүлэх боломжийг олгох; залуучуудын оролцоог оролтод чиглүүлж, тэдний дуу хоолойг чухалчлах; залуучуудын нийгмийн хөдөлгөөн, хүний эрхийн төлөөх идэвхтнүүд болон бусад манлайлагчдыг онцлох; ялгаварлан гадуурхалт болон эмзэг нөхцөл байдалд өртөмтгий үе тэнгийнхнээ хамруулахад онцгой үүрэг гүйцэтгэдэг залуучуудаар удирдуулсан байгууллагуудыг дэмжих, залуучуудын олон төрлийн туршлагад үндэслэх.

Үе тэнгийн сургалтын хандлагыг үе хоорондын эв нэгдлийг бэхжүүлэхийн тулд тэдний хоорондын яриа хэлэлцээ, хүний эрхийн кампанит ажил зэргээр энэхүү харилцан суралцах арга зүйтэй хамтатган хэрэгжүүлж болно
- (d) Бүх төрлийн суралцагчдыг хамруулах боломжтой, хамтын ажиллагаанд тулгуурласан спорт, кино, урлаг, соёл, тоглоом, түүх өгүүлэл, драм, жүжиг зэрэг төрөл бүрийн сонирхолтой сургалтын арга барил, орчинг ашиглах; эдгээр нь мэдлэг, манлайллын ур чадварыг хөгжүүлэх, соёл хоорондын эв нэгдлийг бэхжүүлэх, аюулгүй орчинд охид, эмэгтэйчүүдийг оролцуулж, эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих.

Эдгээр нь нийгмийн жендэрийн хэм хэмжээг авч үзэх, ялгаатай байдлаас үл хамааран залуучуудаар удирдуулсан хөтөлбөрүүдийг хөгжүүлэх, ялгаатай онцлог чанарыг ойлгохыг дэмжих байдлаар энх тайван, хүртээмжтэй, тэгш нийгмийг цогцлоох, багийн ажиллагаа, хамт олонч сэтгэлгээ, энэрэнгүй байдал, хүндлэлийг төлөвшүүлэх.

29. Заах болон суралцах хэрэглэгдэхүүн, дэмжлэг болон бусад нөөцтэй холбоотой үйл ажиллагаанд дараах зүйлс багтана:

- (a) Хүний эрхийн зарчмуудыг тухайн соёлын орчин, орон нутгийн түүхэн болон нийгмийн нөхцөл байдалд нийцүүлэн тусгасан, залуучуудын хэрэгцээнд тохирсон, тодорхой, тэдэнд хамаарал бүхий агуулгатай материал боловсруулах;
- (b) Залуучуудад зориулсан хүний эрхийн тогтвортой сургалтын хөтөлбөрийг бий болгох, сайжруулах, чанарыг нь хангах, хүний эрхийн боловсролын судалгаа, шинжилгээ хийх нөхцөлийг бүрдүүлэх, мөн НҮБ-аас гаргасан материалыг багтаан хүний эрхийн боловсролын материал цуглуулах, хуваалцах, орчуулах, нутагшуулах зорилгоор сургалтын болон нөөцийн төвүүдийг байгуулах буюу бэхжүүлэх;
- (c) Хүний эрхийн боловсролын хөтөлбөр, сайн туршлага, сургалтын арга зүй, үнэлгээний хэрэгсэл болон бусад нөөцийн талаарх мэдээлэл солилцох, бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэх зорилгоор үндэсний болон олон улсын сүлжээ байгуулж, мэдээлэл, туршлага хуваалцах боломжийг бүрдүүлэхийн тулд мэдээллийн технологийг залуучуудад хүртээмжтэй болгох; залуучуудад нээлттэй, цахим болон танхимын хосолмол хэлбэртэй, хүний эрхийн боловсролын хамтын нийгэмлэгийг холбосон цахим платформ, нөөц, материал агуулсан сургалтын вебсайт болон олон нийтийн платформуудыг ашиглах;
- (d) Сошиал медиа, вэбсайт дахь нөөц, цахим сургалтын хөтөлбөр, цахим хэлэлцүүлэг, олон нийтэд нээлттэй онлайн сургалт, веб хурал, зайны сургалт болон гар утасны аппликэйшн зэргийг ашиглан хүний эрхийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхэд технологи ашиглах;
- (e) Залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролыг дэмжих зорилгоор тэтгэлэг болон солилцооны хөтөлбөрүүдийг дэмжих;
- (f) Хүний эрхийн боловсролыг хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх залуучуудын зөвлөл, орон нутгийн залуучуудын бүтэц, байгууллагыг байгуулах буюу бэхжүүлэх; бүх түвшний бодлогод нөлөөлөх залуучуудын оролцоог хангах платформоор хангах;
- (g) Хөгжлийн бэрхшээл, төрөлх хэлний ялгаа зэрэг хүчин зүйлийг харгалзан, ялгаварлан гадуурхалт болон эмзэг нөхцөл байдалд өртөмтгий залуучуудыг нэн тэргүүнд анхаарч, хүртээмжтэй, сонирхол татахуйц сургалтын материалыг боловсруулахад онцгой ач холбогдол өгөх;

3. Багш бэлтгэх

30. Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн өмнөх үе шатууд нь боловсролын албан, албан бус болон албан ёсны бус хүний эрхийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцад оролцдог багш - төрийн албан хаагчид болон иргэний нийгмийн төлөөлөл байхаас үл хамааран - зохих ёсны сургалтаар хангахын чухлыг онцлон тэмдэглэж ирсэн.

31. Эхний болон хоёр дахь үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөнд багш нар, дээд боловсролын байгууллагын багш, боловсролын бусад ажилтнууд нь хүний эрхийн үнэт зүйлс, ур чадвар, хандлага, урам зориг, дадлыг түгээхэд мэргэжлийн үүргээ биелүүлэхийн зэрэгцээ үлгэр дуурайлал үзүүлэгчийн хувьд гол үүрэг, хариуцлага хүлээдэг болохыг онцолсон.

Иймээс энэхүү мэргэжлийн бүлгүүдэд хүний эрхийн талаарх мэдлэг, үнэт зүйлд тууштай байх хандлага, урам зоригийг төлөвшүүлэхэд чиглэсэн хүний эрх болон хүний эрхийн боловсролын арга зүйн талаар сургалт явуулах нь албан боловсролын тогтолцоонд хэрэгжих хүний эрхийн боловсролын хөтөлбөрийн тэргүүлэх бүрэлдэхүүн хэсэг юм.

32. Үүнийг албан бус боловсролын орчин дахь багш нар ч тэргүүлэх ач холбогдолтой гэж үзнэ.

Үе тэнгийн суралцах арга зүйд нийцүүлэн, бусдыг сургах залуучуудыг бэлтгэхийн тулд сургалтын тэргүүлэх чиглэлд багш, манлайлагч, залуучуудын төв болон байгууллагын төлөөлөл, идэвхтэн, сайн дурынхан зэрэг залуучуудыг хамруулах ёстой.

Мөн залуучууд багш нарт зориулсан сургалтын төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээний үйл явцад оролцох ёстой.

33. Багшийг зохистойгоор сургах стратегид дараах зүйлсийг багтаах ёстой: одоогийн туршлагын үнэлгээнд үндэслэсэн хүний эрхийн сургалтын цогц бодлого батлах; сургалтын хөтөлбөрт хүний эрх болон хүний эрхийн боловсролын зарчим, стандарт, мөн залуучуудын хүний эрхтэй холбоотой сурталчилгаа, нөлөөллийн ур чадварыг тусгах; зохих арга зүй, үнэлгээний арга хэрэгсэл төлөвшүүлэх; холбогдох нөөц бололцоог хөгжүүлэх; албан, албан бус болон албан ёсны бус орчны хамтын ажиллагааг хангах.

Дээрх бүх арга хэмжээний хүрээнд багш - ялангуяа залуу багш нар болон ялгаварлан гадуурхалт, эмзэг нөхцөл байдалд өртөмтгий бүлгийн багшийн - мэдлэг, туршлагыг онцолж, хүндэтгэх шаардлагатай.

34. Багш нарт зориулсан хүний эрхийн сургалтын цогц бодлогыг батлахдаа дараах зүйлсийг багтаах ёстой:

(a) Хүний эрхийн боловсрол, сургалтыг хүний эрхийг дэмжих, хамгаалахад чиглэсэн мэдлэг, ур чадвар, хандлага, зан үйлийг төлөвшүүлэх, чадавхжуулах үйл явц хэмээн олон улсын түвшинд зөвшилцөн баталсан тодорхойлолтыг хүлээн зөвшөөрч хэрэглэх;

(b) Сургалтын хэрэгцээ шаардлагыг үнэлсний үндсэн дээр тухайн хүний соёл, боловсрол, туршлагад тохируулан боловсруулсан, бүх багш нарт зориулагдсан

анхан болон ажлын байран дахь давтан сургалтад заавал хамруулах, мөн үүнийг одоо байгаа сургалтын хөтөлбөрт нэгтгэх;

- (c) Анхан болон ажлын байран дахь давтан сургалт явуулах багш нарыг чадавхжуулах сургалт зохион байгуулах; тэдгээр багш нар нь хүний эрхийн чиглэлээр мэргэшсэн, туршлагатай байхаас гадна суралцагчдын олон янз байдлыг төлөөлж байх ёстой;
- (d) Боловсролын ажилтнуудын мэргэжлийн зэрэг, магадлан итгэмжлэл, ажил мэргэжлийн өсөлтөд хүний эрхийн боловсролыг зайлшгүй шаардлага болгох, мөн багш бэлтгэх албан сургалт болон нийгмийн үйлчилгээ, эрүүл мэнд зэрэг залуучуудад чиглэсэн бусад мэргэжлийн сургалтын хөтөлбөрт хүний эрхийн боловсролыг тусгах;
- (e) Хүний эрхийн боловсролын чиглэлээр сургалт зохион байгуулж буй төрийн бус байгууллага болон иргэний нийгмийн бусад салбаруудыг хүлээн зөвшөөрч, дэмжлэг үзүүлэх;
- (f) Сургалтын хөтөлбөр болон түүний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт, стандартыг сайжруулах;
- (g) Хүний эрхийн сургалтыг үр дүнтэй явуулахад хүний эрхийн зарчим хэрэгждэг орчин шаардлагатай учраас багшид зориулан суралцах, ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх;
- (h) Ялангуяа залуу багш болон гадуурхал, эмзэг нөхцөл байдалд өртөмтгий бүлгийн багш нарт тогтмол дэмжлэг, мэргэжлийн зөвлөгөө, чиглүүлэг үзүүлэх;

35. Багш нарт зориулсан хүний эрхийн сургалтын хөтөлбөр дараах зүйлсийг агуулсан байна:

- (a) Хүний эрх болон хүний эрхийн боловсролтой холбоотой мэдлэг, ур чадвар, хандлага, зан үйлийг хамарсан суралцахуйн зорилтууд;
- (b) Дээр дурдсан I ба D хэсгийн “Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны зарчмууд”-д тусгагдсан зарчмууд;
- (c) Багш нарын ажиллаж буй орон нутгийн орчинд болон түүний гаднах хүрээнд үйлчилдэг хүний эрхийн зарчим, стандарт, хамгаалалтын механизм, мөн оршин буй нийгэмдээ хүний эрхийн асуудлыг шийдвэрлэхэд багш, суралцагчдын эдлэх эрх, оруулах хувь нэмэр;
- (d) Залуучуудын оролцоог дэмждэг, соёлын онцлогийг харгалзсан, оролцоог хангасан, суралцагч төвтэй, туршлагад суурилсан, үйл ажиллагаанд чиглэсэн хүний эрхийн боловсролын зохистой арга зүй;
- (e) Залуучуудын онцлогт нийцсэн тэдэнд тухайлан хамааралтай хүний эрхийн асуудлууд, жишээлбэл, залуучууд олон талт, огтлолцсон үнэмшил, шинж чанараасаа шалтгаалан давхардсан ялгаварлан гадуурхалтад өртөж болзошгүй байдлыг тусгах;
- (f) Хүний эрхийн зарчимд нийцсэн ардчилсан манлайллын хэв маяг, багшийн нийгмийн ур чадвар, соёл хоорондын болон шашин хоорондын яриа хэлэлцээний ур чадвар;

- (g) Мэдээллийн болон харилцаа холбооны технологи, цахим болон сошиал медиа зэрэг хүний эрхийн боловсролын одоо байгаа сургалтын болон сургалтын нөөцийн талаарх мэдээлэл, тэдгээрийг хянах, сонгох чадавхыг бэхжүүлэх, шинэ нөөцийг хөгжүүлэх;
- (h) Багшийн зааж буй хичээл, агуулгад хүний эрхийн боловсролыг хэрхэн уялдуулан нэгтгэх жишээнүүд;
- (i) Сэтгэл зүйн гэмтэлтэй тулгарах түүнээс дахин гэмтээхээс сэргийлэх, нийгэм-сэтгэл хөдлөлийн суралцах үйл явцыг тусгах, хохирогч бүлгийн дуу хоолойг анхаарлын төвд авч үзэх стратегиуд;
- (j) Багш нар залуучуудтай ажиллах үедээ өөрсдийн өрөөсгөл ойлголт, ялгавартай хандлагыг таних;
- (k) Залуучуудын ур чадварыг албан болон албан бус хэлбэрээр тогтмол бөгөөд сэдэлжүүлсэн суралцагчийг үнэлэх үнэлгээний арга зүй;
- (l) Боловсролын үйл ажиллагаанд залуучуудын оролцоог хангасан хэрэгцээ шаардлага үнэлгээ болон үнэлгээний үр дүнг тусгах;
- (m) Албан болон албан бус орчин, мөн орон нутгийн нөхцөл байдал, хүн амын онцлогт тохируулан сургалтын хөтөлбөрийг тохируулах;

36. Багш бэлтгэх сургалтын арга зүйд оролцоог хангах, суралцагч төвтэй, туршлагад суурилсан, үйлдэлд чиглэсэн хандлагууд багтах бөгөөд сургалтаар дамжуулан хүний эрхийн мэдрэмж, үйлдэлд чиглэсэн урам зориг, өөртөө итгэх итгэл, сэтгэл хөдлөлийн хөгжил зэргийг анхаарах шаардлагатай.

Цахим платформ нь суралцагчид өөрийн хурдаар суралцах, сургалтын нөөцөө хуваалцах, янз бүрийн орчин нөхцөлд мэдлэгээ тэлэх, нөлөөллийн үйл ажиллагаа, эвсэл холбоо байгуулахад оролцож буй бусад оролцогчдыг танин мэдэх, цахим сургалтын хөтөлбөрөөр суралцах боломжийг бүрдүүлдэг. Үнэлгээ нь сургалтын бүх үе шатанд тогтмол хэрэгжих шаардлагатай.²¹

4. Боломж олгох орчин

37. Залуучуудад зориулсан хүний эрхийн боловсрол нь албан, албан бус эсвэл албан ёсны бусад орчинд явагдаж байгаа эсэхээс үл хамааран гэр бүл (эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч болон бусад гэр бүлийн гишүүд), орон нутгийн хамт олон зэрэг суралцах орчин болон өргөн хүрээний нөлөөлөх орчин нь боловсролын үйл явцад зайлшгүй нөлөөлдөг.

38. Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг зохион байгуулах болон залуусыг идэвхтэй оролцуулахыг дэмжиж, энэ үйл ажиллагаанд оролцсоных нь төлөө хэн нэгэнд сөрөг хариу арга хэмжээ авахгүй байх баталгааг бүрэн хангах.

²¹ ХЭДКГ-ын “Төлөвлөлтөөс үр нөлөө рүү: Хүний эрхийн сургалтын арга зүйн гарын авлага” (Нью-Йорк ба Женева, 2019) бүтээлээс үзнэ үү. www.ohchr.org/Documents/Publications/training6en.pdf; ХЭДКГ болон Эквитас (Equitas) – Олон улсын хүний эрхийн боловсролын төвийн хамтран боловсруулсан “Хүний эрхийн сургалтын үйл ажиллагааг үнэлэх нь: Хүний эрхийн сурган хүмүүжүүлэгчдэд зориулсан гарын авлага” (Монреаль, 2011) бүтээлээс үзнэ үү. www.ohchr.org/Documents/Publications/EvaluationHandbookPT18.pdf.

Хариуцлагын механизм нь залуучуудын аюулгүй байдал, хүртээмжийг бүрэн хангах шаардлагатай.

Хүний эрхийн боловсрол нь улс төрийн нөлөөлөл, оролцооноос ангид, хараат бус байх ёстой.

39. Нийгэмд залуучуудын эрхийг хүндэтгэхтэй холбоотой онцгой сорилтууд тулгардаг бөгөөд мөн тэд олон талт, огтлолцсон шинж чанарынхаа улмаас давхардсан ялгаварлан гадуурхалтад өртөх эрсдэлтэй байдаг.²²

Залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролын үндэсний стратегийг залуучуудын хүний эрхийг хамгаалах, хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээтэй уялдуулан хэрэгжүүлэх ёстой; Үүнд залуучуудын гомдол гаргах, эрхээ хамгаалуулах боломжийг хангах хүртээмжтэй механизмыг хөгжүүлэх багтана.

Е. Үндэсний хэрэгжилтийг хангах үйл явц

40. Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийцүүлэн залуучуудад хүний эрхийн боловсрол олгох талаар уялдаа холбоотой, зохион байгуулалттай үндэсний стратегийг хэрэгжүүлэхэд НҮБ гишүүн улс орнуудаасаа тодорхой үүрэг амлалт авахыг шаарддаг.

Дэлхийн хөтөлбөрийн өмнөх үе шатуудад үндэсний хэмжээнд гарсан ахиц дэвшилд тулгуурлан стратегийг боловсруулах ёстой хэдий ч, залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролын үндэсний стратегийн хэрэгцээг үнэлэх, боловсруулах, хэрэгжүүлэх, дүн шинжилгээ хийх болон үнэлгээ хийхэд хангалттай хэмжээний хүний нөөц болон санхүүгийн нөөц шаардлагатай.

Үндэсний зохицуулах чиг үүрэг бүхий байгууллага энэ үйл явцыг манлайлан удирдах ёстой. Хэрэгжилтийг хангах гурван алхмыг энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал болгож байна.

1. Оролцогчид болон зохицуулалт

41. Эхний алхам болгон НҮБ-ын гишүүн улсууд холбогдох байгууллагуудыг оролцуулсан, залуучуудын төлөөллийг заавал багтаасан үндэсний зохицуулах байгууллага байгуулах талаарх санаачилгыг чиглүүлэх, эсвэл бусдын санаачилгыг дэмжих, хариу арга хэмжээ авах үүрэгтэй холбогдох хэлтэс, нэгжийг гол холбогч болгон томилох ёстой. Тус зохицуулах байгууллага нь тухайн улсын орон нутгийн залуучуудтай зөвлөлдөж ажиллах шаардлагатай.

Тус зохицуулах байгууллага нь шинээр байгуулагдаж болох бөгөөд эсвэл өмнөх байгууллагад үндэслэн үргэлжлүүлэн ажиллаж болно. Энэ нь үйл ажиллагааны зохицуулалт, мэдээлэл солилцоо, нөөцийг нэмэгдүүлж, хүчин чармайлт буюу чиг үүргийн давхардлаас зайлсхийхэд чиглэнэ.

²² “Залуучууд ба хүний эрх” тайлан (А/НRC/39/33)-д НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссар залуучууд эрхээ эдлэхэд тулгарч буй сорилт, ялгаварлан гадуурхалтын талаар тайлбарласан.

Гишүүн улс орнууд холбогдох бүх талуудын оролцоог хангах боломжийг бүрдүүлэх ёстой. Үндэсний зохицуулах чиг үүрэг бүхий байгууллагын бүрэлдэхүүнд нь тухайн улсын залуучуудын олон янз байдал, тэр дундаа ялгаварлан гадуурхалт болон эмзэг нөхцөл байдалд өртөмтгий бүлгийн залуусыг хамруулсан байна

42. Үндэсний зохицуулах байгууллагад дараах үндэсний оролцогч талууд заавал оролцсон байх ёстой:

- (a) Холбогдох яамд (боловсрол, залуучууд, шударга ёс гэх мэт) болон орон нутгийн холбогдох байгууллагууд;
- (b) Үндэсний хүний эрхийн байгууллагууд;
- (c) Залуучуудын төлөөлөл (залуучуудаар удирдуулсан байгууллага, сүлжээ, зөвлөл, сайн дурын бүлгүүд), үүнд залуу хүний эрх хамгаалагчид болон гадуурхагдсан, эмзэг нөхцөлд өртөмтгий бүлгийн залуусын төлөөлөл орно;
- (d) Хүний эрх, хүний эрхийн боловсрол, боловсрол, залуучууд, энх тайван ба тогтвортой хөгжил зэрэг чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллага, сүлжээ;
- (e) Ерөнхий боловсрол, дээд боловсрол болон мэргэжлийн боловсролын байгууллагын төлөөлөл, үүнд багш бэлтгэдэг байгууллага, судалгааны хүрээлэнгүүд, мөн багш нарын холбоо, үйлдвэрчний эвлэлүүд багтана.

43. Бусад оролцогч талуудад нийгмийн үйлчилгээ үзүүлэгчид, хэвлэл мэдээллийн байгууллагууд, олон нийтийн болон шашны удирдагчид, сургуулийн эцэг эхийн зөвлөлүүд, эцэг эх-багш нарын холбоо, хувийн хэвшил, хандивлагчид, эрүүл мэнд болон сэтгэл зүйн эрүүл мэндийн мэргэжилтнүүд, сошиал медиа нөлөөлөгчид болон шаардлагатай бусад оролцогч орж болно.

44. Тухайн улсад үйл ажиллагаа явуулж буй НҮБ-ын болон бусад засгийн газар хоорондын байгууллагын төлөөлөгчид үндэсний зохицуулах байгууллагын хуралд оролцож болно.

45. Үндэсний зохицуулах байгууллага нь гэрээний байгууллагууд, тусгай журмууд, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг зэрэг НҮБ-ын хүний эрхийн тогтолцоонд тайлан гаргах үүрэг бүхий үндэсний агентлагуудтай хамтран ажиллаж, энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд хүний эрхийн боловсролын чиглэлээр гарсан ахиц дэвшлийг эдгээр тайланд тусгахад анхаарна.²³

Мөн ХЭДКГ-тай уялдаа холбоотой ажиллаж, үндэсний хэмжээнд гарсан ахиц дэвшлийн талаарх мэдээллийг хуваалцах ёстой.

²³ Жишээлбэл, ЮНЕСКО-гийн 1974 оны “Олон улсын ойлголцол, хамтын ажиллагаа, энх тайвны төлөөх боловсрол болон хүний эрх, үндсэн эрх чөлөөтэй холбоотой боловсролын тухай” зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьдаг тус байгууллагын тусгай механизм байдаг.

2. Хэрэгжүүлэх алхмууд

46. Үндэсний зохицуулах байгууллага нь залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролын үндэсний стратегийн хэрэгцээг үнэлэх, боловсруулах, хэрэгжүүлэх, дүн шинжилгээ хийх, үнэлэх үйл явцыг манлайлан удирдаж, хяналт тавих үүрэг хүлээнэ; энэ зорилгод хүрэх гурван алхмыг доор товчлон дурдсан байна.

47. Үндэсний стратегийн бүхий л үе шатанд залуучуудыг гол түншээр оролцуулах нь зайлшгүй чухал бөгөөд тэдэнд санаачилгатайгаар манлайлах боломжийг олгох ёстой.

Залуучуудыг оролцуулах боломжит хэлбэрүүдийг шинээр бий болгох, эсвэл бэхжүүлэх шаардлагатай; үүнд хүний эрхийн боловсролын чиглэлээр залуучуудын зөвлөл, ажлын хэсэг байгуулах зэрэг орно. Мөн залуучууд санал бодлоо илэрхийлэх тогтмол хамтран ажиллагчид байх ёстой. Жишээлбэл, боломжтой тохиолдолд түгээмэл сошиал платформуудыг ашиглан үндэсний хэмжээний цахим болон цахим бус асуулгыг хослуулан зохион байгуулах боломжтой.

Залуучуудын олон янзын дуу хоолойг багтаах ёстой.

Алхам 1 – Залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролын үндэсний суурь судалгаа хийх

48. Алхам 1-д дараах үйл ажиллагаанууд багтах ёстой:

(a) Өргөн хүрээний зөвлөлдөх уулзалтуудын үндсэн дээр үндэсний үнэлгээний судалгаа хийх чиг үүрэг бүхий байгууллагыг томилох; судалгаа дуусмагц хэвлэн нийтэлж, нийтэд түгээх

Судалгаанд дараах асуудалд дүн шинжилгээ хийх шаардлагатай:

- (i) “Бүрэлдэхүүн хэсгүүд” II ба D хэсэгт дурдсан дөрвөн үндсэн чиглэл (бодлого болон хэрэгжүүлэх арга хэмжээ; сургалт, сургалтын үйл явц ба хэрэглэгдэхүүн; багш бэлтгэх; боломж олгох орчин)-ийн хүрээнд үндэсний хэмжээнд залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролын өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх; үүнд одоо хэрэгжиж буй санаачилга, сайн туршлага, сул тал, саад бэрхшээлүүдийг хамруулж, ялангуяа залуусын өөрсдийн санаачилсан төсөл, хөтөлбөрт онцгойлон анхаарах;
- (ii) Залуучуудын мэдлэг, ур чадвар, хандлага, зан чанарт тулгуурласан судалгаанд үндэслэн тэдний хүний эрхийн талаарх суралцах хэрэгцээг тодорхойлох;
- (iii) Залуучуудын хүний эрхийн боловсролд нөлөөлж болох түүхэн болон соёлын нөхцөл байдал, үүнд залуучуудын хүний эрхийн нөхцөл байдал болон тэдний оролцоо, идэвхийг хязгаарлаж буй саад бэрхшээлүүдийг багтаан судлах;
- (iv) Орон нутаг, бүс нутаг болон олон улсын түвшинд хэрэгжиж буй туршлага, арга зүй, нөөц, хэрэглэгдэхүүн;
- (v) Албан, албан бус болон албан ёсны бус боловсролын хүрээнд оролцож буй олон талт оролцогчдын оролцоо;

- (vi) Тухайн улсад байж болох холбогдох боловсролын төрөл (тогтвортой хөгжил, энх тайвны боловсрол, дэлхийн боловсрол, иргэний боловсрол зэрэг), тэдгээрийн Чиг үүрэг, агуулга, арга зүй
- (b) II.D хэсэгт дурдсан дөрвөн бүрэлдэхүүн хэсгийн аль үйл ажиллагаа нь ямар хэмжээнд хэрэгжсэн байгааг тодорхойлох;
- (c) Одоогийн хэрэгжиж буй санаачилга, сайн туршлага, сургамж дээр хэрхэн тулгуурлах боломжуудыг хэрхэн ашиглах, мөн сул тал, саад бэрхшээлийг шийдвэрлэхэд шаардлагатай арга хэмжээг тодорхойлон авч үзэх;

49. Алхам 1-ийн үр дүнд дараах зүйлсийг агуулна:

- (a) Залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролын үндэсний суурь судалгаа;
- (b) Суурь судалгааны үр дүнг олон нийтэд түгээх үндэсний кампанит ажил зохион байгуулах; үүнд цахим болон уламжлалт хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, сурталчилгааны материал, бага хурал, олон нийтийн хэлэлцүүлэг зэргийг ашиглаж болно.

Ялангуяа үр дүнг залуучуудад зориулсан орон зай, платформуудад хүргэхэд онцгойлон анхаарах;

Алхам 2 – Залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролыг дэмжих үндэсний стратеги боловсруулах

50. Алхам 2-д дараах үйл ажиллагаанууд багтах ёстой:

- (a) Үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэс болгон үндэсний суурь судалгаанд тулгуурлаж 2020–2024 он буюу түүнээс цааш үргэлжлэх үндэсний стратегийн зорилгыг тодорхойлох;
- (b) Суурь судалгааны үр дүнд үндэслэн хамгийн тулгамдсан хэрэгцээ болон боломжуудыг харгалзан тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох; нэг удаагийн, түр зуурын үйл ажиллагаа бус, тогтвортой өөрчлөлт авчрах бодит үр нөлөөтэй арга хэмжээнд төвлөрөх бөгөөд ялангуяа ялгаварлан гадуурхалт болон эмзэг нөхцөл байдалд өртөмтгий бүлгийн залуучуудад онцгойлон анхаарах;
- (c) Дараах зүйлсийг тодорхойлон үндэсний стратегийг боловсруулах:
 - (i) Нөөц: шаардлагатай хүний нөөц, санхүүгийн эх үүсвэр болон хугацаа;
 - (ii) Үйл ажиллагаа: гүйцэтгэх үүрэг, хариуцлага болон цаг хугацааны төлөвлөлт;
 - (iii) Зохицуулалтын механизм;
 - (iv) Үр дүн (жишээлбэл, хууль тогтоомж, сургалтын материал, сургалтын хөтөлбөр гэх мэт);
 - (v) Стратегийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах, эсвэл боломж олгох орчныг бүрдүүлэхийн тулд шинэчлэх шаардлагатай хууль, бодлого, хөтөлбөрүүд;
 - (vi) Хүрэх үр дүн болон тэдгээрийг хэмжих тоон ба чанарын үзүүлэлтүүдийг хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд тодорхойлох.

51. Алхам 2-ын үр дүн нь 2020–2024 он болон цаашдын хугацаанд хэрэгжих зорилго, тэргүүлэх чиглэл, үр дүнг тодорхойлсон, залуучуудад ойлгомжтой хэлээр бичигдсэн тэдэнд зориулсан хүний эрхийн боловсролын үндэсний стратеги байна. Энэхүү стратегийг холбогдох байгууллагууд болон оролцогч талууд, ялангуяа залуучуудын дунд өргөнөөр түгээх ёстой.

Алхам 3 – Үндэсний стратегийг хэрэгжүүлэх, хянах болон үнэлэх

52. Алхам 3-д дараах үйл ажиллагааг хамруулна:

- (a) Төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- (b) Үндэсний стратегийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
- (c) Стратегийг хэрэгжүүлэх явцын ахиц дэвшил болон тулгарч буй сорилтуудын талаарх мэдээллийг хүлээн зөвшөөрч, түгээх;

53. Үндэсний зохицуулах байгууллага үндэсний стратегийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, үнэлгээний тайланг олон нийтэд нээлттэй болгох ёстой.

Үнэлгээ нь оролцоог хангасан, ил тод, хүний эрхийн үнэт зүйлсийг тусгасан; “Бүрэлдэхүүн хэсгүүд” II.D хэсэгт дурдсан залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролын дөрвөн чиглэлд үнэлгээ хийхээс гадна дараах асуудлуудыг хамрах ёстой:

- (a) Үндэсний стратеги дахь залуучуудын оролцоо, манлайлал;
- (b) Үндэсний стратегийн хэрэгжилтийн газарзүйн хамрах хүрээ;
- (c) Ялгаварлан гадуурхалт болон эмзэг нөхцөл байдалд өртөмтгий залуучуудыг хамруулсан байдал;
- (d) Боловсролын салбараас гадуурх салбар хоорондын хамтын ажиллагаа;

54. Алхам 3-ын үр дүн нь үндэсний стратегид тодорхойлсон үр дүнгүүд байна.

F. Олон улсын хамтын ажиллагаа

1. Хүний Эрхийн Зөвлөлд тайлагнах нь

55. Гишүүн улсууд 2022 онд ХЭДКГ-т дунд хугацааны үндэсний явцын тайлан ирүүлнэ. ХЭДКГ нь ирүүлсэн бүх мэдээллийг нэгтгэн Хүний Эрхийн Зөвлөлд тайлагнана.

2025 оны эхээр гишүүн улсууд ХЭДКГ-т эцсийн үндэсний үнэлгээний тайлангаа ирүүлнэ. Улмаар ХЭДКГ нь дөрөвдүгээр үе шатны хэрэгжилтийн талаарх эцсийн тайланг боловсруулан, 2025 оны эцэст Хүний Эрхийн Зөвлөлд танилцуулна.

Холбогдох оролцогч талуудыг хамруулсан хэрэгжилтийн явцын хэлэлцүүлгийг Хүний Эрхийн Зөвлөлийн холбогдох чуулганы үеэр зохион байгуулж болно.

2. Олон улсын дэмжлэг

56. Олон улсын хамтын нийгэмлэг нь үндэсний стратегийн хэрэгжилт болон бүс нутгийн болон олон улсын түвшинд хэрэгжиж буй холбогдох үйл ажиллагааг дэмжих ёстой.

57. НҮБ-ын хүний эрхийн тогтолцооны байгууллагууд өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж буй үндэсний хүчин чармайлтыг дэмжин ажиллаж болно.

НҮБ-ын гэрээний байгууллагууд гишүүн улсуудын тайланг хэлэлцэх үедээ залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролтой холбоотой гэрээний заалтын хэрэгжилтийг хянаж, зөвлөмж өгөх боломжтой.

Хүний Эрхийн Зөвлөлийн сэдэвчилсэн болон улс орон хариуцсан тусгай журамтай этгээдүүд өөрсдийн онцгой эрхийн хүрээнд холбогдох ахиц дэвшлийг хянаж, зөвлөмж өгч болно.

Залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролын үндэсний хүчин чармайлтыг Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн хүрээнд тогтмол авч үзэх ёстой.

58. Олон улсын хамтын ажиллагаа болон дэмжлэгийг дараах байдлаар үзүүлж болно:

- (a) НҮБ-ын тогтолцоо, түүний төрөлжсөн байгууллагууд, НҮБ-ын Их сургууль болон НҮБ-ын мандаттай Энх тайвны их сургууль багтана;
- (b) Нийгмийн халамж, эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээ, мансууруулах бодис болон хүний наймаанаас урьдчилан сэргийлэх, дүрвэгсэд ба шилжилт хөдөлгөөн, зөрчил мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, энх тайван тогтоох, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, НҮБ-тай харьяа мэргэжлийн сургалтын байгууллагууд;
- (c) Бусад олон улсын болон бүс нутгийн засгийн газар хоорондын байгууллагууд;
- (d) Холбогдох олон улсын, бүс нутгийн болон үндэсний мэргэжлийн сүлжээ, холбоо, үйлдвэрчний эвлэлүүд;
- (e) Дээд боловсролын байгууллагууд, үндэсний хүний эрхийн байгууллагууд болон/эсвэл төрийн бус байгууллагуудын олон улсын, бүс нутгийн болон үндэсний сүлжээ;
- (f) Олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн талаарх нөөц болон баримтжуулалтын төвүүд;
- (g) Олон улсын болон бүс нутгийн санхүүгийн байгууллагууд, хоёр талт санхүүжилтийн агентлагууд;
- (h) Олон талт болон хоёр талт хөгжлийн агентлагууд;
- (i) Үндэстэн дамнасан корпорациуд болон тэдгээрийн сүлжээ;

59. Нөөцийг дээд хэмжээнд ашиглах, давхардлыг арилгах, уялдаа холбоог хангахын тулд оролцогч талууд нягт хамтран ажиллах нь нэн чухал.

60. Дээр дурдсан байгууллага, институтүүд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж болно:

- (a) Үндэсний стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ болон үнэлгээ хийхэд гишүүн улсууд болон үндэсний зохицуулах байгууллагад дэмжлэг үзүүлэх;
- (b) Үйл ажиллагаанд оролцож буй үндэсний болон орон нутгийн оролцогч бусад талуудыг, ялангуяа төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо, дээд боловсролын байгууллага, үндэсний хүний эрхийн байгууллага болон иргэний нийгмийн бусад байгууллагуудыг дэмжих;
- (c) Сайн туршлагын талаах мэдээллийг олж тогтоох, цуглуулах, түгээх, тухайлбал мэдээллийн сан, шагнал урамшуулал олгох, бэлэн байгаа материал, холбогдох байгууллага, хөтөлбөрийн талаарх мэдээлэл солилцох үйл ажиллагааг бүх түвшинд дэмжих,;
- (d) Залуучуудад зориулсан чадавх бэхжүүлэх хөтөлбөрийг дэмжих болон/эсвэл хэрэгжүүлэх; ялангуяа залуучуудын багш нарыг хүний эрхийн чиглэлээр сургах, холбогдох арга хэмжээнд залуучуудын оролцоог хангах, мөн сайн туршлагад үндэслэсэн сургалтын материалыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх;
- (e) Хүний эрхийн боловсрол, сургалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй залуучуудын одоогийн харилцаа холбоог дэмжих, бүх түвшинд шинээр бий болгохыг хөхиүлэн дэмжих, түгээн дэлгэрүүлэх;
- (f) Залуучууд болон залуучуудын байгууллагуудад зориулан санхүүгийн дэмжлэг болон бусад нөөцийг олгох;

ХАВСРАЛТ

**ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛИЙН 2019
ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 26-НЫ ӨДРИЙН
42/7 ДУГААР ТОГТООЛ: ХҮНИЙ
ЭРХИЙН БОЛОВСРОЛЫН ДЭЛХИЙН
ХӨТӨЛБӨРИЙН ДӨРӨВДҮГЭЭР
ҮЕ ШАТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТЛАХ ТУХАЙ**

42/7. Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр: Дөрөвдүгээр үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай

Хүний Эрхийн Зөвлөл нь НҮБ-ын дүрмийн зорилго, зарчмуудыг удирдлага болгон, Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт болон бусад олон улсын хүний эрхийн баримт бичигт тусгасны дагуу боловсрол нь хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх хандлагыг бэхжүүлэхэд чиглэсэн байх ёстой бөгөөд үүнийг улс орнууд биелүүлэх үүрэгтэйг дахин нотолж,

Ерөнхий Ассамблейн 2004 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 59/113 А дугаар тогтоолоор Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийг тунхагласныг, мөн 2006 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 60/251 дугаар тогтоолоор Хүний Эрхийн Зөвлөл нь хүний эрхийн боловсрол, сургалтыг дэмжих үүрэгтэй гэж шийдвэрлэснийг сануулж,

Ерөнхий Ассамблейн 2011 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 66/137 дугаар тогтоолоор баталсан Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай НҮБ-ын Тунхаглалыг дахин нотолж,

Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөртэй холбоотой өмнө нь баталсан тогтоолуудыг сануулж,

Мөн Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр нь бүх салбарт хүний эрхийн боловсролын хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг ахиулах зорилготой, үе шаттайгаар хэрэгждэг тасралтгүй санаачилга болохыг, улс орнууд өмнөх үе шатны хэрэгжилтийг үргэлжлүүлэхийн зэрэгцээ одоогийн үе шатыг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авах ёстойг сануулж,

Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн эхний үе шат нь хүний эрхийн боловсролыг бага болон дунд боловсролын тогтолцоонд нэгтгэхэд, хоёр дахь үе шат нь дээд боловсрол дахь хүний эрхийн боловсрол болон багш, сурган хүмүүжүүлэгч, төрийн албан хаагч, хууль сахиулагч, цэргийн албан хаагчдад зориулсан хүний эрхийн сургалтад, гурав дахь үе шат нь эхний хоёр үе шатын хэрэгжилтийг улам гүнзгийрүүлэх болон хэвлэл мэдээллийн салбарын ажилтнууд, сэтгүүлчдэд зориулсан хүний эрхийн сургалтыг дэмжихэд тус тус чиглэсэн болохыг хүлээн зөвшөөрч,

Хүний Эрхийн Зөвлөлийн 2018 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 39/3 дугаар тогтоолоор дэлхийн хөтөлбөрийн дөрөвдүгээр үе шатны зорилтот бүлэг болгон залуучуудыг онцлон авч үзэх, мөн уг үе шатыг Тогтвортой хөгжлийн зорилтууд 2030-тай, тэр дундаа ТХЗ-ийн 4.7 дугаар зорилтот үзүүлэлттэй уялдуулах шийдвэрийг Зөвлөл гаргаж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн дээд комиссарын газарт дөрөвдүгээр үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах үүрэг өгснийг сануулж,

НҮБ-аас залуучуудын эрхийг хамгаалах, дэмжих, тэдний улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, тэр дундаа хүний эрхийн боловсрол олгох хүчин чармайлтыг нэмэгдүүлэх үүрэг хүлээх талаарх Ерөнхий нарийн бичгийн даргын 2018 оны 9 дүгээр сард гаргасан санаачилгыг тэмдэглэж,

1. Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн дөрөвдүгээр үе шатны (2020–2024) үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг талархан хүлээн авч, уг төслийг боловсруулахдаа НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар нь улс орнууд, холбогдох засгийн газар хоорондын байгууллагууд, үндэсний хүний эрхийн байгууллагууд, иргэний нийгэм болон залуучуудтай зөвлөлдөн ажилласныг сайшаан тэмдэглэв;
2. Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн дөрөвдүгээр үе шатны (2020–2024) үйл ажиллагааны төлөвлөгөөг батлав;
3. Бүх улс орон болон холбогдох оролцогч талуудыг Дэлхийн хөтөлбөрт нийцүүлэн санаачилга хэрэгжүүлэхийг уриалж, ялангуяа өөрсдийн чадавхын хүрээнд дөрөвдүгээр үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхийг уриалав; мөн улс орнуудыг үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасны дагуу дунд хугацааны явцын тайлан болон үндэсний эцсийн үнэлгээний тайлангаа Хүний эрхийн дээд комиссарын газарт ирүүлэхийг уриалж байна;
4. Улс орнууд болон холбогдох оролцогч талуудыг Дэлхийн хөтөлбөрийн дөрөвдүгээр үе шатны хүрээнд өмнөх гурван үе шатыг хэрэгжүүлэх хүчин чармайлтаа эрчимжүүлж, бүх үе шатыг хамарсан үйл ажиллагааг өөрсдийн хэмжээнд хэрэгжүүлэх замаар дэмжихийг уриалав;
5. Хүний эрхийн дээд комиссарын газрыг ЮНЕСКО, Ерөнхий нарийн бичгийн даргын Залуучуудын асуудал хариуцсан төлөөлөгчийн газар, НҮБ-ын Хүүхдийн сан, Хөгжлийн хөтөлбөр, Хүн амын сан зэрэг холбогдох НҮБ-ын байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхийг дэмжих, хүсэлт гаргасан тохиолдолд техникийн туслалцаа үзүүлэх, холбогдох олон улсын хүчин чармайлтыг уялдуулахыг хүсэв;
6. НҮБ-ын тогтолцооны холбогдох байгууллага, агентлагууд болон бусад олон улсын болон бүс нутгийн засгийн газар хоорондын болон төрийн бус байгууллагуудад хандан, өөрсдийн эрх мэдлийн хүрээнд тус үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхийг дэмжих, мөн хүсэлт гаргасан тохиолдолд техникийн туслалцаа үзүүлэхийг уриалав;
7. Бүх үндэсний хүний эрхийн байгууллагуудыг үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийцүүлэн хүний эрхийн боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг уриалав;
8. Хүний эрхийн дээд комиссарын газар, ЮНЕСКО, Ерөнхий нарийн бичгийн даргын Залуучуудын асуудал хариуцсан төлөөлөгчийн газар болон НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагад хандан үйл ажиллагааны төлөвлөгөөг улс орнууд, засгийн газар хоорондын болон төрийн бус байгууллагууд, үндэсний хүний эрхийн байгууллагууд, иргэний нийгмийн хүрээнд өргөнөөр түгээхийг хүсэв;
9. Улс орнуудыг Дэлхийн хөтөлбөрийн гуравдугаар үе шатны үндэсний үнэлгээний тайлангаа бэлтгэж, 2020 оны 4 дүгээр сарын дотор Хүний эрхийн дээд комиссарын газарт ирүүлэх шаардлагатайг сануулав;
10. Үндэсний үнэлгээний тайлангуудад үндэслэн Дэлхийн хөтөлбөрийн гуравдугаар үе шатны хэрэгжилтийн талаарх эцсийн тайланг боловсруулж, Хүний Эрхийн Зөвлөлийн дөчин тавдугаар чуулганд танилцуулахыг Хүний эрхийн дээд комиссарын газарт даалгав;

11. Дэлхийн хөтөлбөрийн хэрэгжилтийг 2022 онд дүгнэн авч үзэхээр шийдвэрлэж, Хүний эрхийн дээд комиссарын газарт хандан одоо байгаа нөөц бололцооны хүрээнд Дэлхийн хөтөлбөрийн дөрөвдүгээр үе шатны хэрэгжилтийн дунд хугацааны явцын тайланг бэлтгэн, Хүний Эрхийн Зөвлөлийн тавин нэгдүгээр чуулганд танилцуулахыг хүсэв;

12. Мөн Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай НҮБ-ын Тунхаглалын 10 жилийн ойг тэмдэглэх зорилгоор “Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай НҮБ-ын Тунхаглалын 10 жилийн ой: сайн туршлага, сорилтууд ба цаашдын чиг хандлага” сэдвээр өндөр түвшний хэлэлцүүлгийг Хүний Эрхийн Зөвлөлийн дөчин наймдугаар чуулганы үеэр зохион байгуулахаар шийдвэрлэв; хэлэлцүүлэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бүрэн хүртээмжтэй байх ёстой гэж үзэж, хэлэлцүүлгийн товч тайланг бэлтгэн, Хүний Эрхийн Зөвлөлийн дөчин есдүгээр чуулганд танилцуулахыг Хүний эрхийн дээд комиссарын газарт даалгав.

*39 дүгээр хуралдаан
2019 оны 9 дүгээр сарын 26*

[Санал хураалтгүйгээр батлав.]



Ерөнхий Ассамблей

Түгээлт: Ерөнхий
2024 оны 8 сарын 19

Эх бичвэр: Англи хэл

Хүний эрхийн зөвлөл

Тавин долоо дахь хурал

2024 оны 9 сарын 9-нөөс аравдугаар сарын 9
Хөтөлбөрийн хэлэлцэх асуудал 2 ба 3

**НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын жилийн
тайлан, Дээд комиссарын газар, Ерөнхий нарийн
бичгийн даргын тайлан**

**Хүний бүх эрх, иргэний болон улс төр, эдийн засаг,
нийгэм, соёлын эрх, тэр дундаа хөгжих эрхийг
түгээн дэлгэрүүлэх, хамгаалах**

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫН ДЭЛХИЙН ХӨТӨЛБӨР ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАВ ДАХЬ ҮЕ ШАТНЫ (2025-2029) ТӨЛӨВЛӨГӨӨ НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрын тайлан*

Хураангуй

Хүний эрхийн зөвлөл 54/7 тоот тогтоолоор НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газарт (ХЭДКГ) Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн тав дахь үе шат (2025-2029)-ны үйл ажиллагааны төлөвлөгөөг бэлтгэхийг хүссэн. Нэгдсэн Үндэстний Байгууллагын холбогдох баримт бичгүүд, төрөл бүрийн оролцогч талуудтай зөвлөлдсөний үндсэн дээр үйл ажиллагааны төлөвлөгөөний хамрах хүрээ, үндэслэл, тодорхой зорилт, үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг, тэдгээрийг хэрэгжүүлэх алхмыг энэ тайланд тодорхойлсон.

* илгээсэн албанаас үл хамаарах техникийн шалтгааны улмаас эцсийн хугацаа өнгөрсөн ч энэ тайланг хурлын дараа хүргүүлсэн.



GE.24-13438 (E)

I. Танилцуулга

1. Хүний эрхийн зөвлөл 54/7 тоот тогтоолоороо Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн тав дахь үе шат (2025-2029 он) нь хүүхэд залуучуудад илүүтэй чиглэж, хүний эрх болон цахим технологи, байгаль орчин болон уур амьсгалын өөрчлөлт, жендэрийн тэгш байдлыг хангахад онцгойлон анхаарч ажиллахаар шийдвэрлэсэн. Зөвлөл нь НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газарт (ХЭДКГ) үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, Зөвлөлийн тавин долдугаар хуралд өргөн мэдүүлэхийг хүссэн.

2. Энэ тайланд ХЭДКГ нь үйл ажиллагааны төлөвлөгөөний хамрах хүрээ, үндэслэл, тодорхой зорилт, үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэх алхмуудыг тодорхойлсон. Уг тайланг боловсруулахдаа НҮБ-ын холбогдох хүний эрхийн гэрээ болон баримт бичгүүд, Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн өмнөх үе шатуудын үйл ажиллагааны төлөвлөгөө, ХЭДКГ болон НҮБ-ын бусад байгууллагаас нийтэлсэн материал, хүүхэд, залуучуудын оролцоотой болон НҮБ-ын тэргүүлсэн санаачилгуудад үндэслэсэн. Эдийн засаг болон Нийгмийн Зөвлөл “Залуучуудын Форум 2024”-ийн хүрээнд залуучуудын хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд НҮБ-ын байгууллагууд, иргэний нийгмийн байгууллага, сүлжээнүүд, хүүхэд, залуучуудын төлөөллийг оролцуулсан шинжээчдийн уулзалт хийх зэргээр нэмж арга хэмжээ авсан. ХЭДКГ нь 2024 оны 5 дугаар сарын 10-нд гишүүн улс орон, НҮБ-ын байгууллагууд, хүний эрхийн үндэсний байгууллага болон иргэний нийгмийн байгууллагуудад нэгтгэн боловсруулсан бичвэрийг тарааж, 2024 оны 6 дугаар сарын 24 гэхэд энэхүү тайланг боловсруулахад анхааран үзэх 34 санал хүлээн авсан.

II. Хүрээ

3. Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн ерөнхий шүхэр дор 2025-2029 он хүртэлх үйл ажиллагааны хөтөлбөр нь олон улсад хүлээн зөвшөөрсөн зарчмуудад үндэслэн хүүхэд, залуучуудын хүний эрхийн боловсролын стратегийг¹ үндэсний хэмжээнд өөрийн онцлогт тохируулан албан болон албан бус боловсролын аль алинд нь² хэрэглэх удирдамж болно. Энэ нь зорилт, бүрэлдэхүүн хэсэг, хэрэгжүүлэх арга хэмжээ, практик алхам, холбогдох оролцогчдыг тодорхойлно.

¹ Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд “үндэсний” гэдэг үгийг шаардлагатай тохиолдолд бүс нутгийн түвшин болон уугуул ард түмнүүдийг хамруулан ойлгоно.

² Албан ёсны боловсрол гэдэг нь “төрийн байгууллага болон албан ёсоор бүртгэгдсэн хувийн байгууллагуудаар зохион байгуулж, санаатай бөгөөд төлөвлөгдсөн боловсрол” юм; албан бус боловсрол гэдэг нь “албан ёсны боловсролын нэмэлт, сонголт буюу нөхөх хэлбэрээр хувь хүний амьдралын туршийн суралцах үйл явцад оролцдог, байгууллагын түвшинд зохион байгуулагдсан, санаатай бөгөөд төлөвлөгдсөн боловсрол” бөгөөд үүнд иргэний нийгмийн байгууллагуудын явуулдаг боловсролын үйл ажиллагаа орно (ЮНЕСКО-гийн нэр томъёоны толь бичгээс, <http://uis.unesco.org/en/glossary>).

4. 2005 оноос хэрэгжиж эхэлсэн Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн ерөнхий танилцуулга, түүний дотор үндэслэл, зорилт, тодорхойлолт, хүний эрхийн боловсролын талаарх зарчмуудыг Хүний эрхийн зөвлөлөөс баталсан дөрөвдүгээр үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1-10 дугаар зүйлд тусгасан.³ Тус танилцуулга хүний эрхийн боловсролын үйл хэргийн залгамж болох ёстой. Хэдийгээр энэхүү тайланд уг асуудлыг дахин авч үзээгүй хэдий ч энэ үйл ажиллагааны төлөвлөгөөний салшгүй хэсэг гэж үзэх нь зүйтэй.

5. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 1 дүгээр зүйлд хүүхэд гэж “18 нас хүрээгүй хүн бүр” гэж тодорхойлсон.

6. Залуучуудын талаар олон улсын хэмжээнд зөвшилцөлд хүрсэн тодорхойлолт байдаггүй.⁴ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газар статистикийн зорилгоор “залуучууд” гэж 15-24 насны хүмүүс, харин Аюулгүйн зөвлөл нь 18-29 насны хүмүүсийг тодорхойлдог (2250 тоот тогтоол (2015), энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөнд НҮБ-ын байгууллагууд, түүнчлэн улс орнуудын бусад тодорхойлолтыг аливаа урьдчилсан саналгүйгээр хүлээн зөвшөөрдөг.

7. Насны шалгуураас гадна хүүхэд, залуучууд гэдэг нь хоёулаа өөрчлөгддөг, нэгэн хэв шинжийн бус ойлголт бөгөөд хөгжих чадавхтай хувь хүмүүсээс бүрддэг. Эдгээр нь нийгэм-соёлын янз бүрийн нөхцөлөөс шалтгаалан харилцан адилгүй байдаг амьдралын түр зуурын мөчлөг юм.

Хүүхэд болон залуу хүмүүс ч мөн адил наснаас гадна өөр хоорондоо огтлолцсон олон төрлийн ижил төстэй шинж чанартай.

8. Дараах хэсэгт дэлгэрэнгүй тайлбарласанчлан НҮБ-ын байгууллагууд болон баримт бичгүүд, түүнчлэн олон улсын форумууд нь хүүхэд, залуучуудыг хүний эрхийг хэрэгжүүлэх, тогтвортой хөгжилд хүрэх, энх тайвныг хангах, хүчирхийлэл, мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны гол оролцогчид, өөрчлөлтийн төлөөлөгч, эрх эдлэгч гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Хүний эрхийн боловсрол, түүний дотор хүний эрх болон цахим технологи, байгаль орчин болон уур амьсгалын өөрчлөлт, жендэрийн тэгш байдлын талаарх боловсрол нь хүүхэд, залуучуудад үйл ажиллагаа явуулах, өөрсдийн болон бусдын хүний эрхийг хамгаалах, төрийн үйл хэрэг, ардчилсан шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжийг олгодог. Хүний эрхийн боловсрол нь хүүхэд, залуучуудыг чадавхжуулах, хөгжүүлэх, энх тайван, шударга, тогтвортой дэлхий рүү хөтлөх гол түлхүүр юм.

III. Үндэслэл

9. Хүүхэд, залуучуудын хүний эрхийн боловсрол нь сурч боловсрох эрхийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.⁴ Үүнийг Тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030, ялангуяа чанартай боловсролын талаарх 4 дүгээр зорилтын 7-д тусгасан. Түүнчлэн хөтөлбөрүүдийг харилцан ойлголцол, энх тайван, хүлээцтэй байдлыг дэмжих, хүчирхийлэл, зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх арга замаар хэрэгжүүлэх

³ Хүний эрхийн зөвлөлийн 42/7 дугаар тогтоол. ⁴ Хүний эрхийн зөвлөлийн баримт бичиг А/HRC/39/33, 13–15-р зүйлүүд.

⁴ А/59/525/Rev.1 баримт бичгийн 10–20-р зүйлүүд; мөн А/HRC/15/28 баримт бичгийн 18–20-р зүйлүүд

шаардлагатай болохыг тэмдэглэсэн.⁵

10. Хүүхэд бүр хүний эрхийг бүрэн дүүрэн эдлэх, хүний эрхийн үнэт зүйлсэд суурилсан соёлыг сурталчлах чадавхыг бэхжүүлэхийн тулд сурч боловсрох эрхтэй; ийм боловсрол нь даяарчлал, шинэ технологи, түүнтэй холбоотой үзэгдлүүдээс үүдсэн суурь өөрчлөлтийн үеийг дагасан сорилтод тэнцвэртэй, хүний эрхэд ээлтэй хариу арга хэмжээ авахад хүүхэд бүрд зайлшгүй шаардлагатай.⁶

11. Оролцоо нь өсвөр насныхан өөрсдийн эрхээ хэрэгжүүлэх талаар зөвшилцөх, нөлөөлөх, улс орнуудыг хариуцлагажуулах улс төр, иргэний оролцооны хэрэгсэл юм. Иймд улс орнууд өсвөр насныхныг иргэн байх, хүний эрхийн боловсролоор дамжуулан идэвхтэй иргэнийхээ үүргийг ойлгон ухамсарлах, хүлээн зөвшөөрөх, биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хөрөнгө оруулах шаардлагатай.⁷ Үүнийг хүлээн зөвшөөрч, Ерөнхий нарийн бичгийн дарга НҮБ-аас хүүхдүүдэд хүний эрхийн боловсрол олгохыг баталгаажуулах, тухайлан үндэсний хөтөлбөрт оруулахыг уриалсан.⁸

12. Ерөнхий нарийн бичгийн дарга НҮБ-ын Залуучуудын стратегийн хүрээнд залуучуудын дунд иргэний ухамсар, оролцоо, сайн дурын үйл ажиллагаа, энх тайван болон хүчирхийлэлгүй соёлыг төлөвшүүлэх зорилгоор залуучуудад чиглэсэн хүний эрхийн боловсрол, цаашлаад дэлхийн иргэний болон тогтвортой хөгжлийн боловсролыг ялгаварлан гадуурхалгүйгээр олгох хүчин чармайлтаа нэмэгдүүлэхийг НҮБ-д илэрхийлсэн.⁹ 2022 оны Боловсролыг өөрчлөх залуучуудын Тунхаглалд залуучууд энх тайван, хүний эрхийн зарчимд суурилсан боловсролыг дэмжих, залуу хүн бүрийг сэтгэл хангалуун, урам зоригтой, таатай, чанартай амьдрахад чиглүүлэхийг шийдвэр гаргагчдад хандан уриалсан.

13. Дэлхийд тулгарч буй өнөөгийн сорилтуудаас урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх стратеги нь залуучуудад хүний эрхийн боловсрол олгох явдал хэмээн үзэх нь улам бүр нэмэгдэж байна.¹⁰ Аюулгүйн зөвлөл мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэхэд залуучууд чухал үүрэг гүйцэтгэхийг баталгаажуулж, нийгмийн дэд бүтэц, улс төрийн оролцоог хамарсан үйл явцад залуучуудыг бүтээлчээр оролцох чадвараар хангасан, энх тайвны төлөө чанартай боловсролыг зохих ёсоор дэмжихийг улс орнуудад уриалав.¹¹

14. Технологи ба хүний эрхтэй холбоотой гарч буй боловсролын асуудлын тухайд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга хэлэхдээ, нээлттэй, аюулгүй, найдвартай цахим ирээдүйн гол үндэс суурь нь хүний эрх болгохын чухлыг онцлон тэмдэглэв.¹² Цахим орчин нь хүүхэд, залуучуудын эрхийг орон нутаг, үндэсний болон олон

⁵ Бүх хүний боловсрол: Хамтын амлалтаа хэрэгжүүлэх нь, Дэлхийн боловсролын форум дээр 2000 оны 4 дүгээр сарын 26–28-ны өдрүүдэд Дакарт батлагдсан

⁶ Хүүхдийн эрхийн хороо, Ерөнхий тайлбар №1 (2001 он), 2 болон 3-р зүйлүүд.

⁷ Хүүхдийн эрхийн хороо, Ерөнхий тайлбар №20 (2016 он), 24-р зүйл.

⁸ Ерөнхий нарийн бичгийн даргын удирдамжийн тэмдэглэл, “Хүүхдийн эрхийг бүх шатанд нэвтрүүлэх” (2023 оны 7-р сар), хуудас 8.

⁹ Залуучууд 2030: Залуучуудтай хамтран ажиллах, тэдний төлөө үйл ажиллагаа явуулах” баримт бичгийг үзнэ үү, https://www.unyouth2030.com/_files/ugd/b1d674_9f63445fc59a41b6bb50cbd4f800922b.pdf хаягаар орж, 12-р хуудас

¹⁰ Хүний эрхийн зөвлөлийн баримт бичиг A/HRC/35/6-ыг үзнэ үү.

¹¹ Аюулгүй байдлын зөвлөлийн 2250 дугаар тогтоол (2015 он).

¹² Бидний Хамтын Ирээдүй бодлогын товхимол №5: “Дэлхийн дижитал гэрээ – бүхний төлөө нээлттэй, чөлөөтэй, аюулгүй дижитал ирээдүй” (2023 оны 5-р сар), хуудас 14..

улсын түвшинд хэрэгжүүлэх шинэ боломжуудыг олгож байгаагийн зэрэгцээ тэдгээр эрхийг зөрчих, хүчирхийлэх эрсдэлийг бий болгож байна. Үүнтэй холбогдуулан Ерөнхий Ассамблей шинэ болон шинээр гарч ирж буй цахим технологийн хүний эрхийн үр дагавартай холбоотой ойлголт, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхийн тулд цахим чадварыг сурталчлах, чадавхыг бэхжүүлэх санаачилгыг дэмжихийн чухлыг онцлон тэмдэглэж;¹³ хүн бүрийг хүний эрхийн зарчим болон тэдгээр зарчмуудыг нийгмийн бүхий л салбарт хангах арга зүйд сургах, ялангуяа, цахим агуулга, технологийн хэрэглээнээс үүдэн улам бүр нэмэгдэж байгаа бүх төрлийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг арилгах эерэг зан үйлийг дэмжихийн тулд урт хугацааны, насан туршийн үйл явц болох хүний эрхийн боловсролыг дэмжиж, хөрөнгө оруулалт хийхийг улс орнуудад уриалав.¹⁴ Залуучууд цахим технологи, интернэтийн хүчийг хөшүүрэг болгон хүний эрх, тэгш байдал, эрхэм чанарыг цахим орчинд хамгаалж, цахим ертөнцийн давуу болон эрсдэлийн талаар бусдад сургах амлалтаа илэрхийлсээр байна;¹⁵ Үүний тулд улс орнууд, албан болон албан бус боловсролоор дамжуулан хүүхдийн цахим бичиг үсэг, ур чадварыг хөгжүүлэх ёстой.¹⁶ Гэвч интернэт гэх мэт цахим технологид нэвтрэх боломж тэгш бус байна. Дэлхий даяар ойролцоогоор 2.2 тэрбум хүүхэд, залуучуудын гуравны хоёр нь, ялангуяа охид, өсвөр насны охид гэртээ интернэтэд холбогдоогүй байна.¹⁷ Ерөнхий нарийн бичгийн даргын хэлснээр боловсролыг дахин зураглана гэдэг нь цахим бичиг үсгийн боловсрол, цахим дэд бүтэц болон бусад салбарт хөрөнгө оруулалт хийх утга юм.¹⁸

15. Байгаль орчин болон уур амьсгалын өөрчлөлтийн талаарх боловсролын тухайд Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 29 дүгээр зүйлийн (1)(е)-д “хүүхдэд олгох боловсролыг ... байгаль орчныг хайрлан хүндэтгэх үзлээр төлөвшүүлэхэд чиглүүлнэ” хэмээн заасан байдаг. Байгаль орчин болон уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой боловсрол, ялангуяа хүүхэд, залуучуудын боловсролыг дэмжих, хамтран ажиллах, энэ үйл явцад аль болох өргөн хүрээнд оролцохыг хөхүүлэн дэмжих шаардлагатай болохыг бүс нутгийн болон олон улсын тогтолцоо онцолж байна.¹⁹ Цэвэр, эрүүл, тогтвортой орчинд амьдрах эрхийг хүний эрх болохыг хүлээн зөвшөөрснөөр, Ерөнхий Ассамблей улс орнууд болон бусад холбогдох талуудад хандан “бүх хүний цэвэр, эрүүл, тогтвортой орчныг хангах хүчин чармайлтыг нэмэгдүүлэхийн тулд чадавхыг бэхжүүлэх”-ийг уриалсан бөгөөд байгаль орчны хохирлын хүний эрхийн үр дагавар нь аль хэдийнээ эмзэг нөхцөл байдалд хамаарах болсон эмэгтэйчүүд,

¹³ Ерөнхий Ассамблейн 78/187 дугаар тогтоолын 9-р зүйл.

¹⁴ Мөн эх сурвалжаас, 32-р зүйл.

¹⁵ Олон улсын Харилцаа холбооны Холбоо (ITU), Generation Connect: Залуучуудын уриалга (2022), 2 болон 4-р талууд

¹⁶ Хүүхдийн эрхийн хороо, Ерөнхий тайлбар №25 (2021 он), 32-р зүйл.

¹⁷ Ерөнхий Ассамблейн 78/187 дугаар тогтоолын уриалгын хэсгийн 19-р зүйл; мөн ЮНИСЕФ ба Олон улсын Харилцаа холбооны Холбоо (ITU), “Гэртээ хэдэн хүүхэд, залуус интернэтэд холбогддог вэ? COVID-19 цар тахлын үеийн дижитал холболтын тооцоо” (2020 он), хуудас 2.

¹⁸ Бидний Хамтын Ирээдүй, Ерөнхий нарийн бичгийн даргын тайлан (2021 он), хуудас 41.

¹⁹ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн хүрээний конвенци (1992), 4 дүгээр зүйлийн 1(и) ба 6-р зүйл; Парисын хэлэлцээр, Уур амьсгалын өөрчлөлтийн хүрээний конвенцид (2015), 12-р зүйл; Байгаль орчны мэдээлэл авах, олон нийт оролцох, шүүхэд хандах эрхийн конвенци (1998), 3-р зүйлийн 3 дахь заалт; Латин Америк, Карибын орнуудын Байгаль орчны мэдээлэл авах, олон нийт оролцох, шүүх эрх зүйн бүс нутгийн хэлэлцээр (2018), 10-р зүйлийн 2(д) заалт; Ерөнхий нарийн бичгийн даргын Хүний эрхийн төлөөх уриалга (2020), хуудас 10; COP28 дээр боловсрол ба уур амьсгалын өөрчлөлтийн хамтын үйл ажиллагааны тунхаглал (2023), 1.2-р зүйл.

охид, хүн амын зарим давхаргад хамгийн ихээр мэдрэгдэж байгааг тэмдэглэв.²⁰ НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага (ЮНЕСКО)-аас дэлхийн хэмжээнд явуулсан судалгаагаар хүүхэд, залуучууд уур амьсгалын өөрчлөлтийг ойлгох, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг илүү сайн арга хэмжээ авах, байгаль дахь хүний байр суурийг танин мэдэхэд туслах уур амьсгалын өөрчлөлтийн боловсролыг шаардажбайна.²² Илүү их эрхэд нийцсэн, үр дүнтэй байгаль орчны бодлогыг бий болгож, тэдний чөлөөт, идэвхтэй, утга учиртай, үр дүнтэй оролцоог хангахын тулд хүүхдүүдэд байгаль орчны болон хүний эрхийн боловсрол, насанд нь тохирсон, хүртээмжтэй мэдээлэл, хангалттай цаг хугацаа, нөөц бололцоогоор хангах, тэднийг дэмжих, таатай орчныг бүрдүүлэх шаардлагатай.²³

16. Жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүд, охидыг чадавхжуулах нь Тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030 (Зорилго 5)-ын бие даасан зорилт бөгөөд чанартай боловсролын 4 дүгээр зорилттой салшгүй холбоотой гэдгийг тэмдэглэх нь зүйтэй;²¹ Жендэрийн тэгш байдал нь бүх суралцагчид боловсрол эзэмших, боловсролын хөтөлбөрийг бүрэн дүүргэх бололцоогоор хангагдахаас гадна, боловсролоор дамжуулан эрх тэгш байдалд уриалахыг шаарддаг.²² Өсөн нэмэгдэж байгаа хөдөлмөрийн мөлжлөг, хор хөнөөлтэй үйл ажиллагаа болон хүйсээр ялгаварлан гадуурхах бусад хэлбэр, тэр дундаа жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөж буй нийгмийн гадуурхалт, ядуурлыг даван туулахын тулд охид эмэгтэйчүүдэд эрхээ баталгаажуулахад нь шаардлагатай ур чадвар, дадал эзэмшүүлэх шаардлагатай. Харин хөвгүүдэд жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалтын талаар, түүнтэй тэмцэхэд татан оролцуулах чиглэсэн боловсрол олгох шаардлагатай.²³ Иймд улс орнууд боловсролын хөтөлбөртөө эмэгтэйчүүд, охидын хүний эрх, жендэрийн тэгш байдал, өөрийгөө танин мэдэхүйн тухай тодорхой мэдээллийг тусгахын зэрэгцээ сургуулиуд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн талаар насны онцлогт тохирсон мэдээллээр хангах баталгааг хангах; түүнчлэн улс орнууд жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах, ялгаварлан гадуурхахгүй байх орчныг бүрдүүлэх, оролцоог хангахад хувь нэмрээ оруулах ёстой.²⁴ Эмэгтэйчүүдийн статусын талаарх Хорооны зүгээс жендэрийн тэгш байдлыг хангахад жендэрийн мэдрэмжтэй боловсрол, сургалт чухал үүрэгтэй болохыг хүлээн зөвшөөрч, үүнийг хэрэгжүүлэхэд эрэгтэйчүүд, хөвгүүдийн үүрэг оролцоог онцолсон.²⁵

²⁰ Ерөнхий Ассамблейн 76/300 дугаар тогтоолын 4-р зүйл ба уриалгын хэсгийн 11-р зүйл.

²¹ ЮНЕСКО, Хандалтаас эрх мэдэлжүүлэлт рүү: Боловсролоор дамжуулан болон боловсролын салбарт хүйсийн тэгш байдлыг хангах ЮНЕСКО-гийн стратеги (2019–2025), х. 4.

²² Инчоно тунхаглал ба Тогтвортой хөгжлийн зорилт 4-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээ (2015 он), хуудас 28.

²³ A/HRC/WG.11/37/1 дугаар бүхий баримт бичгийг үзнэ үү.

²⁴ Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хорооны хамтарсан ерөнхий зөвлөмж No.31/ хор хөнөөлтэй үйлдлүүдийн талаарх Хүүхдийн эрхийн хорооны ерөнхий тайлбар No.18 (2019), 69 дэх догол мөр

²⁵ Эмэгтэйчүүдийн аж байдлын комиссын дөчин наймдугаар чуулган, зөвшилцсон дүгнэлт, 2004 оны 3 дугаар сар, 4 дэх догол мөр.

IV. Тодорхой зорилтууд

17. Энэхүү үйл ажиллагааны хөтөлбөр нь дараах тодорхой зорилтуудыг хангахад чиглэнэ:

- (a) Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн өмнөх үе шатуудад гарсан ахиц дэвшилд үндэслэн хүүхэд залуучуудад чиглэсэн хүний эрхийн боловсролын тогтвортой үндэсний стратеги боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, тэр дундаа хүн бүрийг ялгаварлан гадуурхахгүйгээр удирдах үүрэг гүйцэтгэх оролцоог хангах;
- (b) Албан ба албан бус боловсрол, албан ёсны бус сургалтад хамрагдсан хүүхэд, залуучуудын хүний эрхийн боловсролыг²⁶ тэдний насан туршийн боловсролын нэг хэсэг болгон өргөжүүлж, гадуурхагдах болон эмзэг байдалд байгаа хүмүүсийг нэн тэргүүнд тавих;²⁷
- (c) Хүүхэд залуучуудад хүний эрхийн боловсрол олгох албан ба албан бус боловсролын үндсэн бүрэлдэхүүн хэсэг, үйл ажиллагааны талаар зааварчилгаа өгөх, үүний дагуу холбогдох мэдээллийг цуглуулж, үндэсний ахиц дэвшлийг үнэлэх боломжтой;
- (d) Тэдний үе тэнгийнхэнд нь зориулсан хүний эрхийн боловсролын хөтөлбөрт хүүхэд, залуучуудын оролцоо, манлайллыг зоригжуулж, дэмжих;
- (e) Хүүхэд, залуучуудын хүний эрхийн боловсролыг тэдний хүний эрхийг хамгаалах, дэмжих бусад үйл ажиллагаанд нэмэлт болгон дэмжих;
- (f) 2030 он хүртэлх хөтөлбөрийн хүрээнд тогтвортой хөгжилд хүрэх, дэлхийн өнөөгийн сорилтуудаас урьдчилан сэргийлэх, шийдвэрлэхэд хүүхэд, залуучуудын хүний эрхийн боловсролын оруулсан хувь нэмрийг онцлон харуулах;
- (g) Хүний эрх, хүүхэд, залуучууд, боловсрол болон тогтвортой хөгжлийн чиглэлээр ажилладаг орон нутаг, үндэсний, бүс нутгийн болон олон улсын төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд, тэр дундаа хүүхэд, залуучуудын тэргүүлсэн хөдөлгөөн болон байгууллагуудын дунд хүүхэд, залуучуудад хүний эрхийн боловсрол олгох чиглэлээр сүлжээ, хамтын ажиллагааг дэмжих.

²⁶ Албан бус сургалт гэдэг нь зориудын буюу санаатайгаар явагддаг боловч байгууллагын түвшинд зохион байгуулагддаггүй суралцах үйл явц юм. Энэ нь албан ёсны болон албан бус боловсролоос илүү зохион байгуулалт муутай, бүтэц багатай байдаг ба гэр бүл, ажлын байр, орон нутаг болон өдөр тутмын амьдралд хувь хүнээр, гэр бүлээр эсвэл нийгмийн зүгээс чиглүүлэгдэн явагддаг сургалтын үйл ажиллагааг хамарна (ЮНЕСКО-гийн нэр томъёоны толь бичгийг үзнэ үү).

²⁷ Эдгээрт дараах бүлгийн хүүхэд, залуус хамаарах боломжтой. Үүнд: эмэгтэйчүүд, охид; бие махбодын, сэтгэцийн, сэтгэлзүйн, сонсголын болон харааны зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс; үндэс угсаа, шашин шүтлэгийн цөөнх болон уугуул ард түмэн зэрэг бүлгүүдэд харьяалагдагсдын хүүхэд, залуус; лесби, гей, бисекс, трансжендер болон интерсекс хүүхэд, залуус; нийгэм, эдийн засгийн хувьд эмзэг нөхцөлд байгаа, газарзүйн хувьд алслагдсан бүс нутагт амьдардаг, зэвсэгт мөргөлдөөний бүс нутагт байгаа хүүхдүүд; мөн дотооддоо шилжсэн, цагаач, орогнол хүсэгч, дүрвэгч, буцаж ирсэн хүүхэд, залуус; асран хамгаалагчгүй, гудамжинд амьдарч байгаа, байгалийн гамшигт нэрвэгдсэн хүүхдүүд; эцэг эхийн хараа хяналтгүй, хууль зөрчсөн, хорих ял эдэлж буй, эсвэл хүний эрх зөрчигдөж, хүчирхийлэлд өртсөн хүүхэд, залуус орно.

V. Бүрэлдэхүүн хэсгүүд

18. Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн өмнөх үе шатууд нь албан боловсрол (эхний болон хоёр дахь үе шат) болон албан бус боловсрол (дөрөвдүгээр үе шат), албан болон албан бус боловсролын багшийн хүний эрхийн сургалт (гурав дахь шат)-ын хүрээнд хүүхэд, залуучуудыг хамарсан хүний эрхийн үр дүнтэй боловсрол олгох элементүүдийг тодорхойлсон.

19. Эдгээр элементэд тулгуурлан энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүүхэд, залуучуудад хүний эрхийн үр дүнтэй боловсрол олгох дараах дөрвөн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлсон. Бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн бүхий үйл ажиллагаа, тухайлбал, төлөвлөлт, зураглал, хэрэгжилт, хяналт, тогтмол дүн шинжилгээ, үнэлгээ гэсэн үе шатанд хүүхэд, залуучуудыг гол оролцогч болгон оролцуулах шаардлагатай.

A. Бодлого, холбогдох хэрэгжүүлэх арга хэмжээ

20. Улс орнууд хүүхэд, залуучуудын хүний эрхийн боловсролыг дэмжих бодлогыг боловсруулж, баталж, хэрэгжүүлж, хяналт тавих бөгөөд үүнд дараах үйл ажиллагааг хамруулна:

- (a) Албан боловсролын хувьд үндэсний онцлогтоо тохируулан хүний эрх, хүний эрхийн боловсролын бодлого, хууль тогтоомжийг дараах замаар боловсруулах;
 - (i) Хүний эрхийн боловсролыг тусгасан боловсролын хууль тогтоомж, сургалтын хөтөлбөрийг боловсруулж, бэхжүүлэх, мөрдүүлэх, түүнчлэн цахим технологи, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, жендэрийн тэгш байдлыг хангахтай холбоотой хүний эрхийн боловсролын тухай хууль тогтоомжийг батлах;
 - (ii) Үндэсний сургалтын хөтөлбөр, боловсролын стандартад хүний эрхийн мэдлэг, ур чадвар, хандлагыг үндсэн ур чадвар болохыг хүлээн зөвшөөрч, бичиг үсэг, тоо бодох, цахим ур чадварыг иж бүрэн болгох;
 - (iii) Тухайлсан Хүний эрхийн боловсролын үндэсний хөтөлбөрийг бэлтгэх эсхүл хүний эрхийн боловсролыг одоо байгаа сургалтын хөтөлбөрүүдтэй нэгтгэж, үзэл баримтлал, зорилго, сургах, суралцах зорилт, арга барилыг тодорхойлох;
 - (iv) Холбогдох бүхий л хууль тогтоомж, бодлогыг одоогийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон бусад холбогдох олон улсын баримт бичигт тусгагдсан сайн туршлагад тулгуурлан хүний эрхийн боловсролын зарчимд нийцүүлэх;
 - (v) Хүний эрхийн боловсролыг хэрэгжүүлэх, дэмжихэд орон нутгийн удирдлагын гүйцэтгэх үүрэг, хариуцлагын талаар тэдгээрт зааварчилгаа өгөх;

- (vi) Боловсролын байгууллагын бүхий л бодлого, үйл ажиллагаа²⁸ тухайлбал засаглал, менежмент, хүмүүжлийн болон сахилгын журам бусад бодлого, дүрэм журам, үйл ажиллагааны хүний эрхийн зарчимд суурилсан хандлагыг дэмжих;
- (vii) Боловсрол, хүний эрхийн боловсрол нь ялгаварлан гадуурхалтгүйгээр, ялангуяа гадуурхагдсан, эмзэг байдалд байгаа бүх хүүхэд, залуучуудад хүртээмжтэй байх баталгааг хангах бодлого боловсруулах;
- (viii) Шийдвэр гаргах болон инновац шинэчлэл хийх үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг хэрэгжүүлэхийн тулд боловсролын байгууллагын удирдлагыг чадавхжуулах;
- (ix) Сурагчдын хүний эрхийн мэдлэг, ур чадвар, хандлагын талаарх хүрсэн үр дүнг үнэлэх, санал хүсэлт гаргах журам боловсруулах;
- (x) Боловсролын хэрэглэгдэхүүнийг хүний эрхийн зарчимд нийцүүлэхийн тулд шинэчлэн боловсруулах, хүний эрхийн боловсролын тусгай хэрэглэгдэхүүн боловсруулах удирдамжийг батлах;
- (xi) Хүний эрхийн тэгш байдал, ялгаварлан гадуурхахгүй байх, хүний эрхийг хүндэтгэх, шударга, ил тод байх зарчимд үндэслэн багшлах болон боловсролын бусад боловсон хүчнийг бэлтгэх, сонгон шалгаруулах, үнэлэх, шагнал олгох, албан тушаал ахих, хариуцлага тооцох бодлого, үйл ажиллагааг бий болгох;
- (xii) Багшлах болон боловсролын бусад боловсон хүчин, түүнчлэн хүүхэд, залуучуудад чиглэсэн бусад холбогдох мэргэжлээр ажиллах ажилтнуудад олгох төрийн тусгай зөвшөөрөл, гэрчилгээ олгоход хүний эрхийн сургалтад урьдчилан эсхүл мэргэжил дээшлүүлэх хэлбэрээр хамрагдсан байх шалгуурыг тогтоох;
- (xiii) Боловсролын бодлогыг боловсруулахад сурагчид, багш болон эцэг эхийн холбоод, бусад холбоод, мэргэжлийн болон судалгааны байгууллага, иргэний нийгэм, түүний дотор хүний эрхийн үндэсний байгууллага, хүүхэд болон залуучуудын тэргүүлсэн хөдөлгөөн, байгууллага, бусад оролцогч талуудыг оролцуулан оролцооны хандлагыг хэрэгжүүлэх;
- (xiv) Дээрх үйл ажиллагаанд хүүхэд, залуучуудыг утга учиртай оролцуулах, үе хоорондын түншлэлд онцгойлон анхаарч удирдамж боловсруулах;
- (b) Иргэний нийгэм, хүний эрхийн үндэсний байгууллагууд, хүүхэд болон залуучуудын тэргүүлдэг хөдөлгөөн эсхүл байгууллага, хувийн хэвшил, бусад оролцогчдын явуулж байгаа хүний эрхийн албан бус боловсролын тухайд бусад оролцогч талуудтай хамтран саад бэрхшээлийг арилгах, тэдний ажлыг хөнгөвчлөх бодлого, холбогдох арга хэмжээг боловсруулах, тухайлбал, гэрчилгээ баталгаажуулах; олон нийтийн газар нэвтрэх боломжоор хангах, татварын хөнгөлөлт үзүүлэх зэргээр санхүүгийн дэмжлэг үзүүлэх; чадавх бэхжүүлэх санаачилгыг өрнүүлэх гэх зэргээр менторшип болон бусад мэргэжлийн туслалцаа үзүүлэх; хүүхэд, залуучуудын тэргүүлдэг хөдөлгөөн, байгууллагуудын санаачилгыг онцгойлон авч үзэж, хүний эрхийн боловсролын

²⁸ Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасны дагуу боловсролын байгуулалтад ерөнхий боловсролын анхан, дунд, дээд шатны болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд хамрагдана.

хөтөлбөр, ялангуяа цахим хөтөлбөрүүдийг дэмжих; өөр хоорондоо эвсэн нэгдэх, холбоо байгуулах, сүлжээ бий болгохыг дэмжих гэх мэт;

- (с) Холбогдох үндэсний хэмжээний бодлого, стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө хоорондын харилцан шүтэлцээ, уялдаа холбоо, харилцан хамаарлыг хангах;
- (д) Бодлогын хэрэгжилт, үнэлгээний талаарх холбогдох, ойлгомжтой, иж бүрэн арга хэмжээг боловсруулж, батлах. Уг арга хэмжээнд үүрэг хариуцлагыг тодорхой хуваарилж, тодорхой зориулалт бүхий, хангалттай, тогтвортой санхүүгийн болон бусад нөөцөөр хангаж, харилцан шүтэлцээ, мониторинг, тайлагналт, хариуцлагыг хангах үүднээс холбогдох бүх оролцогч талуудыг оролцуулах.
- (е) Сурч боловсрох эрх болон хүний эрхийн боловсролын бүс нутгийн болон олон улсын баримт бичгүүдийг соёрхон батлах, эсхүл олон улсын гэрээний зарим заалт үйлчлэхгүй байхаар нэгдэн орсон шийдвэрийг хүчингүй болгох замаар хүүхэд, залуучуудын хүний эрхийн боловсролын талаарх олон улсын үүргээ биелүүлэх; хүний эрхийн боловсрол, хүүхэд залуучуудын талаарх үндэсний бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээг бүс нутгийн болон олон улсын баримт бичигт нийцүүлэх.

В. Заах болон суралцах процесс

21. Хүүхэд, залуучуудад зориулсан хүний эрхийн боловсрол нь агуулгын онцлог шинж чанартай бөгөөд тэдний суралцах онцлог хэрэгцээг хангах, насны онцлогийг харгалзан үзэх шаардлагатай болохыг хүлээн зөвшөөрч энэ хэсэгт агуулга, арга зүй, материал болон нөөцийн талаарх ерөнхий удирдамжийг санал болгож байна.

22. Агуулгын хувьд дээр дурьдсанчлан хүний эрхийн боловсрол нь хүүхэд, залуучууд эрхээ хэрэгжүүлэх, бусдын эрхийг хүндэтгэх, хамгаалах мэдлэг, ур чадвар, хандлагыг төлөвшүүлэх дэмжлэг болдог. Хүний эрхийн боловсролын ерөнхий ур чадварыг эхний болон дөрөв дэх үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан. Харин энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөнд Хүний эрхийн зөвлөлөөс онцолсон гурван сэдэвчилсэн хүний эрхийн боловсролын салбарын ур чадварт онцгой анхаарал хандуулсан.²⁹

(а) Хүний эрх болон цахим технологийн талаарх боловсрол:

(i) Мэдлэг: Хүүхэд, залуучууд дараах зүйлийг мэдэж, ойлгоно:

- а. Цахим орчин дахь тэдний эрх, ялангуяа амьд явах, үл ялгаварлан гадуурхах, хувийн нууцыг хамгаалах, бие махбод болон сэтгэл зүйн эрүүл мэндийн хүрч болох хамгийн дээд стандартад хүргэх, цахим орчинд нэгэнт бий болсон болон шинээр гарч ирж буй бүх хэлбэрийн хүчирхийллийн эрсдэлээс хамгаалах, мэдээлэл олж авах, үзэл бодолтой байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, сэтгэн бодох болон шашин шүтэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх болох тайлан хуран цуглах эрх чөлөө;

²⁹ Энэ хэсгийн гол эх сурвалжууд нь Хүүхдийн эрхийн хороо болон Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтыг устгах хорооны холбогдох ерөнхий тайлбарууд, ЮНЕСКО-гийн Энх тайван, хүний эрх болон тогтвортой хөгжилд зориулсан боловсролын талаарх зөвлөмж, мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын бусад баримт бичгүүд болно

- b. Цахим орчин, ялангуяа түүний дэд бүтэц, бизнесийн үйл ажиллагаа, итгэн үнэмшүүлэх стратеги, автомат боловсруулалтын хэрэглээ, хувийн мэдээлэл, тандалт, алгоритмын хувийн тохиргоо, хиймэл оюун ухаан, холбогдох хууль эрх зүйн нөхцөл;
 - c. Оффлайн болон цахим орчинд хүний эрх болон үндсэн эрх чөлөөг дэмжих, хамгаалах цахим технологийн боломж;
 - d. Цахимжилтын нийгэмд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, цахим бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийн үлдээж байгаа ул мөртэй холбоотой боломж, эрсдэл, түүний дотор байгаль орчны нөлөөлөл;
 - e. Цахим контент, харилцаа, зан үйл, гэрээтэй холбоотой эрсдэлд өртөж болзошгүй сөрөг үр дагавар, тухайлбал цахим түрэмгийлэл, хүний наймаа, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл болон хүчирхийллийн бусад хэлбэр
 - f. Хор уршгийг бууруулах стратеги, өөрийн болон бусдын хувийн мэдээлэл, хувийн нууц, илэрхийллийг хамгаалах стратеги, тэдгээрийн нийгмийн, сэтгэл хөдлөлийн ур чадвар, тэсвэрлэх ур чадварыг бий болгох стратеги;
 - g. Хүүхэд, залуучууд, ялангуяа гадуурхалт, эмзэг байдалд байгаа тэдний үе тэнгийхний цахим орчинд нэвтрэхэд тулгарч буй янз бүрийн саад бэрхшээл;
 - h. Цахим технологийн ашиглах нь хүүхэд, залуучууд өөр хоорондоо, эсхүл хүүхэд, залуучууд болон багш, эцэг эх, асран хамгаалагчдын хоорондын шууд, хариу үйлдэлтэй харилцааг орлох ёсгүй тул цахим болон цахим бус үйл ажиллагааны эрүүл тэнцвэр;
- (ii) Ур чадвар: Хүүхэд, залуучууд дараах ур чадварыг эзэмших боломжтой:
- a. Технологийн нийгэмд эзлэх байр суурь, өдөр тутмын амьдралд үзүүлэх нөлөөлөл, мэдлэгийг бий болгоход гүйцэтгэх үүрэг, тэдгээрийн хэрэглээний нийгмийн гишүүд, ялангуяа гадуурхалт, эмзэг байдалд өртөмтгий хүмүүсийн оролцоо, хамруулалт;
 - b. Төрөл бүрийн суваг, технологиор дамжуулан мэдээлэл, мэдлэгийг үр дүнтэй хайх, хүлээн авах, тунгаан үнэлэх, хариуцлагатайгаар бүтээх, ашиглах, түгээх;
 - c. Ялгаварлан гадуурхалт, арьс үндсээр алагчлах, хүчирхийлэл, садар самуун болон мөлжлөгийн мэдээлэл, бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл, мөлжлөг, дарамт, цахим залилан, цахим дарамт, цахим грүминг, цахим түрэмгийлэл зэрэг онлайн худал мэдээлэл, ташаа мэдээлэл болон бусад хэлбэрийн өрөөсгөл буюу худал агуулга, үзэн ядсан үг хэллэг, хор хөнөөлтэй агуулга, зан үйлийг илрүүлэх, тэмцэх;
 - d. Цахим болон цахим бус орчинд хүүхэд, залуучуудын анхаарал татсан хүний эрхийн гол сэдвүүдийн талаар үр дүнтэй онлайн мэдээлэл, нөлөөллийн кампанит ажлыг үе тэнгийнхэн болон бусад хүмүүстэй хамтран зохион байгуулж, хэрэгжүүлэх;

- e. Өөрсдийн бодол санааг илэрхийлэх, оролцоог хангах цахим платформ, арга хэрэгслийг тодорхойлох, зохих ёсоор ашиглах, үе тэнгийнхэн болон насанд хүрэгчидтэй эрх тэгш оролцох, шаардлагатай тохиолдолд нэрээ нууцлах, ингэснээр тэд дангаараа болон бүлгээр өөрсдийн эрхийн төлөө үр дүнтэй нөлөөлөх боломжтой;
- f. Цахим орчинд найдвартай, үр дүнтэй, хянамгай, хүндэтгэлтэй байдлаар харьцаж цахим аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, мэдээлэлтэйгээр зөвшөөрөл авах үндсэн дээр хувийн мэдээлэл, хувийн нууц, илэрхийллийг хамгаалах, бусдын эрх, нэр төрийг хүндэтгэсэн, хууль тогтоомжийг зөрчөөгүй байх;
- g. Хүний эрхийн зарчимд тулгуурлан өнөөгийн болон ирээдүйн технологийг хариуцлагатай ашиглах замаар нийгэм, орон нутаг, үндэсний, бүс нутаг, дэлхийн хэмжээнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах;
- h. Улс орнууд болон бусад холбогдох оролцогчид, тэр дундаа бизнес эрхлэгчдийн цахим технологийг ашиглахдаа хүний эрхийн зарчимд суурилсан хандлагыг хэрэгжүүлээгүй үйлдэлд хариуцлага тооцох;
- i. Цахим орчинтой холбоотойгоор эрх нь зөрчигдөж хүчирхийлэлд өртсөн тохиолдолд мэргэжлийн болон олон салбарын дэмжлэг (сэтгэл зүйн болон хууль зүйн дэмжлэгийг оролцуулан) авах, зөрчигдсөн эрхийг сэргээх хүүхэд, залуучуудад ээлтэй шүүхийн болон шүүхийн бус механизмыг үр дүнтэй хэрэгжүүлэх.

(iii) Хандлага: хүүхэд, залуучууд дараах зүйлийг харуулна:

- a. Цахим орчинд бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх;
- b. Технологийн хэрэглээнээс үүдэлтэй эсвэл технологиос үүдэн улам бүр нэмэгдэж байгаа ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, хор хөнөөлтэй зан үйлийн бүх хэлбэрийг шийдвэрлэх эерэг зан үйл;
- c. Хүний эрхийг дэмжих, хамгаалахад цахим технологийг хөшүүрэг болгон ашиглах хүсэл эрмэлзэл;
- d. Цахим, хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсрол, ур чадвар, хариуцлагатайгаар цахим ертөнцийг хянах, дасан зохицох чадвартай цахим иргэн болон байгууллага байх;
- e. Аливаа хор хөнөөлтэй цахим үйл ажиллагааны бай болох үед тэсвэртэй байх, түүнчлэн кибер хохирогч болохтой тэмцэх зэрэг зорилтот бүлэгтэй эв санааны нэгдэлтэй байх;
- f. Цахим платформ болон сошиал медиаг ашиглан нийгмийн оролцоог бодитоор үнэлэх;
- g. Дэлгэцийн хамааралтай байдал болон цахим донтолтоос урьдчилан сэргийлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг мэдээллийн хэрэгслийн төлөвшил, цахим тэнцвэрийн талаарх ойлголт.

(b) Байгаль орчин болон уур амьсгалын өөрчлөлтийн талаарх боловсрол:

(i) Мэдлэг: Хүүхэд, залуучууд дараах зүйлийг мэдэж, ойлгоно:

- a. Хүний эрхийг хангахад уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын алдагдал, бохирдол, байгаль орчны бусад сорилт зэрэг олон талт хямралын өсөн нэмэгдэж байгаа сөрөг нөлөөлөл
 - b. Тэдний цэвэр, эрүүл, тогтвортой орчинд амьдрах эрх гэж юу болох, энэ нь амьд явах, бие махбод, сэтгэцийн эрүүл мэндийн хүрч болох хамгийн дээд стандартад хүрэх, амьжиргааны зохих түвшинд аж төрөх, сурч боловсрох, зөрчигдсөн эрхийг үр дүнтэй сэргээх зэрэг бусад эрхүүдийн харилцан хамаарал;
 - c. Цэвэр, эрүүл, тогтвортой орчинд амьдрах эрхтэй холбоотой олон улсын, бүс нутгийн болон үндэсний бодлого, тогтолцоо, түүнчлэн байгаль орчинтой холбоотой процесст иргэдийн оролцоо;
 - d. Хувь хүн, бүлэг, нийгэм, улс орон, байгалийн баялаг, экосистемийн харилцан хамаарал, үйлдэл, эс үйлдлээс үүдэн гарах үр дагавар;
 - e. Үе хоорондын тэгш байдал, шударга ёс, эв нэгдлийн зарчим болон улс орнуудын уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг нийтлэг боловч ялгаатай үүрэг хариуцлагыг тус тусын чадавхын дагуу авч хэрэгжүүлэх зарчмын дагуу арга хэмжээ авах төрийн үүрэг;
 - f. Эмэгтэйчүүд, охид, уугуул иргэд, цөөнх, Африк гаралтай хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, гамшиг болон уур амьсгалд өртөмтгий орчинд амьдардаг, хүрээлэн буй орчны сорилтоос болж шилжин суурьшихаас өөр аргагүйд хүрсэн хүмүүс зэрэг тодорхой бүлгийн хүүхэд, залуучуудад байгаль орчны хор хөнөөлийн огтлолцсон болон ялгаатай нөлөөлөл;
 - g. Колоничлол, нүүлгэн шилжүүлэлт, геноцид зэрэг тэгш бус байдлын түүхэн болон одоо үргэлжилж байгаа хэв маягийн хоорондын уялдаа холбоо, уур амьсгалын өөрчлөлтөд экосистем болон хүмүүсийн эмзэг байдал, эдгээр асуудлыг шийдвэрлэхэд уур амьсгалын шударга ёсны хөдөлгөөний үүрэг оролцоо.
- (ii) Ур чадвар: Хүүхэд, залуучууд дараах ур чадварыг эзэмших боломжтой:
- a. Уур амьсгал болон байгаль орчны хор хөнөөлийн шалтгаан, үр дагавар, бодит болон боломжит эх үүсвэр, дасан зохицох арга хэмжээ, бусад бүс нутгаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, уур амьсгал болон байгаль орчны талаарх холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, уур амьсгал болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээний үр дүн, бодлого болон төлөвлөлт, тогтвортой амьдралын хэв маяг болон хэрэглээ, уламжлалт буюу өвөг дээдэс, уугуул иргэдийн мэдлэг (чөлөөт, урьдчилсан, мэдээлэлтэйгээр уугуул иргэдийн зөвшөөрлийг авах) зэрэг байгаль орчны талаарх үнэн зөв, найдвартай мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх;
 - b. Гамшгийн эрсдэл, хүрээлэн буй орчны эрүүл мэндэд үзүүлэх сөрөг үр дагавар зэрэг өсөн нэмэгдэж буй байгаль орчны сорилтод бэлтгэх дасан зохицох, тэсвэрлэх чадварыг бий болгох стратегийг батлах;
 - c. Байгаль орчны сорилтыг тунгаан хүлээн авч, эдийн засгийн эргэлтийг дэмжих зэргээр асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах, хувьсан өөрчлөгдөх чадавхын дагуу тогтвортой амьдрал болон хэрэглээний хэв

маягийг нэвтрүүлэх замаар хариуцлагатай шийдвэр гаргах;

- d. Байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын хямралын нөлөөллийг арилгах, уур амьсгалын шударга ёс, байгаль орчны тогтвортой байдлыг дэмжихэд хувь нэмрээ оруулахын тулд хувь хүн, уугуул иргэд болон хамтаар нэгдэн санаа бодлоо хуваалцаж, бусдыг урамшуулан дэмжиж, тайван замаар үйл ажиллагаа явуулах;
 - e. Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны шийдвэр гаргах үйл явцад орон нутаг, улс үндэстэн, бүс нутаг, дэлхийн түвшинд утга учиртай оролцох, нөлөөлөх;
 - f. Дэлхийн түвшинд байгаль орчны хор хөнөөлтэй тэмцэх, ногоон тархи угаалт эсвэл ногоон гэх тодотголтой худал сурталчилгааг тодорхойлох яаралтай бөгөөд шийдэмгий арга хэмжээг цахим болон цахим бус орчинд авч хэрэгжүүлэх;
 - g. Ирээдүйд учирч болзошгүй эрсдэл, хор уршгийг харгалзан хүүхэд, залуучуудыг хүрээлэн буй орчны хор хөнөөлөөс хамгаалах, тэдний сайн сайхан байдал, хөгжлийг хангаагүй тохиолдолд улс орнууд болон бусад холбогдох оролцогчид, тэр дундаа бизнес эрхлэгчдэд хариуцлага тооцох;
 - h. Байгаль орчныг хамгаалах хүчин чармайлтын эсрэг заналхийлэл, айлган сүрдүүлэлт, дарамт болон бусад ноцтой хариу арга хэмжээг танин мэдэж, аюулгүй, найдвартай байдлыг хангах зохих арга хэмжээг авах
 - i. Хүүхэд, залуучуудын асуудалд төвлөрсөн хүний эрхийн үндэсний байгууллагууд зэрэг хүүхэд, залуучуудад ээлтэй шүүхийн болон шүүхийн бус механизмтай үр дүнтэй ажиллах, байгаль орчны хохирол болон уур амьсгалтай холбоотой бусад гарз, хохиролтой холбоотой зөрчигдсөн эрхийн асуудлаар шударга ёсыг эрэлхийлж, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх.
- (iii) Хандлага: хүүхэд, залуучууд дараах зүйлийг харуулна:
- a. Эв нэгдэл, болон нийтлэг хүн төрөлхтөн, эх дэлхийтэй холбоо, хамааралтай байдал;
 - b. Эрүүл эх дэлхийн төлөөх хамтын хариуцлагын мэдрэмж;
 - c. Байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт болон түүний нөлөөлөлтэй тэмцэхэд уламжлалт болон уугуул иргэдийн мэдлэг, туршлагын олон талт үүргийг хүндэтгэж, хүлээн зөвшөөрөх;
 - d. Тогтвортой байдал, хүний эрхийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих зорилгоор цахим хэрэгслийг ашиглан байгаль орчны үнэн зөв, найдвартай мэдээллийг бусадтай хуваалцах хүсэл эрмэлзэл;
 - e. Цэвэр, эрүүл, тогтвортой орчинд амьдрах эрхийг хүний бусад эрхтэй уялдуулан хамгаалах, байгаль орчны хор уршгийг арилгах, хариуцлагыг дэмжих чиглэлээр уур амьсгалын шударга ёс, үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэхийг нэн тэргүүнд уриалах арга хэмжээ авдаг байх;
 - f. Тогтвортой, цэцэглэн хөгжиж буй ирээдүйн төлөөх өөдрөг үзэл, итгэл найдвар.

- (с) Жендэрийн тэгш байдлын талаарх боловсрол:
- (i) Мэдлэг: Хүүхэд, залуучууд дараах зүйлийг мэдэж, ойлгоно:
- a. Хүн бүр эдийн засаг, нийгэм, соёл, иргэний болон улс төрийн бүх эрхийг аливаа ялгаагүйгээр эдлэх тэгш эрх;
 - b. Жендэрт суурилсан хүчирхийлэл, хүүхэд болон албадан гэрлэлт, боловсрол жендэрийн ялгаа, албан болон албан бус хөдөлмөр эрхлэлт дэх ялгаварлан гадуурхалт, нөөц баялгийн тэгш бус хүртээмж, халамжийн чиг үүргийн тэгш бус хуваарилалт, түүнтэй холбоотой активизм, хөдөлгөөний талаарх жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалтын түүхэн үндэс, илрэл, хувьсал;
 - c. Ялгаварлал бүхий жендэрийн чиг үүрэг, жендэрийн хэвшмэл ойлголттой холбоотой нийгэм, соёлын хэм хэмжээ, хандлага, хүлээлтийн үр дагавар, түүний дотор сэтгэцийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөө;
 - d. Нас, үндэс угсаа, хөрөнгө чинээ, эрх зүйн байдал, чадамж, бэлгийн чиг баримжаа, газар зүйн байршил зэрэг бусад шинж байдал нь жендэрийн харилцан үйлчлэл, огтлолцол бүхий ялгаварлан гадуурхалтын олон хэлбэр, огтлолцолд хүргэдэг талаар;
 - e. Олон талт байдалд байгаа хүн бүр өөрийн бие махбод, нөхөн үржихүйн үйл ажиллагааны талаар бие даасан, мэдээлэлтэй шийдвэр гаргах эрх нь тэгш байдал, хувийн нууц, бие махбодын бүрэн бүтэн байдлыг хангах үндсэн эрхийн суурь болох;
 - f. Чанартай боловсрол, насан туршийн суралцах үйл явц, чадавхжуулахад нөлөөлдөг хүүхдийн гэрлэлт, хүүхдийн хөдөлмөр болон гэрийн ажил, өсвөр насны болон хүсээгүй жирэмслэлт зэрэг жендэртэй холбоотой саад бэрхшээл;
- (ii) Ур чадвар: хүүхэд, залуучууд дараах зүйлийг хийх чадвартай болно.
- a. Жендэрт суурилсан хор хөнөөлтэй хандлага, өрөөсгөл үзлийг тодорхойлох, эсэргүүцэх, өөрчлөх болон гэр бүл, сургууль болон нийгмийн өргөн хүрээнд, цахим орчинд, тэр дундаа өдөр тутмын амьдралд жендэрт нийцсэн хэллэг ашиглах замаар илүү эерэг үүрэг, зан үйлийн хэлбэрийг нэвтрүүлэх;
 - b. Хүн бүр эрхээ чөлөөтэй, бүрэн дүүрэн эдлэх, хэрэгжүүлэх боломжийг хязгаарласан үзэл суртал, бүтцийг эсэргүүцэж, олон талт байдал, оролцоог дэмжих;
 - c. ХДХВ болон бэлгийн замаар халдварлах бусад халдвараас урьдчилан сэргийлэх, хүчирхийлэл болон хор уршиг бүхий бусад үйлдлээс хамгаалах, өсвөр үеийнхний жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх зэрэг бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд болон эрх, холбогдох үйлчилгээний талаарх үнэн зөв мэдээлэл авах, бэлгийн боловсрол эзэмших;
 - d. Ялангуяа охид, эмэгтэйчүүдийн тухайд нийгэм, эдийн засаг, соёл урлаг, иргэний болон улс төрийн эрхээ эрэгтэйчүүд болон хөвгүүдийн нэгэн адил тэгш эрхтэйгээр эдлэх, шаардах;

- e. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар мэдээлэлтэйгээр шийдвэр гаргах;
 - f. Жендэрийн тэгш байдал болон түүнтэй холбоотой яриа хэлэлцүүлэг нь саналын зөрүүтэй байсан ч ухаалгаар шүүн тунгааж, хүндэтгэлтэйгээр оролцох;
 - g. Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн үед мэргэжлийн болон олон салбарын дэмжлэг (сэтгэл зүйн, хууль зүй, эрүүл мэндийн гэх мэт) эрэлхийлж, хүүхэд, залуучуудад ээлтэй шударга ёс, зөрчигдсөн эрхийг сэргээх арга хэмжээг үр дүнтэй олж авах.
- (iii) Хандлага: хүүхэд, залуучууд дараах зүйлийг харуулна.
- a Жендэрийн тэгш бус байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалт бүхий хэм хэмжээг шийдвэрлэх, түүнтэй тэмцэхэд итгэл төгс байх, эдгээрийг цаашид үргэлжлүүлэхгүй байхад өөрсдийн гүйцэтгэх үүрэг
 - b Ялангуяа хөвгүүд, эрэгтэйчүүдийн хувьд эерэг эрэгтэйлэг байдал;³⁰
 - c Жендэрийн тэгш байдал, олон талт байдлыг хүндэтгэх, нээлттэй байдал;
 - d Жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалтад өртсөн хүмүүсийн үзэл, амьдралын туршлагыг ойлгох чанар.

23. Хүүхэд, залуучуудад хүний эрхийн боловсрол олгох зохих арга зүй нь тэднийг хамтрагч гол түнш болгож, суралцагч төвтэй, оролцоотой, жендэрт нийцсэн, насны онцлогт тохирсон, хувьсан өөрчлөх, хүртээмжтэй байх шаардлагатай. Тэдгээр нь хүүхэд, залуучуудад хүний эрхийн зарчмуудыг өөрсдийн амьдрал, нөхцөл байдалдаа бодитоор хэрэгжүүлэх боломжийг олгох туршлага судлах, түүнчлэн үе тэнгийнхнээсээ суралцах нь сэтгэл хөдлөлийн холбоо, яриа хэлэлцүүлэг, харилцан ойлголцлыг бий болгодог тухай чухалчлан үзвэл зохино. Үе хоорондын болон соёл хоорондын эв нэгдлийг бэхжүүлэхэд чиглэсэн яриа хэлэлцүүлэг нь боловсролын эдгээр хүчин чармайлтыг дагалдаж байх ёстой. Спорт, гадуур суралцах, кино болон баримтат кино, урлаг, соёлын үйл ажиллагаа, тоглоом болон түүх ярилцах зэрэг боловсролын янз бүрийн арга, хэрэгсэл нь бүх төрлийн суралцагчдыг татан оролцуулж, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой.

24. Цахим технологи, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, жендэрийн тэгш байдалтай холбоотой сургах болон суралцах хэрэглэгдэхүүн, дэмжлэг болон бусад эх сурвалжууд нь соёлын холбогдох нөхцөл байдал, орон нутгийн онцлог, нийгмийн хөгжилтэй уялдсан хүний эрхийн зарчимд суурилсан байх бөгөөд ойлгомжтой тодорхой, шинжлэх ухааны хувьд үнэн зөв, шинэчлэгддэг, хүүхэд залуучуудад хамааралтай байх ёстой. Эдгээр нь аливаа ялгаварлан гадуурхалтгүйгээр бүх хүүхэд, залуучуудад хүртээмжтэй, оролцоог хангасан байх бөгөөд уугуул болон эх хэл зэрэг хэлний асуудал, түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг харгалзан үзэх шаардлагатай.³¹

³⁰ ЮНЕСКО, Эерэг эр хүн: эерэг эршүүд байдал ба хүйсийн тэгш байдлыг дэмжигч эрчүүд (2022 он).

³¹ Сургалтын материал, дэмжлэг болон бусад нөөцийн талаархи нэмэлт зөвлөмжүүдийг Хүний эрхийн зөвлөлийн баримт бичиг А/НRC/42/23-д туссан дөрөв дэх үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөний 29-р зүйлээс үзнэ үү.

С. Багшийн сургалт

25. Багш нарт зохих сургалтыг хангах стратеги нь одоо байгаа үйл ажиллагааны үнэлгээнд үндэслэсэн хүний эрхийн сургалтын цогц бодлого батлахыг тусгасан; хүний эрх болон хүний эрхийн боловсролын зарчим, стандарт, түүнчлэн хүүхэд, залуучуудын хүний эрхийн талаарх нөлөөллийн ур чадварыг сургалтын хөтөлбөрт нэвтрүүлэх; зохих арга зүй, үнэлгээний аргуудыг төлөвшүүлэх; холбогдох нөөцийг хөгжүүлэх; албан, албан бус, албан ёсны бус тохируулга түүнчлэн холбогдох оролцогч талууд, түүний дотор хүний эрхийн үндэсний байгууллагуудтай хамтран ажиллах. Эдгээр бүх үйл ажиллагааны явцад үе хоорондын суралцах үйл явц, багшийн туршлага, сайн сайхан байдал, ялангуяа гадуурхагдсан эсвэл эмзэг бүлгийн сургагч багш хүүхэд, залуучууд болон багшийг онцлон авч үзэж, хүндэтгэх шаардлагатай.

26. Багшид зориулсан хүний эрхийн сургалтын хөтөлбөрт дараах элементүүдийг тусгана:

- (a) Хүний эрх болон хүний эрхийн боловсролын талаарх мэдлэг, ур чадвар, хандлага, зан үйлийг багтаасан суралцахуйн зорилтууд;
- (b) Хүний эрхийн асуудлыг шийдвэрлэхэд багш, суралцагчдаас гадна хүний эрхийн зарчим, стандарт, хамгаалах механизмын талаар идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг нийгмийн бусад бүлгүүд, тэдгээрийн эрх, хувь нэмэр;
- (c) Жендэрийн тэгш байдлын асуудлууд, ялангуяа жендэрийн зан үйлийн сургах, суралцах үйл явцад үзүүлэх нөлөөлөл;
- (d) Суралцагчдын олон талт байдал, тэдний хэрэгцээ, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг харгалзан анги танхим болон боловсролын байгууллагын өргөн хүрээний олон нийтийн оролцоо, тэгш байдлыг хангах, бүх суралцагчдад айдас, ичгүүр, эрсдэлгүйгээр суралцах үйл явцад итгэлтэй оролцох боломж, нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг болохуйц, хүртээмжтэй, хамтын ажиллагааны орчин, соёлыг бий болгох арга замууд;
- (e) Оролцоонд суурилсан, суралцагч төвтэй, насны онцлогт тохирсон, жендэрт нийцсэн, туршлага болон үйл ажиллагаанд чиглэсэн, хүүхэд, залуучуудын оролцоог идэвхжүүлсэн хүний эрхийн боловсролын зохистой арга зүйн талаарх удирдамж;
- (f) Хүүхэд, залуучуудтай холбоотой хүний эрхийн тухайлсан асуудлууд;
- (g) Багшийн нийгэм, сэтгэл хөдлөлийн ур чадвар, соёл хоорондын болон шашин хоорондын яриа хэлэлцүүлгийн ур чадвар, ардчилсан бөгөөд хүний эрхийн зарчимд нийцсэн манлайллын хэв маяг;
- (h) Мэдээлэл, харилцаа холбооны технологи, цахим болон сошиал медиа зэрэг хүний эрхийн боловсролын сургах болон суралцах үйл ажиллагааны нөөцийн талаарх мэдээлэл, тэдгээрийг хянах болон тэдгээрийн дундаас сонгох, түүнчлэн шинэ нөөц боловсруулах чадавхыг бэхжүүлэх;
- (i) Хүний эрхийн боловсролыг багшийн зааж байгаа урлаг, хүмүүнлэгийн ухаан, карьер болон амьдралын ур чадвар, шинжлэх ухаан, технологи, инженерчлэл болон математик, хэл, биеийн тамир, нийгмийн шинжлэх ухаан, салбар хоорондын сургалтын агуулгад нэгдсэн жишээ;

- (j) Цахим болон цахим бус орчинд гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд, залуучуудыг олж тогтоох, зохих хариу арга хэмжээ авах, бэлгийн дарамт, хүчирхийлэл, дээрэлхэлт, цахим дээрэлхэлтийн тохиолдлуудад эрт үед нь хөндлөнгөөс оролцох, хохирогчийн эрх ашгийг төвд нь авч үзэх замаар сэтгэл зүйн гэмтлийг даван туулах, дахин сэтгэцийн гэмтэл авахаас зайлсхийх стратеги;
- (k) Багшийг янз бүрийн соёлын үндэс, итгэл үнэмшил, дадал зуршлыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэх болон өөрсдийн хэт нэг талыг барьсан, өрөөсгөл хандлагыг шийдвэрлэхэд бэлтгэх соёлын хариу үйлдэл;
- (l) Хүүхэд, залуучуудын тухайлсан ур чадварын албан ба албан бус хэлбэрийн тогтмол болон дэмжих суралцагчдын үнэлгээ
- (m) Хүүхэд, залуучуудын оролцоотойгоор хийсэн хэрэгцээний үнэлгээ дүн шинжилгээний үр дүнг боловсролын үйл ажиллагаанд нэгтгэх;
- (n) Сургалтын хөтөлбөрийг албан болон албан бус тохируулга, орон нутгийн нөхцөл байдал, хүн амын нөхцөлд нийцүүлэх;
- (o) Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд болон эрхийн талаарх мэдээллийг багтаасан бэлгийн цогц боловсрол;;
- (p) Хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцүүлэн, хүүхэд, залуучуудыг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, хувийн мэдээллийг нь зүй бусаар болон арилжааны зорилгоор ашиглах, бусад эрхийг нь зөрчихгүй байх үүднээс хүүхдийн болон өсвөр үеийнхний цахим технологийн хөгжилд үзүүлэх нөлөөллийн судалгааг харгалзан цахим төхөөрөмж, технологийг зохистой бөгөөд хүний эрхийг хүндэтгэсэн хэрэглээ зэрэг цахим ур чадвар болон ур дүй.

27. Багшид зориулсан сургалтын арга зүй нь оролцоон тулгуурласан, суралцагч төвтэй, хамтын буюу багийн ажиллагаа, туршлага, үйл ажиллагааны хандлагад үндэслэх бөгөөд сэдэлжүүлэлт, өөртөө итгэлтэй байдал, тунгаан бодохуй, хүний эрхийн мэдрэмж, үйл ажиллагаанд хөтлөх эргэцүүлэл, тусгалд анхаарна. Сургалтын үйл ажиллагааны туршид үнэлгээ хийх шаардлагатай.³² Онлайн платформууд нь суралцагч бие даан өөрийн хурдаар суралцах, сургалтын нөөцийг өөр хоорондоо хуваалцах, олж авсан мэдлэг, ур чадварыг өөр нөхцөл байдалд хэрэглэх, нөлөөллийн болон бусад эвсэл байгуулах бусад оролцогч талуудын мэдлэг болон цахим сургалтын хөтөлбөрийн боломжийг олгоно.

D. Боломж олгох орчин

28. Хүний эрхийн боловсрол албан, албан бус, чөлөөт орчинд явагдаж байгаа эсэхээс л хамааран, биет болон виртуал орон зайг хамарсан сургалтын орчин, гэр бүл (эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч болон гэр бүлийн бусад гишүүд) болон орон нутгийг багтаасан өргөн хүрээний суралцах орчин нь боловсролын үйл явцыг тодорхойлж байдаг.

³² Хүний эрхийн дээд комиссарын газар, Төлөвлөлтөөс нөлөөлөл хүртэл: Хүний эрхийн сургалтын арга зүйг зааварчилсан гарын авлага (2019 он) Ерөнхий Ассамблейн 78/187 тоот тогтоолын 10-р зүйл.

29. Хүний эрхийн сургах, суралцах үйл явц нь хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах сургалтын орчинд явагдаж байгаа эсэхийг баталгаажуулах нь чухал юм. Боловсролын зорилт, үйл ажиллагаа, боловсролын байгууллагын зохион байгуулалт нь хүний эрхийн үнэт зүйл, зарчимд нийцсэн байх ёстой. Үүний нэгэн адил боловсролын байгууллагын дотоод болон гадаад соёл, бүлгүүд нь эдгээр зарчмуудыг шингээн, бодитоор бэхжүүлэх чухал юм. Улс орнууд хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг зохион байгуулах, оролцохыг хөхиүлэн дэмжих арга хэмжээ авч, эрдэм шинжилгээний эрх чөлөөг баталгаажуулж, тэдгээрийн эсрэг зүй бус арга хэмжээ авахаас хамгаалах шаардлагатай. Хүүхэд, залуучуудын хүний эрхийг хамгаалалт, хэрэгжилтийг нэмэгдүүлэх арга хэмжээ нь хүүхэд, залуучуудад чиглэсэн хүний эрхийн боловсрол олгох хүчин чармайлтыг дагалдаж байх учиртай.

30. Хүний эрх ба цахим технологийн тухайд улс орнууд улс өөрийн улс дотор болон улс орнуудын хооронд цахим оролцоог сайжруулахад тулгарч буй бэрхшээл тухайлбал, жендэр, хөгжлийн бэрхшээл, насны цахим хуваагдал болон хөдөө орон нутаг, хот суурин газрын хүртээмжийн ялгаа зэргийг шийдвэрлэх шаардлагатай.³⁷ Бүхий л хүүхэд, залуучууд өөрт тохирсон, утга учиртай арга замаар цахим орчинд адил тэгш, үр дүнтэй нэвтрэх боломжийг хангах арга хэмжээг авах шаардлагатай. Найдвартай, оролцоог хангасан цахим сургалтын тогтолцоо болон орчныг хөгжүүлэх нь сургууль болон нийтийн номын сан зэрэг сургалтын бусад орчинд зохих дэд бүтцийг бий болгох явдал юм. Хүүхэд, залуучуудыг хамгаалах, тэдэнд хүртээмжтэй байдлыг хөнгөвчлөх арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд цахим орчныг хүүхдийн дээд ашиг сонирхол болон хөгжиж буй чадавхад нийцүүлэн тэдний нас, хөгжлийн үе шатыг харгалзан хүүхэд, залуучуудад ээлтэй байдлаар хүргэхэд чиглүүлнэ. Суралцагчид болон багшийн хувийн болон нууц мэдээллийг хамгаалах, хүүхэд, залуучуудыг цахим хүчирхийллээс хамгаалах талаар тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байна. Цахим үйлчилгээ үзүүлэгчид Бизнес ба хүний эрхийн Удирдах зарчмуудын дагуу хүний эрхэд учирч буй хохирлыг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор өөрсдийн хөгжүүлж буй технологийн бүхий л амьдралын мөчлөгт хүний эрхийн зохих магадлан шалгалтыг хийх ёстой. Түүнчлэн тэд хүүхэд, залуучуудтай идэвхтэй ажиллаж, хүүхэд, залуучуудын эрх, хүртээмжтэй байдлын хандлага, түүнчлэн зохих хамгаалалтыг хэрэгжүүлж, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхдээ тэдний санал бодлыг зохих ёсоор харгалзан үзэх ёстой. Түүнчлэн улс орнууд хүүхэд, залуучуудын хүний эрх, тэр дундаа үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван хуран цуглах эрхээ цахим орчинд хэрэгжүүлэхэд хууль ёсны, зайлшгүй шаардлагатай, тохирохоос бусад хязгаарлалт тавихгүй байхыг баталгаажуулах ёстой.³³

31. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн тухайд аюулгүй, эрүүл, тэсвэртэй дэд бүтэц нь үр дүнтэй суралцахад чухал ач холбогдолтой. Үүнд, зорчих болон сургуульд хүргэх тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангах; сургууль болон бусад сургалтын байгууламжууд нь бохирдол, үер, хөрсний гулсалт болон бусад байгаль орчны аюулын эх үүсвэр, түүний дотор тэсрэх болон дэлбэрээгүй бөмбөг, бусад аюултай бодисоор бохирдсон газруудаас аюулгүй зайд байрлах; хангалттай халаалт эсхүл хөргөлтийн системтэй, ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүрэлцээтэй барилга, хичээлийн анги танхимыг барих зэрэг хамаарна. Мөн тогтмол хяналт шалгалтаар дамжуулан боловсролын дэд бүтэц нь гамшгийн аюулд аюулгүй,

³³ Мөн адил, 14-р зүйл; болон Хүүхдийн эрхийн хороо, Ерөнхий тайлбар №26 (2023 он), 65-р зүйл.

тэсвэрлэх чадвартай эсэх, мөн суралцагч болон сурган хүмүүжүүлэгчдийг уур амьсгалын өөрчлөлт болон бусад байгалийн гамшгийн нөлөөллөөс хамгаалахад хангалттай нөөцийг зориулах нь чухал юм. Түүнчлэн Улс орнууд онцгой байдлын үед, тэр дундаа байгалийн гамшиг, уур амьсгалын бусад нөлөөллийн үед бага насны хүүхдийн боловсролоос эхлээд дунд болон дээд боловсрол хүртэлх бүх түвшинд, мөн онцгой байдлын янз бүрийн үе шатанд тасралтгүй, тогтвортой байх төлөвлөгөө, бүтцийг бий болгож, онцгой байдлын олон төрлийн үе шатанд гадуурхагдсан эсхүл эмзэг байдалд байгаа хүүхэд, залуучуудад онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Байгаль орчинд ээлтэй сургуулийн байгууламжууд, тухайлбал сэргээгдэх эрчим хүчний гэрэлтүүлэг, халаалт, хүнсний цэцэрлэгт хүрээлэн зэрэг нь суралцагчдад үр өгөөжтэй байж болно.³⁴

32. Жендэрийн тэгш байдлын тухайд бүхий л хүүхэд, залуучуудад эрх тэгш хандаж, тэдний чадавхыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх боловсролын орчныг бүрдүүлэх нь жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалтыг арилгахад хувь нэмэр оруулна.⁴⁰ Боловсрол нь хүүхэд болон залуу хүмүүст хууль зүйн болон практикийн хувьд хүртээмжтэй байх ёстой; тэдний сурч боловсрох эрхийг бүрэн, чөлөөтэй эдэлж, хэрэгжүүлэхийн тулд зохих нөхцөлийг бүрдүүлэх ёстой. Үүнд, хүүхэд, залуучуудыг аюулгүй хүртээмжтэй боловсролын байгууллагуудад нэвтрэх боломжийг олгох, үүний тулд боловсролын байгууллагууд газар зүйн тохиромжтой байршилд, эсвэл цахимд холбогдох зэрэг технологийн хэрэгслээр дамжуулан хүртээмжтэй байдлыг хангах асуудал аль аль нь хамаарна. Олон нийтийн газарт өргөн тархсан жендэрт суурилсан хүчирхийлэл болон сургууль руугаа явах, буцахдаа тулгардаг эрсдэлийг харгалзан сургуультайгаа ойр байх нь ялангуяа хөдөө орон нутагт маш чухал юм. Боловсролын байгууллагуудыг зохих дэд бүтцээр хангах асуудлыг анхаарч үзэх хэрэгтэй. Боловсролын хүрээнд бүх хүүхэд, залуучуудын эрхийг хангах нь тоо үзүүлэлтээр тэгш байдлыг хангахаас илүү өргөн хүрээг хамардаг. Энэ нь тэдэнд адил чанартай багш болон ая тухтай орчны тэгш хүртээмжтэй байдал, өөрийгөө тодорхойлох, өөрийгөө танин мэдэх зорилгодоо хүрэх боломжоор тодорхойлогддог орчин нөхцөлийг хангахыг шаарддаг; Шаардлагатай тохиолдолд боловсролын тодорхой чиглэлээр суралцагчдын тэгш бус хуваарилалт, ялангуяа шинжлэх ухаан, технологи, инженерийн болон математикийн боловсролыг нэгтгэх асуудлыг шийдвэрлэх шаардлагатай. Түүнчлэн улс орнууд бүхий л хүүхэд, залуучууд, ялангуяа эмэгтэйчүүд, охид, лесбиян, гей, бисексуал, трансжендэр, интерсекс хүмүүсийн эсрэг хүчирхийллийг бууруулах арга хэмжээ авч, боловсролын байгууллагууд дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, мэдээлэх, мөрдөн шалгах механизмыг тодорхойлж, асуудлыг шийдвэрлэхийн тулд төрийн хангалттай санхүүжилтээр хангах ёстой.

VI. Үндэсний хэрэгжилтийг хангах процесс

33. Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийцүүлэн хүүхэд, залуучуудын хүний эрхийн боловсролын талаар уялдаа холбоотой, зохион байгуулалттай үндэсний стратеги нь хэрэгцээг үнэлэх, стратеги боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих,

³⁴ Хүүхдийн эрхийн хороо, Ерөнхий тайлбар №26 (2023 он), 55-р зүйл. 40 Бээжингийн тунхаг ба Үйл ажиллагааны хөтөлбөр (1995) (Үйл ажиллагааны хөтөлбөрийн II хавсралтын 72-р зүйлийг үзнэ үү

үнэлэхэд дэмжлэг үзүүлэхийн тулд хангалттай хүний нөөц болон санхүүгийн нөөцийг хуваарилах талаар улс орнууд ихээхэн үүрэг амлалт хүлээхийг шаарддаг.

А. Оролцогчид болон зохицуулалт

34. Улс орнууд зохицуулах байгууллага байгуулах талаарх санаачилгыг чиглүүлэх, хариу арга хэмжээ авах, дэмжих үүргийг холбогдох яаманд даалгах, ингэхдээ тухайн улсын холбогдох төрийн байгууллага, иргэний нийгэм, хүүхэд залуучуудтай зөвлөлдөх шаардлагатай. Шинээр байгуулах, эсхүл одоо байгаа байгууллага дээр тулгуурлаж байгуулах байгууллага нь зохицуулалт, мэдээлэл солилцоо, нөөц болон тайлагналтыг нэмэгдүүлж, хүчин чармайлтын давхардлаас зайлсхийх баталгааг хангана. Улс орнууд нь холбогдох бүх талын оролцоог хангах боломжийг дэмжих үүрэгтэй бөгөөд зохицуулах байгууллагын гишүүд нь тухайн улсын хүүхэд залуучуудын хүн амын олон талт байдал, тэр дундаа гадуурхагдсан эсвэл эмзэг байдалд байгаа хүмүүсийг анхаарна.

35. Дараах үндэсний оролцогчдыг зохицуулах байгууллагад заавал оруулна.

- (a) Холбогдох яамд (боловсрол, хүүхэд, залуучууд, хууль зүй, мэдээлэл болон харилцаа холбооны технологи, байгаль орчин, эмэгтэйчүүд гэх мэт) болон холбогдох олон нутгийн байгууллагууд;
- (b) Үндэсний хүний эрхийн байгууллагууд;
- (c) Хүүхэд, залуучуудын төлөөлөл (хүүхэд залуучуудын тэргүүлсэн хөдөлгөөн болон байгууллага, сүлжээний зөвлөл, сайн дурын бүлгүүд);
- (d) Холбогдох иргэний нийгмийн байгууллагууд болон сүлжээд;
- (e) Боловсролын байгууллага, түүний дотор багш бэлтгэх байгууллага, эрдэм шинжилгээний хүрээлэнг, багш нарын холбоо, холбоодын төлөөлөгчид.

36. Бусад оролцогчдод нийгмийн үйлчилгээ үзүүлэгчид, орон нутгийн болон үндэсний хэвлэл мэдээллийн байгууллагууд, олон нийтийн болон шашны байгууллагын удирдагчид, уугуул иргэд, нийгмийн цөөнхүүд, сургуульд суурилсан эцэг эхийн хороо, эцэг эхийн холбоод, хувийн хэвшил, хандивлагчид, эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд, нийгмийн сүлжээний нөлөөлөгчид, соёлын байгууллагууд, уран бүтээлчид болон бусад холбогдох хүмүүс байж болно. Эдгээр оролцогчдыг хүүхэд залуучуудын хүний эрхийн боловсролыг дэмжих, хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцохыг дэмжих шаардлагатай.

37. НҮБ болон тус улсад байгаа засгийн газар хоорондын бусад байгууллагын төлөөлөгчид Зохицуулах байгууллагын хуралдаанд оролцож, зохих хүсэлтийн дагуу дэмжиж болно.

38. Зохицуулах байгууллага нь НҮБ-ын хүний эрхийн механизм, тухайлбал гэрээний байгууллагууд, тусгай журам, хүний эрхийн төлөв байдлын ээлжит тайлан болон ЮНЕСКО-гийн Энх тайвны боловсрол, Хүний эрх болон Тогтвортой байдлын талаарх зөвлөмжийн хүрээнд тайлагнах механизм, Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийг хянан үзэх механизм зэрэг олон улсын болон бүс нутгийн засгийн газар хоорондын санаачилгад өргөн мэдүүлэх улс орны тайланг боловсруулах үүрэг бүхий үндэсний агентлагууд, түүнчлэн бусад холбогдох аймаг, орон нутаг, дүүргийн албадтай

хамтран ажиллах бөгөөд энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд хүний эрхийн боловсролын ахиц дэвшлийг тэдгээр тайланд тусгана.

39. Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдуулан улс орнууд 2027 онд үндэсний дунд хугацааны ахиц дэвшлийн тайланг НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газарт (ХЭДКГ) хүргүүлнэ. ХЭДКГ нь хүлээн авсан мэдээллээ нэгтгэн Хүний эрхийн зөвлөлд хүргүүлнэ. 2030 оны эхэн гэхэд улс орнууд үндэсний үнэлгээний эцсийн тайлангаа ХЭДКГ-т хүргүүлэх бөгөөд эдгээрт үндэслэн тав дахь шатны хэрэгжилтийн талаарх эцсийн тайланг Зөвлөлд зориулан бэлтгэнэ.

В. Хэрэгжүүлэх үе шат

40. Зохицуулах байгууллага нь хүүхэд, залуучуудын хүний эрхийн боловсрол олгох үндэсний стратегийг үе хоорондын хамтын ажиллагааны хандлагад нийцүүлэн хэрэгцээ шаардлагын үнэлгээ, боловсруулалт, хэрэгжилт, мониторинг, үнэлгээ зэрэг үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хянах үүрэгтэй. Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн өмнөх үе шатуудаас олж авсан сайн туршлага, сургамжид үндэслэн улс орнууд доор дурдсан хэрэгжүүлэлтийн үе шат бүхий арга замыг авч үзэхийн хүсэж болох юм. Зохицуулах байгууллага байхгүй тохиолдолд уг арга барилыг холбогдох талууд хамтран хэрэгжүүлэх боломжтой.

41. Үндэсний стратегийн үе шат бүрд үндсэн түнш болох хүүхэд, залуучуудын оролцоо зайлшгүй чухал юм. Хүний эрхийн боловсролын асуудлаар хүүхэд, залуучуудын зөвлөлдөх хороо, ажлын хэсэг байгуулах зэргээр хүүхэд, залуучууд, тэр дундаа гадуурхагдсан, эмзэг байдалд байгаа хүмүүсийг оролцуулах боломжийг бүрдүүлж, бэхжүүлнэ. Тэд байнгын хамтрагч болох бөгөөд өөрсдийн хэтийн төлөвлөгөөг мэдээлэл цуглуулах уламжлалт бус аргуудыг ашиглан үндэсний санал асуулгыг хослуулах замаар илэрхийлэх боломжтой байх ёстой.

1 дүгээр үе шат – Хүүхэд залуучуудын хүний эрхийн боловсролын талаарх үндэсний суурь судалгаа

42. 1 дүгээр үе шат нь дараах үйл ажиллагаанаас бүрдэнэ:

- (a) Өргөн хүрээний зөвлөлдөх үйл ажиллагаанд тулгуурлан үндэсний үнэлгээний судалгаа хийх, баталгаажуулалт болон санал хүсэлтийг авах зорилгоор олон нийтэд түгээх. Уг судалгаа нь V хэсэгт (“Бүрэлдэхүүн хэсэг”) авч үзсэн одоогийн санаачилгууд, сайн туршлага, дутагдал, саад тотгор зэрэг дөрвөн чиглэлээр хүүхэд, залуучуудын хүний эрхийн боловсролын өнөөгийн үндэсний нөхцөл байдалд дүн шинжилгээ хийнэ.
- (b) V хэсэгт дурдсан дөрвөн бүрэлдэхүүн хэсгийн ямар арга хэмжээ аль хэдийн хэрэгжсэн, ямар хэмжээнд байгааг тодорхойлох;
- (c) Одоогийн санаачилга, сайн туршлага, сургамж дээр хэрхэн тулгуурлах, боломжуудыг хэрхэн ашиглах, дутагдал, саад бэрхшээлийг хэрхэн арилгах талаар авч үзэх.

43. 1 дүгээр үе шатнаас бий болох үр дүнд дараахыг хамруулна:

- (a) Хүүхэд, залуучуудын хүний эрхийн боловсролын талаарх үндэсний суурь судалгаа. Ингэхдээ гадуурхагдсан, эмзэг байдалд байгаа хүмүүсийн талаарх мэдээллийн бүрэлдэхүүн хэсгээр нь боловсруулсан өгөгдөл
- (b) Суурь судалгааны талаар үндэсний хэмжээнд явуулах кампанит ажил. Үр дүнг хүүхэд, залуучуудад хүртээмжтэй хэл, хэлбэрээр түгээхэд онцгой анхаарах шаардлагатай

2 дугаар үе шат – Хүүхэд, залуучуудын хүний эрхийн боловсролыг дэмжих үндэсний стратеги

44. 2 дугаар үе шат нь дараах үйл ажиллагаанаас бүрдэнэ:

- (a) Үндэсний суурь судалгаанд тулгуурлан одоогийн үйл ажиллагааны төлөвлөгөөг жишиг болгон ашиглан үндэсний стратегийн зорилтуудыг боловсруулах;
- (b) Нэн тулгамдсан хэрэгцээ ба/эсвэл байгаа боломжуудыг харгалзан суурь судалгааны үр дүнд тулгуурлан тэргүүлэх чиглэлүүдийг тогтоох, ялангуяа гадуурхагдсан, эмзэг байдалд байгаа хүүхэд, залуучуудын талаар тогтвортой өөрчлөлтийг хангах үр дүнтэй арга хэмжээнүүдэд анхаарлаа хандуулах;
- (c) Үндэсний стратегийг боловсруулахдаа дараах зүйлийг тодорхойлно:
 - (i) Нөөц бололцоо: шаардагдах хүний нөөц, санхүү, цаг хугацаа, технологийн нөөц;
 - (ii) Үйл ажиллагаа: гүйцэтгэх үүрэг, үүрэг хариуцлага, хамаарах цаг хугацаа, чухал үе;
 - (iii) Зохицуулах механизм;
 - (iv) Үр дүн (шинэ эсвэл шинэчлэн найруулсан хууль тогтоомж, боловсролын материал эсвэл сургалтын хөтөлбөр гэх мэт);
 - (v) Хүрэх үр дүн, холбогдох тоон болон чанарын үзүүлэлтүүд нь мониторинг болон үнэлгээний тогтолцооны үндсэн элемент болно.

45. 2 дугаар алхмаас гарах үр дүн нь хүүхэд залуучуудад хүртээмжтэй хэлээр боловсруулсан хүний эрхийн боловсрол олгох үндэсний стратеги бөгөөд үүнийг байгууллага, оролцогч талууд, ялангуяа хүүхэд залуучуудад өргөнөөр түгээх шаардлагатай

3 дугаар үе шат – Үндэсний стратегийн хэрэгжилт, мониторинг, үнэлгээ

46. 3 дугаар үе шат нь дараах үйл ажиллагааг хамруулсан байх шаардлагатай:

- (a) Төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- (b) Хэрэгжилтэд мониторинг хийх, үүнд холбогдох оролцогч талуудтай зөвлөлдөх, стратегид тусгагдсан шалгуур үзүүлэлтүүдийг шалгах, хэрэгжилтийг цаашид сайжруулах зорилгоор үнэлгээ хийх, сайн туршлагыг баримтжуулах;

(с) Стратегийг хэрэгжүүлэх явцад гарсан ахиц дэвшил, тулгамдсан асуудлын талаарх мэдээллийг олж тогтоох, түгээх..

47. Зохицуулах байгууллага нь үндэсний стратегийн хэрэгжилтийг хүүхэд, залуучуудтай хамтран үнэлж, үнэлгээний тайланг олон нийтэд нээлттэй болгож хүртээмжтэй байдлыг хангана. Үнэлгээ нь хүний эрхийн үнэт зүйлсийг тусгасан, хүртээмжтэй, ил тод байх ёстой; Эдгээр нь дээрх V хэсэгт (“Бүрэлдэхүүн хэсэг”) тодорхойлсон хүүхэд, залуучуудын хүний эрхийн боловсролын дөрвөн чиглэлийг хөндөж, хэрэгжүүлэх явцад олж авсан сургамжид тулгуурлан цаашид авах арга хэмжээний зөвлөмжийг багтаасан байх шаардлагатай.

48. 3 дугаар үе шатнаас гарах үр дүн нь үндэсний стратегийн тодорхойлсон үр дүнгийн болон үнэлгээний тайлан байна.

